



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан бүтээв.

Улаанбаатар хот

2024 он



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

.....
Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан эмхэтгэсэн товхимол

АГУУЛГА

Монгол, Унгарын хамтарсан “азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн түүх, соёлын харилцаа хамаарлын судалгаа төсөл”-ийн хээрийн судалгааны ажлын үр дүнгээс	6
Ар гүнтээс илэрсэн хүний ясны судалгаа	75
Монгол-Унгарын хамтарсан khi land хятаны ландшафт археологийн судалгаа 2023: үр дүн, төсөөлөл	89
Монгол орны зарим эмийн ургамлаас ялгасан эндофит мөөгөнцрийн бактерийн эсрэг идэвхийн судалгаа	107
Унгарын таркань сючь эрнюгийн судалгааны хүрээлэнгийн танилцуулга	114
Унгарын мэндчилгээний онцлог	116
Унгарын судлаач балинт габорын монгол нутгаар аялсан замыг тодруулах нь	121
Диосеги вилмош (1923–1972) болон Унгар-Монголын судалгааны хамтын ажиллагаа Сүхбаатар аймгийн нутаг дахь эртний тамга тэмдгийн судалгааны тойм	137

Эрхлэн гаргасан:

Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам

Эмхэтгэсэн:

Элчин сайдын Нарийн бичгийн дарга Г.Хишигбадам

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ажилтан М.Энхбаатар

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Т.Бат

ННА 63.4

ДАА 930.1

ISBN 978-9919-9372-1-8

Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд
Бүрэн эрхт Элчин сайд **ДР.ОБРУЩАНСКИЙ**
БОРБАЛА АННА



МЭНДЧИЛГЭЭ

Шинжлэх Ухааны Академийн эрхэм Ерөнхийлөгчөө, Хурлын төлөөлөгчдөө,

Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд маш их баярлалаа. Мөн Та бүхэнд Шинжлэх ухааны өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Унгарын Шинжлэх ухааны өдрөөр бид судалгааны үр дүнгүүдийг хэлэлцсэнээр Унгар-Монголын харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Дипломат харилцааны 73 жилийн түүхтэй манай хоёр орны Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа нэлээн эрт үеэс эхэлсэн гэж хэлж болно. Энэ нь дорнын гарал үүсэлтэй Унгарын ард түмэн гарал угсаагаараа холбоотой байж болох садан төрөл, тэдний хэл соёлыг сонирхох болсон тэр цагаас эхлэлтэй юм. Өнгөрсөн зуунд Унгарын судлаачид өвөг дээдсийнхээ ул мөрийг олохын тулд Кавказаас дорно зүгт монголчуудын амьдарч байсан нутаг болох Дундад болон Төв Ази руу олноороо зорчсон байдаг.

Дундад зууны сүүл XIX зуунд Унгарын Шинжлэх ухааны Академийн

удирдлага дорно дахины хэлний судалгаагаа баяжуулж, монгол хэлийг судлуулахаар нэгэн залуу судлаачийг илгээсэн: 1870 оны үед Балинт Габорыг Өргөө рүү монгол хэл, аялгууны шинжилгээ хийлгэхээр явуулсан ба тэрээр халимаг, монгол хэлийг судалжээ. Балинт Габор Төв Азид 155 хоногийг өнгөрүүлэхдээ олон сонирхолтой үг хэллэгийн цуглуулгатай болсноос гадна ижил утгатай 1200 орчим үгийг илрүүлж, хэлзүйн ижил төстэй байдлыг нь тодорхойлсон.

1877 онд Сичени Бела гүнгээр ахлуулсан эрдэм шинжилгээний экспедиц Өвөр Монгол болон Гансу-д очиж, түүхийн дурсгалуудыг судалсан. Харамсалтай нь энэхүү экспедицийн гишүүн Балинт Габор өвдсөний улмаас нутаг руугаа буцсан ч судлаач Лоци Лайош Говийн үүсэл гарлын талаар Байгалийн шинжлэх ухааны чухал нээлтийг хийсэн юм. Экспидиц Дунхуанд хүрч маш сонирхолтой судалгаануудыг хийсэн бөгөөд энэ нь сүүлд Унгарын судлаач Штейн Аурелын хийсэн судалгааны суурь нь болсон.

1897 онд Зичи Енөөгийн удирдсан эрдэм шинжилгээний экспедиц Монгол Улсаар дайран өнгөрөхдөө Өргөө буюу одоогийн Улаанбаатар хотын тухай маш олон түүхэн зургийг авч, хөдөөгүүр явж Байгалийн шинжлэх ухаан, биологийн судалгаануудыг хийсэн.

XX зууны эхний хагаст Лигети Лайош Хятад Улсад хамаарах Өвөр Монголд очиж Буддын сүм хийдүүдэд эрдэм шинжилгээний судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Унгар-Монгол хоёр улс 1950 онд Дипломат харилцаа тогтоож, 1957 онд Улаанбаатар болон Будапешт хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээсэн түүхтэй. Ийнхүү манай хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоосноор харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарыг хамран хөгжих үүд хаалга нээгдсэн юм. Үүний түүхчээлэх салбар нь мэдээж Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа юм.

Өдгөө манай Элчин сайдын яамнаас хоёр улсын Шинжлэх ухааны академи хоорондын уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг улам илүү өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд талууд археологи, археогенетик, түүх, хэлний түүх, угсаатны зүй болон бусад чиглэлээр хамтарсан судалгааны төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Энэ жил манай угсаатны зүйч Диосеги Вильмошын мэндэлсний 100 жилийн ой тохиож байгаа. Тэрээр 1960 онд судалгааны ажлаар Монголд ирснээр Унгарын угсаатны зүйг олон үнэт зүйл, гэрэл зургаар баяжуулж, ардын аман зохиолын цуглуулгатай болгожээ.

Бид цаашдаа олон олон судалгаа, шинжилгээний ажлуудыг хамтдаа хийж, хоёр орны шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлнэ гэж итгэж байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч, Академич ДҮГЭРИЙН РЭГДЭЛ



МЭНДЧИЛГЭЭ

Жил бүрийн 11 дүгээр сард тэмдэглэдэг Монгол Улсын Шинжлэх ухааны ажилтны өдрүүдтэй нэгэн дор “Монгол-Унгарын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа” ээлжит хурлаа зохион байгуулж буй Унгар Улсын Элчин сайдын яам, Эрхэм хүндэт Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хагагтай Др.Обруцанский Борбала Анна Танд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн нэрийн өмнөөс болон хувиасаа мэндчилгээ, талархлаа дэвшүүлж байна.

Манай хоёр улсын Шинжлэх ухааны академиуд хоорондын хамтын ажиллагаа урт удаан түүхтэй бөгөөд хамтран ажиллах анхны гэрээг 1960 онд байгуулж байсан бол 1995, 2007, 2014, 2021 онуудад шинэчлэн байгуулснаар хоёр академийн хамтын ажиллагаа улам өргөжин тэлж байна.

Хамтран ажиллаж байгаа он жилүүдэд хоёр орны судлаачид геологи, соёл, археологи, биологи, газарзүй болон бусад чиглэлээр цөөнгүй хамтарсан төсөл хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний олон арван бүтээл туурвисан байна. Үүний дотроос бидний угсаа гарвал нэгтэйг шинжлэх ухааны түвшинд батлах зорилготой археологийн салбарын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд

ихээхэн амжилт олж буйд туйлаас талархаж явдгаа энд онцлон тэмдэглэе.

Унгар Улсын Элчин сайдын санаачлагаар жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг энэхүү эрдэм шинжилгээний хурал дээр хоёр улсын судлаачдын хамтын судалгааны үр дүнг хэлэлцэж, олон нийтэд зөв мэдээлэл өгөхийн зэрэгцээ цаашид хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал, санаачлагыг дэвшүүлж ирсэн онцлогтой.

2023 онд хоёр улсын Шинжлэх ухааны Академи хооронд 2024-2026 онд хамтран хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалт зарлагдаж, төслүүдийг хүлээн авч шийдвэрлэх шатанд ирээд байна. Энэ удаад цөөнгүй тооны салбарын дундын болон шинэ салбарын төслийн саналууд ирсэн байгаа нь энэхүү арга хэмжээ үр дүнгээ өгч байгааг илтгэж байна. Тиймээс энэ хурлыг цаашид ч тасралтгүй зохион байгуулах нь бидний хамтын ажиллагаанд хөг нэмэх чухал ажил хэмээн үзэж байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэхийн ялдамд Монгол-Унгар хоёр улсын Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа улам өргөжин хөгжихийн ерөөл өргөө.

МОНГОЛ, УНГАРЫН ХАМТАРСАН “АЗИЙН ХҮННҮЧҮҮД БА ЕВРОПЫН ХҮННҮЧҮҮДИЙН ТҮҮХ, СОЁЛЫН ХАРИЛЦАА ХАМААРЛЫН СУДАЛГАА ТӨСӨЛ”-ИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

С.Энхболд, Э.Амарболд

(ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан)

Товчлол: Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн, Унгар Улсын Унгар судлалын хүрээлэн хамтран “Азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийг эхлүүлэн ажиллаж байна. Төслийн судалгааны баг Монгол Улсын Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны нутагт орших Ар гүнтийн хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газар 2022 онд хайгуул, малтлага судалгааг хийж гүйцэтгэсэн. Хайгуул судалгааны явцад нийт цагариг хэлбэрийн чулуун дарааст булш 41 байгааг илрүүлэн тогтоож, оршуулгын газрын дэвсгэр зургийг хийсэн. Тэдгээр булшнуудаас цагариг хэлбэрийн чулуун дарааст 7

булш сонгон малтлага судалгаа хийсэн. Малтан судалсан бүх булшнаас хүн, мал, нохой, буга зэрэг антропологи, палеозоологийн хэрэглэгдэхүүн олдсон. Эд өлгийн зүйлийн хувьд том хэмжээтэй цөгцөн ёроолтой төмөр тогоо, дашмагийн ясан амсар бөглөөний хамт, олон тооны ваар сав, хүрэл хонх, чулуун эдлэл, нумын ясан наалт, чий будагтай савны үлдэгдэл зэрэг илэрч олджээ. Малтлага судалгаагаар илэрсэн олдворуудын сэргээн засварлалт, он цаг тогтоох, генетикийн судалгаа зэрэг лабораторийн түвшний судалгаа үргэлжилж байна.

Түлхүүр үг: Ар гүнт, хүннү, цагариг хэлбэрийн чулуун дарааст булш, антропологи, палеозоологи.

THE RESULTS OF FIELD RESEARCH STUDY OF THE MONGOLIAN AND HUNGARIAN JOINT PROJECT “CORRELATION STUDY ON THE RELATIONSHIP BETWEEN ASIAN XIONGNU AND EUROPEAN XIONGNU”

Enkhbold.S¹, Amarbold.E¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences

Summary: The Institute of Archeology of the Academy of Sciences of Mongolia and the Institute of Hungarian Studies of Hungary have started a joint project “Correlation study on the relationship

between Asian Xiongnu and European Xiongnu”. The research team of the project completed the exploration and excavation of the Ar Gunt Xiongnu tomb and burial monument in the 19th khoroo of

Songinokhairkhan District, Ulaanbaatar, Mongolia, between June 27 and August 8, 2022. During the survey, 41 circular burials were discovered and a background map of the cemetery was made. Among those burials, 7 circular burials were selected and excavated. Anthropological and paleozoological tools of humans, animals, dogs, and deer were found in all surveyed burials.

As for the artefacts, a large iron cauldron, Bone brim of the flask (Dashmag) with stopper, numerous pottery vessels, bronze bells, stoneware, bow part of compound bow, and the remains lacquered wooden bowl were found. As a result of this joint research, the date of the above group of graves was set in detail.

Key words: Ar gunt, Xiongnu, circular burials, anthropology, paleozoology.

Оршил

Хүннү нар нь Төв азийн үржил шимт газрыг эрхшээлдээ авч Европ, Азийг холбосон гүүр болж байжээ. Сүүлийн үеийн судалгаагаар Евроазийн өргөн уудам нутгаас Хүннү нарт холбогдох 15 мянга гаруй булш, оршуулга илэрч мэдэгдээд байгаагийн дийлэнх нь буюу 13 мянга гаруй нь Монгол улсын нутагт [Эрэгзэн нар, 2022], үлдсэн хэсэг нь ОХУ-ын Буриадын Өвөр Байгал, БНХАУ-ын Өвөр Монголын Ордос зэрэг газарт бөөгнөрсөн байдалтай, Хөхнуур, Ганьсу, Шинжаан, Алтайн хязгаар, Тува, Дундад Азийн Долоон голын хөндий зэрэг газруудад цөөн тоотой тархсан нь тэмдэглэгджээ. Иймээс Хүннү судлал, Хүннүгийн археологийн судалгаа нь бүс нутаг, цаашлаад хүн төрөлхтний түүхийн судалгаанд багагүй орон зайг эзлэх нь дамжиггүй билээ.

Үүний дагуу 2022 онд Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Унгар Улсын Унгар судлалын хүрээлэн хамтран “Азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Ийнхүү Европ-Азийн соёл хоорондын уялдаа холбоог макро төвшинд судлах, Монгол, Унгар хоёр улсын археологийн судалгааны хөгжлийг харилцан дэмжиж Монгол улсын нутагт орших Хүннүгийн үеийн булшны бүтэц зохион байгуулалт, шинж чанарыг ойлгох, генетикийн судалгаа хийх зорилгоор 2022 онд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны нутаг Ар гүнтийн хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газар судалгаа хийсэн.

Хамтарсан судалгааны анги 2022 оны 6-р сарын 27-ноос 8-р сарын 08-ны хооронд хүннүгийн цагариг хэлбэрийн чулуун дарааст 7 булшинд малтлага судалгаа хийсэн (зураг-1).

Ар гүнтийн хүннүгийн булш оршуулгын дурсгалт газар

Монгол улсын Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг Ар гүнт хэмээх газар хүрэл зэвсгийн үеэс Монголын үед холбогдох 86 тооны дурсгал нийт 7 газар оршино. Эдгээрээс хамгийн олон булш бүхий газар бол Ар гүнтийн хүннүгийн булш оршуулгын дурсгал юм. Энэхүү дурсгалт газар нь Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны нутаг, Жаргалант уулын урд бие, Жаргалантын давааны баруун талд, хоёр талаараа жалга бүхий амны дунд, наранд эвэр бага зэрэг налуу энгэрт оршино. Уг дурсгалт газрын хөрс ерөнхийдөө тачир ургамлын бүрхүүлтэй, шимт хөрсний зузаан

дунджаар 10 см, түүний доор цайвар шаргал өнгийн шаварлаг хөрстэй болох нь малтлагын явцад мэдэгдсэн (зураг-2).

Дурсгалт газрын судлагдсан байдал

Дурсгалт газрыг анх 2016 онд Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн (хуучин нэрээр) эрдэм шинжилгээний ажилтан Н.Эрдэнэ-Очир, Б.Батдалай, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Соёлын өвийн байцаагч нарын бүрэлдэхүүнтэй баг Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалын бүртгэл, баримтжуулалтын ажлын хүрээнд нээн илрүүлсэн байдаг. Үүний дараагаар Монгол улсын ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн профессорын багийн судлаачид бүртгэн, баримтжуулж “Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх археологийн дурсгалууд” [Ванчигдаш Ч, нар. 2021. тал-321] бүтээлдээ хэвлүүлжээ.

Булшны байрлал, зохион байгуулалт

Ар гүнтийн Хүннүгийн булшнуудын газрын гадарга дээр ил гарсан дараас чулууны хэлбэр бүгд цагариг, дараас чулууны төв хэсэг чулуугүй, бага зэрэг ухагдсан мэт хонхойсон. Өнгөн хөрсөн дээр ил байрлах дараас чулууны голч жижиг нь 4.5 м, том нь 7 м голчтой (дараас чулууны хэмжээг хүснэгт 1-ээс харна уу).

Малтан судалсан 7 булшны 1, 2 дугаартай булш дурсгалт газрын төв хэсэгт хойноос урагш цуварсан байрлалтай байсан бол 3, 4-р булш зэрэгцээ, 5-р булш дурсгалт газрын

хамгийн хойд захад, 6-р булш хамгийн зүүн захад, 35-р булш хамгийн баруун урд захад байрлаж байсан.

Булшны нүх

Малтан судалсан булшнуудын оршуулгын нүх харилцан адилгүй гүнээс мэдэгдэж эхэлсэн ба 1-р булш 90 см, 2-р булш 70 см, 3-р булш 50 см, 4-р булш 60 см, 5-р булш 70 см, 6-р булш 60 см, 35-р булш 55 см-ээс тус тус илэрсэн (зураг-3-9).

Нийт булшны бүтэц нь дараас чулуу, чигжээс чулуу, оршуулгын хэсэг гэсэн 3 үеэс бүтэж байв. Дараас чулууны доороос булшны нүх илэрч, түүний дундаас чигжээс чулуунууд гарч байсан. Булшны нүхний төв хэсгийн чигжээс чулуунууд эвдэгдэж харин хөл болон толгой тал руугаа бөөгнөрсөн байдалтай үргэлжилж оршуулгын хэсэг хүрсэн. Өнгөн хөрснөөс авс хүртэлх чигжээс чулуунуудын дундаас хүн, малын яс, авсны модны хэсгүүд цөөнгүй тоогоор гарч байв. Илэрч олдсон олдворууд булшны нүхний төв хэсгээс буюу хар хүрэн өнгийн хөрсөн дундаас илэрч байсан нь тонуулчдын ул мөр гэдгийг тодорхой харуулж байв.

1, 2-р булшны оршуулгын нүхний ханыг тэгшлэн засаж 2 см зузаантай улаан зосоор өнгөлсөн байсан нь малтлагын явцад илэрсэн (зураг-10).

Малтан судалсан 7 дурсгалын 2, 3, 6-р булш хойлгын хөмөгтэй байсан ба хамгийн том нь 6-р булшных байв (зураг-17). Уг булшны хөмгөөс нийт 20 гаруй бод, 50 гаруй бог малын яс илэрсэн.

Хүснэгт 1. Ар гүнтийн Хүннү булшны бүтэц ба хэмжээ

Булшны дугаар	Дараасны голч (метр)	Чиглэл (Азимут)	Нүхний гүн, өнгөн хөрснөөс авс хүртэл (метр)	Оршуулгын нүхний хэмжээ(метр)	Өнгөн хөрснөөс шал хүртэлх гүн	Хойлгын хөмгийн хэмжээ (метр)
Булш 1	7	80	2.4	Урт 3.5, толгой талын өргөн: 1.8, хөл талын өргөн: 1.2	3.1	-
Булш 2	7	70	3.1	Урт 3.5, өргөн 1.5	3.6	Амсрын өргөн 0.8, гүн 0.7
Булш 3	4.5	12	2.1	Урт 2.9, өргөн 1.7	2.6	Амсрын өргөн 0.8, өндөр 0.7 м, гүн 0.2
Булш 4	6.5	10	2.7	Урт 3.2, өргөн 2.3	3.1	-
Булш 5	5.5	350	2.3	Урт 2.5, толгой талын өргөн 1.5, хөл талдаа 1.2	2.8	-
Булш 6	6	10	2.3	Урт 2.9, Толгой талдаа 1.7, хөл талдаа 1	3.8	Амсрын өндөр 1.2, хөмгийн дотор өндөр 1.8, гүн 1.2
Булш 35	6	5	2.9	урт 2.5, толгой талын өргөн 1 м, хөл талдаа 0.87 м,	3.3	-

Оршуулгын хэсгийн бүтэц

Малтан судалсан 7 булшны 1, 2-р булш дүнзэн бунхантай түүн дээрээ хөндлөн тавьсан зах банзаар хийсэн тагтай (зураг-11,12). Уг бунхант булшнууд оршуулга, тахилын, хойлгын гэсэн 3 хэсгээс бүрдэх бол 3, 4, 5, 6-р булшны авс нь оршуулга, тахилын гэсэн 2 тасалгаатай (зураг-13, 14, 15). Харин 35-р булшны авс ямар нэгэн тасалгаагүй, дээрээ уртааш нь тавьсан банзан тагтай байв (зураг-16).

Олдвор хэрэглэгдэхүүн

Малтан судалсан бүх булш тоногдож гадаад, дотоод зохион байгуулалт алдагдсан хэдий ч цөөнгүй тооны олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсоныг доор сийрүүлбэл,

1-р булшинаас бугын эвэр, адууны эрүү, модон эдлэлийн хугархай, нохойн яс, хүний гавал, төмөр эдлэлийн хугархай, чулуун эдлэл (зураг-18, 23).

2-р булшинаас нохойн бүтэн яс, дугуй

хэлбэрийн үйсэн эдлэл, хүн, малын яс, нумын ясан наалт, гичир, хээтэй хаш эдлэлийн хугархай, 2 ш цоолбор хээтэй төмөр арал, дэгээ хэлбэрийн металл эдлэл, үйсэн эдлэлийн үлдэгдэл, цөгцөн ёроолтой төмөр тогоо, чулуун хэлтэй хүрэл хонх, ширэн эдлэлийн хэсэг, сур болон даавуун эдлэлийн үлдэгдлүүд илэрсэн (зураг 19, 20, 21, 24, 25, 26).

3-р булинаас хүн, малын яс, шатсан модны хугархай, том, жижиг 4 ш ваар, ясан савхны хугархай, чий будагтай эдлэлийн үлдэгдэл, 2 ш сувс илэрсэн (зураг-22, 27, 32).

4-р булинаас хүн, малын яс, нумын наалт, төмөр эдлэлийн хэсгүүд, богийн ясаар хийсэн дашмагийн ясан бөглөөтэй амсар, ясан арал, дөрвөлжин хэлбэртэй голдоо нүхтэй жижиг ясан эдлэл (чимэглэл), голдоо нүхтэй бөөрөнхий ясан эдлэл, дугуй хэлбэрийн билүү

чулуу, чулуун зэвсэг (залтас), халбаган толгойтой ясан савх, сувс, чий будгийн хэсгүүд, төмрийн үлдэгдэл илэрсэн (зураг 28, 29).

5-р булинаас хүн малын яс, бугын эвэр, хүрэл толины хагархай хэсэг 2 ш, төмөр хутганы хугархай, ваарын хагархай илэрч олдсон.

6-р булинаас хүний яс, төмрийн хугархай хэсгүүд, төмөр эдлэлийн үлдэгдэл, жижиг хэмжээтэй төмөр цутгуурын шанага, дугуй хэлбэрийн модон эдлэл, үйсний хэсгүүд, ваарын хагархай, том хэмжээтэй бүтэн ваар, чулуун хэлтэй хүрэл хонх, тааран эдлэлийн тасархай зэрэг гарсан (зураг-30, 31, 33, 34).

35-р булинаас хүний яс (бүтэн) нумын гичир, нумын ясан наалт, төмөр эдлэлийн үлдэгдэл илэрсэн.

Хүснэгт 2. Булинаас илэрсэн хүний ясны мэдээлэл

Дурсгалын дугаар	Нас	Хүйс	Хүний ясны хадгалалт
ArG-1	+45	Эмэгтэй	80%
ArG-2	25-35	Эмэгтэй	95%
ArG-3	35-45	Эрэгтэй	75%
ArG-4	25-35	Эрэгтэй	65%
ArG-5	-17	Тодорхойгүй	
ArG-6	25-35	Эмэгтэй	
ArG-7	17-25	Эрэгтэй	

Урьдчилсан дүгнэлт

- Ар гүнтийн дурсгалт газар нарийвчилсан хайгуул хийж дэвсгэр зургийг үйлдсэнээр урьд тэмдэглэгдсэн байсан 19 тооны хүннү булш байна гэсэн мэдээг шинэчилж 41 булштай оршуулгын дурсгал байгааг тогтоосон.

- Малтан судалсан бүх булшнаас хүн, мал, нохой, буга зэрэг антропологи, палеозоологийн хэрэглэгдэхүүн олдсон. Нийт 1250 гаруй ширхэг яс илэрсэн бөгөөд тоо толгойгоор нь авч үзвэл хамгийн их нь 34 хонь, 20 ямаа, 14 үхэр, 9 адуу, 3 нохой, 3 бугын яс илэрч олдсон нь нарийвчилсан

лабораторийн түвшний судалгаа хийх боломжийг 100% олгосон.

- 1, 2-р булшны оршуулгын нүхний ханыг тэгшлэн засаж 2 см зузаантай улаан зосоор өнгөлсөн байсан нь Монголд анх удаа тэмдэглэгдэж байгаа юм.
- Олдвор хэрэглэгдэхүүний хувьд 2-р булшнаас олдсон цөгцөн ёроолтой төмөр тогоо, 4-р булшнаас илэрсэн дашмагийн ясан бөглөөтэй амсрыг онцгойлон нэрлэж болно. Дашмагийн амсар нь бог малын чөмгөний ясыг засаж урласан байх ба мөн адилхан ясыг засаж таглаа хийсэн байна. Үүнтэй ижил эдлэл Монголд одоохондоо илэрч тэмдэглэгдээгүй байна.
- Судалгаанд хамрагдсан 6 дугаарт булшнаас илэрсэн малын ясанд хийсэн он цаг тогтоох лабораторийн судалгаагаар НТӨ 120 – НТ 28 онд хамаарах болохыг тогтоосон.

Тус төслийн Ар гүнтийн дурсгалт газарт явуулсан малтлага судалгаагаар илэрсэн олдворын сэргээн засварлалт, он цаг тогтоох, генетикийн судалгаа зэрэг лабораторийн түвшний судалгаа үргэлжилж байна.

Ном зүй

Эрэгзэн.Г, Батболд.Н, Энхболд.С, Содномжамц.Б. Монгол нутаг дахь хүннүгийн археологийн дурсгалууд газрын зураг //Хүннүгийн эзэнт гүрний үеийн булш, оршуулгын дурсгалууд: Судалгаа хадгалалт хамгаалалт, сурталчилгаа төсөл. УБ, 2022.

Ванчигдаш.Ч, нар. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх археологийн дурсгалууд. УБ, 2020. тал-321.

Эрэгзэн Г, Энхболд.С, Мандах.Д, Амарболд.Э. Монгол, Унгарын хамтарсан “Азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс // Монголын археологи 2022. УБ, 2022. тал 79-84.

Эрэгзэн.Г, Энхболд.С, Мандах.Д, Амарболд.Э. Монгол, Унгарын хамтарсан “Азийн хүннүчүүд ба европын хүннүчүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс. УБ, 2022. АХГБСХ.

AMS Radiocarbon Dating Report. Ar Gunt Site, Belkh Site and Tuuliin Khar Tun Site (Mongolia). Institute of Accelerator Analysis Ltd. Kawasaki, 2023.


Хавсралт зураг



Зураг-1. Судалгааны ангийн бүрэлдэхүүн



Зураг-2. Ар гүнтийн хүннүгийн булшны байршил.



Гар зураг-1. Булины байрлал, зохион байгуулалт



Зураг-3 Ар гүнтийн хүннүгийн дурсгалт газрын бушины зохион байгуулалт




Зураг-4. Ар гүнтийн дурсгалт газарт байрлах 3, 4-р зэрэгцээ були



Зураг-5. Ар гүнтийн дурсгалт газарт байрлах 1, 2-р цувраа були



Зураг-6. 1-р булины оршуулгын нүх



Гар зураг-2. 1-р булины дэвсгэр зураг




Зураг-7. 2-р булины оршуулгын нүх



Гар зураг-3. 2-р булины дэвсгэр зураг




Зураг-8. 3-р булины оршуулгын нүх



Гар зураг-4. 3-р булины дэвсгэр зураг



Зураг-9. 4-р булины оршуулгын нүх



Гар зураг-5. 4-р булины дэвсгэр зураг



Зураг-10. 5-р булины оршуулгын нүх



Гар зураг-6. 5-р булины дэвсгэр зураг




Зураг-11. 6-р булины оршуулгын нүх



Гар зураг-7. 6-р булины дэвсгэр зураг



Зураг-12. 35-р булины оршуулгын нүх



Гар зураг-8. 35-р булины дэвсгэр зураг



Зураг-13. 1-р булины хананы зос



Зураг-14. 1-р булинаас илэрсэн бугын
эвэр



Зураг-15. 1-р булины оршуулга, тахилын
хэсэг



Зураг-16. 2-р булины оршуулга,
тахилын хэсэг



Зураг-17. 3-р булины оршуулга, тахилын хэсэг



Зураг-18. 4-р булинаас илэрсэн хүний оршуулга



Зураг-19. 5-р булинаас илэрсэн хүний оршуулга



Зураг-20. 6-р булины илэрсэн хүний оршуулга



Зураг-21. 35-р булины илэрсэн хүний оршуулга



Зураг-22. 6-р булины хөмөгний амсрын хэсэг, чигжээс чулуу



Зураг-23. 1-р булины авсны тахилын хэсэг



Зураг-24. 1-р булинаас илэрсэн хүн
малын яс



Зураг-25. 2-р булинаас илэрсэн бог бод
малын яс



Зураг-26. 2-р булинаас илэрсэн нохойн
яс



Зураг-27. 2-р булинаас олдсон цөгцөн
ёроолтой төмөр тогоо



Зураг-28. 3-р булинаас илэрсэн ваар,
бог малын яс



Зураг-29. 4-р булинаас илэрсэн дашмагийн
ясан амсар бөглөөний хамт



Зураг-30. 4-р булинаас илэрсэн
дашмагийн ясан амсар бөглөөний хамт



Зураг-31. 6-р булинаас илэрсэн цутгуурын
шанага



Зураг-32. 6-р булинаас илэрсэн
цутгуурын шанага



Зураг-33. 6-р булинаас илэрсэн хүрэл хонх



Зураг-34. 2-р булинаас илэрсэн хүрэл
хонх



*Зураг-35. 2-р булинаас олдсон цөгцөн ёроолтой төмөр тогоог
сэргээн засварласны дараа*


Хавсралт 2.

Table 1 Conventional radiocarbon age

Lab Number	Sample Code	Provenance	Material Type	Pretreatment	$\delta^{13}\text{C}$ (‰) (AMS)	Data with $\delta^{13}\text{C}$ Correction	
						Conventional ^{14}C Age (yrBP)	pMC (%)
IAAA-221082	No.1	Ar Gunt site (ArG-2022)	tooth	CoEx	-21.57 ± 0.41	2,040 ± 30	77.53 ± 0.25

Table 2 Radiocarbon age without $\delta^{13}\text{C}$ correction and calibrated age

Lab Number	Data without $\delta^{13}\text{C}$ Correction		Age for Calibration (yrBP)	Calibrated Age (1 σ)	Calibrated Age (2 σ)
	Age(yrBP)	pMC(%)			
IAAA-221082	1,990 ± 30	78.07±0.25	2,044±26	92calBC - 78calBC (9.9%) 54calBC - 9calAD (58.4%)	151calBC - 132calBC (2.8%) 120calBC - 28calAD (91.3%) 47calAD - 57calAD (1.3%)



АР ГҮНТИЙН (МОНГОЛ УЛС) МАЛТЛАГААС ОЛДСОН ХҮННҮГИЙН ҮЕИЙН ТӨМӨР ЦУТГАМАЛ ТОГООНЫ ОЛДВОРЫН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

Хэрцэг Жужана

(HUN-REN судалгааны хүрээлэнгийн Сэргээн засварлагч)

Хагархай төмөр цутгамал тогоог болгоомжтой савлаж боогоод 2023 оны 1-р сарын 6-ны өдөр сэргээн засварлах цехэд хүргэсэн. Олдворын тайлбарыг баримт бичгийн төгсгөл хэсгийн “Ажиглалт” гэсэн бүлгээс харж болно. Учир нь процессын эхэнд нэг ч параметрийг хэмжиж, тайлбарлах боломжгүй юм.

Сэргээн засварлахаас өмнөх тогооны нөхцөл байдал:

Тогооны хагарсан хэсгүүдийг боломжит байршлаар нь тэмдэглэж, хайрцаг, уутанд тус тусад нь хийсэн (зураг 1, 2, 3). Задлах үедээ хэсэг бүрийн зургийг хоёр талаас нь нэгбүрчлэн

авсан. Том, жижиг хагархай хэсгүүдийн алиныг нь ч гараар барихад амархан хугарч бутрахаар байсан. Том хэсгүүд хагарч, хэлбэрээ алдагдах магадлалтай учир бэхлэх шаардлагатай болсон.

Утсаар нааж тогтоосон нэг хэсэг байсан ба тэр нь тогоонд огт хамаарахгүй нь тодорхой байсан тул шинжилгээ хийлгэхээр хадгалсан. 90-110 ширхэг хагархай байсан бөгөөд зарим хэсэг нь бусад зузаан хагархайнаас салсан тул яг нарийн тоолох боломжгүй байв. Хагархай хэсгүүдийн гадаргуу нь: зэврээгүй, зэвээр бүрхэгдсэн гэсэн хоёр янз байсан. Булшнаас гаргахад тогоо нь зузаан зэв, шороогоор бүрхэгдсэн, бүрэн бүтэн мэт байсан ч хөдөлгөх үед энэхүү “бэхэлгээ” эвдэрч, задран унасан.



1-р зураг



2-р зураг



3-р зураг

Хагархайнуудын хоёр талд 0.5-2 см зузаан жижиг хайрга наалдсан, үндсэн гадаргуу дээр маш гүн, хатуу зэв тогтсон байсан. Бараг бүх хагархайн гадаргуу нь 2 давхаргатай, нэлээд газарт цэврүүтэх зэврэлтийн шинж тэмдэгтэй байв. Олон газар төмрийн зэврэлт нь шохой болон

карбонатын бохирдолтой холилдож, нэг талдаа хөө тортогны ул мөртэй байсан. (4-р зураг) Ногоон өнгөтэй, зэвэрсэн зэс ялтас 3 хэлтэрхийд наалдаастай байсан бөгөөд тэдгээр нь санамсаргүй зүйл байгаагүй бололтой. (5-р зураг)



4-р зураг



5-р зураг

Цэвэрлэгээ:

Цэвэрлэгээ эхлэхийн өмнө холбосон хэсгүүдийг дугуйлж зураад, ангилсан. Учир нь зэврэлтийг арилгах явцад цуурсан гадаргуу хагарах магадлалтай байсан. Гадаргуу нь цэвэрхэн болсон хэсгийг тэр даруйд нь нааж байсан.

Хэврэг, задрах магадлалтай учир усаар цэвэрлэгээ хийх боломжгүй нь тодорхой байсан. “Хөвөн” материалд чийг оруулвал хлоридын урвалын нөлөөгөөр муу үр дагаварт хүргэж болзошгүй.

Хагархай хэсгүүдийн зэврэлт нь үндсэн материалтай харьцуулахад хамаагүй хатуу байсан учир зэвийг арилгах ажил маш хүндрэлтэй, удаан явагдаж, зарим багаж техникээ солих мөн өмнө хийсэн ажлаа дахин давтан хийх тохиолдол ч гарч байсан. Арай нимгэн зэврэлттэй хэсэгт 2-3 мм-ийн өргөнтэй ган цүүц ашиглаж байсан ч энэ нь бүр нимгэн хэсгүүдэд хэт их хүнддэж байсан тул үргэлжлүүлэн нарийн

үзүүртэй, иртэй хутгаар цэвэрлэсэн.

Гадна болон дотор талын зэврэлтийн 60 орчим хувьд нь битүү цэврүүтэй нүхжилт үүсэж дотор талдаа чийг авсан учраас зэвийг арилгах шаардлага үүссэн (6-р зураг). Бусад хэсгүүдэд нэг л төрлийн зэврэлт байсан бөгөөд түүнийг тогоон дотроос арилгаагүй. Яагаад гэвэл энэ хэсгийн зузаан нь ердөө л 1-3 мм байсан болохоор хэрэв зэвийг арилгавал нимгэн цутгамал хэсэг ч бас “устаж” мэдэхээр байсан (7-р зураг). Дараа нь цэвэрлэсэн гадаргуугаа элсээр хэлбэржүүлж, перпендикуляр маягаар хадгалсан. Эс бөгөөс хагархай хэсэг нь агаарын даралтыг тэсвэрлэж чадахааргүй байсан. Үүний дараа дахин нарийн зүлгүүрээр зүлгүүрдэж, алмазан хошуутай цүүцээр хамгийн зузаан зэврэлттэй хэсгийг зэвгүй болтол нь нимгэлсэн. Ингэж өнгөлсний дараа тогооны гадаргуу дээр зүлгүүрийн мөр огт үлдээгүй. Дараа нь 500 микроны шилэн талст зүлгүүрээр дахин өнгөлсөн.



6-р зураг



7-р зураг

Хадгалалт:

Өнгөлгөө хийсний дараа олдворыг хадгалах газар нь чийг багатай байх ёстой. Ойролцоогоор 50°C хүртэл халаасан хэсгүүдийг спирттэй таннины хүчлийн уусмалаар идэвхгүйжүүлсний дараа гадаргууг нь арчаад, хэдэн цагийн турш 80°C хатаах шүүгээнд хадгалсан.

Цэвэрлэсний дараа ихэнх хэсгүүд нь 2 мм-ийн зузаантай болсон бөгөөд дотор талд нь үлдээсэн зэв нь илүү тогтвортой болгосон. Нөхцөл байдлыг үнэлж үзээд дараах шалтгаануудын улмаас чийглэж, дэвтээхээр шийдсэн:

1. Тусдаа хэсгүүд нь бэхжээгүй байв.
2. Хооронд нь сүвлэн холбож болохуйц хагархай гадаргуугаас наалт амархан салахаар байсан.
3. Тогоо нь овор томтой учраас гадны биетээр дахин нэмж бэхжүүлвэл үзэмжийг алдагдуулна.

4. Тохирох хэсгүүдийг хайж байх явцад олдворт гажилт үүсч, статик тогтворгүй болох нь тодорхой болсон.
5. Чийглэж дэвтээх нь зэврэлт үүсэх эрсдлийг эрс бууруулдаг.
6. Тогоо нь ерөнхийдөө урвуу нуман хэлбэртэй. Энэ нь хамгийн муу статик нөхцөл бөгөөд суурийн хэмжээ жижиг гэсэн үг.
7. Засвар хийхэд ашиглагддаг зэс нь чийглэг орчинд төмрийн зэврэлтийг хурдасгах магадлалтай бөгөөд чийглэж дэвтээх нь үүнээс сэргийлдэг.

Чийглэж дэвтээхэд хэрэглэгдэх давирхай нь гүн дэвтээхэд наалдамхай чанар багатай, өнгөгүй, удаан мууддаг, агшихгүй байх ёстой. Elan-tech EC 141 NF эпокси давирхай нь эдгээр нөхцөлийг хамгийн сайн хангасан (8-зураг). Ингэхдээ хамгийн жижиг хэсгүүдийг сонгож дэвтээсэн.



8-р зураг

Эвлүүлэх, наах:

Гадаргуугийн нэлээд хэсэг нь гэмтэж, бүрэн бус болсон тогооны хагархай хэсгүүдийн байршлыг олох нь хамгийн том ажил байсан. Үүний хажуугаар хэлбэр нь гажсан бүслүүрүүд ч төөрөгдүүлсэн. Ирмэг нь муруйгаараа бүрэн үлдсэн ч бас л гажсан байсан.

Наалт хийхдээ Gorilla2 хэмээх эпокси давирхайг ашигласан бөгөөд түүгээр жижиг цоорхойг бөглөсөн. Хагархайнуудыг эвлүүлэх үед гажсан хэлтэрхийнүүд нь гулсах, нарийн таарахгүй байх зэрэг бэрхшээлүүд гарч байсан. Эхлээд их биеийг нь эвлүүлэн нааж эхэлсэн. Яагаад гэвэл энэ нь хамгийн гол тулах цэг бөгөөд

наахын тулд тогоогоо доош нь харуулан хөмөрч тавих шаардлагатай болсон. Нэг бариулын чих нь тогооны үндсэн биетэй холбоотой тул түүнийг тулгуур хэвэнд оруулсан. Энэ үед гадаргуугын нэлээд хэсэг алга болсон нь тодорхой.

Хагарал цууралт бүрийг түр зуурын хөндлөн бэхэлгээ (хулсан саваа, халуун хайлмал цавуу) ашиглан зассан (9-10 дугаар зураг). Хамгийн сүүлчийн бэхэлгээг хийхдээ нүүрстөрөгчийн утаснуудыг цууралт үүссэн шугамд тэгш өнцөгт үүсгэн огтлолцсон байдлаар шигүү байрлуулан наасан. Зарим хэсэгт нь илүү зузаан шилэн эдийг наасан. Энэ нь тогооны ёроолд зайлшгүй шаардлагатай байсан. (11-р зураг)



9-р зураг



10-р зураг



11-р зураг

Нөхөлт, баталгаажуулалт:

Өнгөлгөөний явцад дунджаар 2 мм зузаантай болсон тогооны ханыг эпокси давирхайгаар (Free Form Sculpt) бэхлэх шаардлагатай байсан бөгөөд гадаргууг нь дотор талын зэврэлттэй төстэй хэлбэрт оруулсан.

Дутуу хэсгүүдийг нь мөн ижил синтетик давирхайгаар нөхсөн. Тухайлбал, нүүрэн талын эвдэрсэн гадаргуу дээр шилэн даавуу нааж, зуурах боломжтой синтетик давирхайг хоёр талд нь барьж, дотор хэсгийг нь шилэн даавуугаар бэхжүүлсэн. (Body Pro F250). (12, 13, 14-р зураг)



12-р зураг



13-р зураг



14-р зураг

Тогоог тогтвортой болгохын тулд гажсан их биеийг дотор талын ирмэгээс доош ойролцоогоор 3 см сунгасан бөгөөд доод талд нь шилэн цагираг нааж суурилуулсан (15-16-р зураг).



15-р зураг



16-р зураг

Ийнхүү тогооны доод хэсэгт хүрсэн бөгөөд тэндээс нэг ч хэлтэрхий олоогүй. Ингэх зуураа суурийг өрж нөхөж хийсэнтэй ижил гэмээр бэрхшээлтэй

тулгарсан. Тогооны их бие ба суурь хоёрын хооронд ямар ч холбоо байхгүй, зөвхөн 10-12 ширхэг “хөвөгч” хагархай л байсан. (17-18-19-20-р зураг).



17-р зураг



18-р зураг




19-р зураг



20-р зураг

Тэрхүү том онгорхойг нөхөхөд түр зуурын тогтвортой суурь шаардлагатай байсан бөгөөд үүнийг дараа нь тээвэрлэхэд ашиглаж ч болох байсан. Энд полиуретан хөөс тохиромжтой ч түүнийг тогоон дээр шууд нааж болохгүй учир улаан лоольтой синтетик давирхайтай бэхэлгээний боолтоор

сөргөө хийж, дараа нь тогооноос гаргаж аваад полиуретан шүршигчийг цацсан. Холбогч хөөс нь хэвэнд тохирохгүй суурийг зөв хэлбэрт оруулахад сайн байдаг. Энэ хоёрын хоорондох хоосон зайнд нь хэлбэрт яг таарахгүй байгаа хэсгүүдийг оруулсан (21-22-23-24-р зургууд).



21-р зураг



22-р зураг



23-р зураг



24-р зураг

Тогооны зөвхөн гадна талаас нь ажиллах боломжтой байсан. Яагаад гэвэл тогооны амсрыг доош харуулан хөмөрсөн байрлалтай байсан тул дотроос нь нөхөх боломжгүй. Ингэхийн

тулд тогоог эргүүлэх шаардлагатай байсан ч суурь нь олдворын нийт жинг даахгүй тул эргүүлэхдээ өмнө ашиглаж байсан боолт болон полиуретан хөөсийг хэрэглэсэн. (25, 26, 27-р зургууд)



25-р зураг



26-р зураг



27-р зураг

Нэмэлт будаг, гадаргууг хамгаалах:

Цагааннийлэг давирхайг температураар тогооны өнгөнд тохируулан будсан. Зэс хавтанг спиртийн бензтриазолын 3-4% уусмалаар идэвхгүйжүүлж, хуванцар 70 металл бүрэх шүршигчээр шүршээд, сүүлд нь тогооны гадаргууг бүхэлд нь микрокристалл лаваар бүрсэн.

Тогоог сэргээн засварлах үеийн ажиглалт:

Ажлын төгсгөлд тогооны хэмжээг тодорхой гаргах боломжтой болсон: өндөр нь 51см, амны диаметр нь 38-39см, бариулын чихний урт 5,5см, өргөн нь 19см, суурийн өндөр 9см, суурийн доод хэсгийн диаметр 14,5см, суурийн диаметр 12см, олдворын тойргийн дээд хэмжээ 40см, тойргийн доод хэмжээ 37см (тогооны гажилтын улмаас). (28, 29, 30, 31,32 дугаар зургууд)



28-р зураг



29-р зураг



30-р зураг



31-р зураг

Өмнө дурдсанчлан, цэвэрлэх явцад ихэнх хагархайнууд мурийж гажсан нь тодорхой болсон. Энэ нь наах үед нэлээд бэрхшээл учруулсан. Учир нь тогоо маш том онгорхой ан цав, цоорхойтой байсан ба тэр чигээр нь булшинд хийсэн нь тогтоогдсон. Ер нь тогоог булшинд хийхээс өмнө үүссэн эдгээр цоорхойг онгорхой орхих ёстой байсан ч энэ нь тогооны тогтвортой байдлыг алдагдуулах байсан тул цоорхойг нөхөж битүүлсэн. Тогооны нэг талд байсан хөө тортогтой хэсэг нь тогоог хажуу талаар нь гал түшүүлж байсныг илтгэнэ.

Тогооны суурь хэсгийн хажуу тал дээр хоёр ширхэг гурвалжин нүх, тэдгээрийн хооронд 3 давхар зураас байдаг (зураг 33). Давхар зураас нь тогооны гадна талын хүрээний доогуур гүйсэн маягтай ба түүний доод үзүүрээс доошоо чиглэн нийлсэн 4 хос зураасыг

харж болно. Тэдгээрийн дээд хэсэг нь тогооны бариулын доор болон дунд хэсэгт байрладаг. Бариулын дунд хэсэгт хавтгай байх бөгөөд энэ нь хоёр хэсэг бүхий хэвийг ашигласан болохыг нотолж байна (зураг 34). Цутгалтыг тогооны суурь хэсгээс дээш хийсэн ба цутгах хоолой нь суурь хэсгийн дотор, тогооны хажуу доор байрладаг. Бариулын нэг чихний дээд хэсэгт 3 хагарал үүссэн бөгөөд энэ нь хөлдөлтөөс үүссэн агшилтын үр дагавар байж болох юм.

Тогооны материалыг авч үзвэл хамгийн сонирхолтой нь, суурь хэсгийн дээгүүр, гадна талд нь 2 см орчим төмрийн өнгөтэй толбо ажиглагдсан. Үүнээс гадна тогооны гадаргуу тэр чигээрээ, түүний дотор эвдэрхий хэсэг нь хүртэл нь хар өнгөтэй байсан. (зураг 35).



32-р зураг



33-р зураг



34-р зураг



35-р зураг

Эвдэрхий хэсгийг олсон бөгөөд энэ нь аль эрт хагарсан байх магадлалтай юм.

Сав баглаа боодол, хүргэлт:

Цутгамал төмөр тогоог Монгол руу онгоцоор тээвэрлэх учир аль болох аюулгүй байдлыг хангасан савлагаа бэлтгэх шаардлага үүссэн. Нэг талыг нь нугалсан хайрцгийг 15см-ийн фанераар хийсэн. Төмрийг эсгийгээр бүрсэн

тулгуурыг тогооны суурь болгосон ба хайрцагны ёроолын булангаас татаж авах боломжтойгоор бэхэлсэн. Энэ нь хэн нэгэн хүн тогоог чихнээс татаж гаргах боломжгүй хэмээн үзсэн. Хайрцагны дотор талыг бүхэлд нь 5см зузаантай хөвөн даавуугаар доторлож, үлдсэн цоорхойг тугалган цаасаар гагнаж, хөвөнгийн хаягдлаар дүүргэсэн (зураг 36, 37).



36-р зураг



37-р зураг

Ашигласан материал, багаж хэрэгсэл:

500 микрон шилэн сувс, ган ир, корунд болон алмаазан толгойтой зүлгүүр, цүүц, нарийн зүлгүүр, 2мм мяндсан утас, 1мм карбон фибер, шилэн даавуу, ган хавтан, эсгий, хөвөн хавтан, хөвөн хаягдал, 15 м фанер, полиуретан хөөс, улаан лоолийн цутгамал боолт.

Elan-tech EC141 NF эпокси давирхай, Body pro F 250 полиэстр материалтай давирхай, Free Form Sculpt зуурах эпокси давирхай, Gorilla эпокси цавуу, 5% этанол таннины хүчлийн уусмал, Паралоид В 72 ацетон уусмал, Пластик 70 шүршигч, микрокристалл лав, бентриаз 4% этилийн спиртийн уусмал.



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

АР ГҮНТЭЭС ИЛЭРСЭН ХҮНИЙ ЯСНЫ СУДАЛГАА

Б.Мишээлт

*(ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан)*

Хураангуй. Монгол-Унгар хоёр улсын хамтарсан “Азийн хүннүүд ба европын хүннүүдийн харилцаа, хамаарлын судалгаа” төслийн хүрээнд 2022 онд Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 19-р хорооны нутаг Ар гүнтийн хүннүүгийн булш, оршуулгын дурсгалт газар цагариг хэлбэрт чулуун дарааст булшинд судалгаа хийсэн ба тэдгээрээс илэрсэн хүний ясны олдворын анхан шатны судалгааны үр дүнг энэхүү өгүүллээрээ нэгтгэн хүргэж байна.

Удиртгал

Эртний хүнийг шинжлэх палеоантропологиин салбар нь хүний ясанд хийх олон төрлийн хэмжилт судалгаагаар тухайн үеийн эртний хүний талаар олон төрлийн мэдээлэл цуглуулах боломжтой (Бямбадорж, 2020). Эртний хүний гавлын ясанд хийх краниологиин (гавал судлал) хэмжилтийн үр дүнд янз бүрийн түүхэн үеийн хүн амын антропологи төрхтний хэв шинж, хийгээд угсаа гарвалын хамаарлыг тодруулах зэрэг чухал ач холбогдолтой (Бямбадорж, 2020). Харин их биеийн ясан дээр хийгдэх остеологиин (яс судлал) хэмжилтээр нас, хүйс, бие бялдрын байдал, онцлог шинжийг тодорхойлж болно (Бямбадорж, 2020). Мөн их биеийн ясанд ажиглагдах өвчин эмгэг, бэртэл гэмтлийг судалснаар тухайн түүхэн үеийн амын эрүүл мэнд, аж ахуй, амьдрах орчин нөхцөлийг нэхэн

тодруулах боломжийг олгодог (Эрдэнэ, 2011). Мөн хүн ам зүй, хүн амын нүүдэл суудал болон бусад түүх, соёл, нийгэм, угсаа гарвал, генийн сан зэргийг судлах боломжийг олгодог (Наран, 2003; Эрдэнэ, 2011).

Материал ба арга зүй

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг Ар гүнт хэмээх газар Хүрэл зэвсгийн үеэс Монголын үе хүртэл нийт 7 газар 86 тооны дурсгал оршино. Эдгээрээс хамгийн олон дурсгал бүхий газар бол Ар гүнтийн хүннүүгийн дурсгал буюу Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны нутаг Жаргалант уулын урд бие, Жаргалантын давааны баруун талд, хоёр талаараа жалга бүхий амны дунд, бага зэрэг наранд ээвэр налуу энгэрт 41 тооны хүннүүгийн цагариг хэлбэрийн чулуун дарааст булш байгаагаас 7 булшийг сонгон малтан судалсан.

Ар гүнтийн дурсгалаас илэрсэн хүний ясны олдворууд харьцангуй сайн хадгалалттай ба ясны олдворын хүйсийг Buikstra and Ubelaker (1994) болон White and Folkens (2005) нарын арга зүйн дагуу мөн боловсруулсан аргуудын тусламжтайгаар тодорхойлсон. Энэхүү судалгааны хэрэглэгдэхүүнд сүүжний яс хадгалагдсан байгаа тул нас тодорхойлоход Todd (1921), умдгийн заадлын гадаргуун элэгдэл, Lovejoy et al. (1985) нарын чих маягийн гадаргуун

элэгдэл, Jesper L. Boldsen et al (2018) нарын боловсруулсан ТА-3 аргуудыг нас тодорхойлоход ашиглав.

Остеологийн хэмжилтийг Мартины аргын дагуу хийсэн. Өндрийг Pearson and Hasegawa нарын (2009) дунд чөмгөний хамгийн уртын хэмжээг ашиглан тооцоолон гаргав. Амны хөндийн өвчлөлийг үнэлэхдээ голчлон Лукакс (1989) болон Хилсон (1996) нарын шалгуурт тулгуурласан.

Үр дүн:

Булш-1

Хадгалалт: Ясны ерөнхий хадгалалтын байдал дунд (Зураг 1). Гавлын яс, эрүү, баруун эгэм, зүүн дал, зүүн богтос, шуу, хос дунд чөмөг, шилбэ, шуу, тахилзуур, зарим хавирга, багана нуруу, хөл гарын жижиг яснууд хадгалагдан үлджээ. Эрүүний зүүн 1,2-р бага араа, 2,3-р их араа унаж түүшин эдгэсэн. Баруун бага араанаас хойших бүх араа шүднүүд унаж түүшин эдгэсэн байдалтай байна.

Нас хүйс: Хөмсөгний нумын төвгөр сайн хөгжсөн, нүдний аяганы ирмэг мохой, дагзны төвгөр сайн хөгжсөн, эрүүний өнцөг хурц. Урт ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуу сайн хөгжсөн зэргээс үзэхэд эрэгтэй хүн бололтой.

Араа шүднүүд унаж түүшин эдгэсэн

байдалтай. Шилбэний ясны дээд үений гадаргуу, хүзүүний 1-р нугалам элэгдэж гөлийсөн байдалтай, нурууны нугалам нуруунууд ясжсан байна. ТА-3-ийн ахимаг насны шинжүүдийг өөртөө агуулж байна. Ойролцоогоор 55-63 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- Баруун шилбэний ясны дунд чөмөгтэй нийлэх дээд үений гадаргуу элэгдэж гөлийж, ясны ирмэгээр ясжилт үүссэн байна (Зураг 2). Насжилттай холбоотойгоор ийнхүү гөлийлсөн байна.
- Өвчүүний гол хэсэгт жижиг нүх байна. Удамшлын шалтгаантай төрөлхийн ийм шинж ажиглагддаг билээ (Зураг 3).
- Хүзүүний 4,5-р нугалмууд хоорондоо нийлж бэхжсэн байна. Ясны гадна ирмэгээр ясжилт үүссэн байна (Зураг 4).
- Зүүн талын тахилзуур ясны дээд бие хэсэгт бэртэл гэмтлийн ул мөр ажиглагдах ба урьд хугараад эдгэж бороолсон бололтой (Зураг 5).


Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөгний уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 162,5 см өндөртэй. Ясны бүрэн бус байдлаас шалтгаалан биеийн жинг тодорхойлох боломжгүй байна.



Зураг 1. Були-1 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 2. Баруун шилбэний ясны үений дээд гадаргуу



*Зураг 3. Өвчүүний ясны
харагдах байдал*



Зураг 4. Хүзүүний нугалмуудын нийлсэн байдал



Зураг 5. Шилбэний ясны дээд хэсэг

Булиш-2

Хадгалалт: Ясны хадгалалт сайн, ясны бүрэн бүтэн байдал муу байна (Зураг 6). Гавлын яс, эрүүний хугархай, зүүн сүүж, ууц, хос шилбэ, шуу, хөлийн зарим жижиг яснууд, хавирга, багана нурууны зарим нугалмууд хадгалагдан үлджээ. Хоншоорын шүднүүд унаж түүшин эдгэсэн байна.

Нас хүйс: Хөмсөгний нумын төвгөр сайн хөгжсөн, нүдний аяганы ирмэг мохоо, дагзны төвгөр сайн хөгжсөн. Урт ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуу сайн хөгжсөн зэргээс үзэхэд эрэгтэй хүн бололтой.

Шүднүүд унаж, түүшин эдгэсэн байдалтай. Нугалам нуруунууд ирмэгээрээ ясжсан байна. Ясны бүрэн бүтэн байдал хангалтгүйтэй холбоотойгоор нас тодорхойлоход хүндрэлтэй байна. Гэсэн хэдий ч ТА-3-ийн ахимаг насны шинжүүдийг өөртөө агуулж байна. Ойролцоогоор 53-56 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- Гавлын ясны хойно баруун зулайн хэсэгт нас барсны дараа гадны биетээс үүдэлтэй гэмтэл үүсчээ (Зураг 7).
- Зүүн шилбэ болон тахилзуур яснууд амьд ахуй үед хугарсан ба бороолох үед зөв эдгээж чадаагүйн улмаас буруу бороолсон байдалтай байна. Үүнийг pseudoarthrosis гэж нэрлэнэ (Зураг 8).
- Мөн зүүн хөлний жижиг яснууд, тахилзуур зэрэг яснууд хоорондоо нийлж, яс нь өнгө хувирч харласан байсан. Уг хүний биеийн зөөлөн эдүүд байх үед хөлний хэсэгт гал тавьж уг галын улмаас биеийн зөөлөн эдүүд шатаж яснуудыг хооронд нь нийлүүлж үлдээсэн байна (Зураг 9).

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 181,6 см өндөртэй. Ясны бүрэн бус байдлаас шалтгаалан биеийн жинг тодорхойлох боломжгүй байна.



Зураг 6. Булиш-2 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 7. Гавлын яс хойноосоо харагдах байдал



Зураг 8. (a) Зүүн шилбэ, тахилзуур ясны хугарлын байдал (b) Баруун эрүүл шилбэ, тахилзуур



Зураг 9. Хөлийн жижиг яснууд нийлсэн байдал

Булш-3

Хадгалалт: Ясны хадгалалт, бүрэн бүтэн байдал сайн (Зураг 10). Гавлын яс, эрүү, хос эгэм, дал, бугалга, богтос, шуу, хос сүүж, ууц, хос дунд чөмөг, шилбэ, тахилзуур, хөл гарын зарим жижиг яснууд, багана нурууны зарим нугалмууд хадгалагдан үлджээ. Хоншоор, эрүүний зарим шүднүүд гээгдсэн.

Нас хүйс: Хөмсөгний нумын төвгөр сул хөгжсөн, нүдний аяганы ирмэг хурц, дагзны төвгөр сул хөгжсөн. Урт ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуун сул хөгжсөн зэргээс үзэхэд эмэгтэй хүн бололтой.

Шүдний элэгдэл, умдаг ясны заадлын нийлэгжилт, чих маягийн гадаргуун

өөрчлөлт, ТА-3-ийн насжилтын шинжүүд зэргүүдийг харгалзан үзэхэд 36-39 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- L5-р нугалмын үений сэртэн салсан байдалтай байх ба энэ нь бүсэлхийн spondylolysis бололтой (Зураг 11).
- Ясан дээр нүдэнд ил мэдэгдэх эмгэг шинж ажиглагдсангүй.

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөг, шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 157 см өндөртэй. Их биеийн урт нь 74 см, хөлийн урт нь 83 см байна. Ясны бүрэн бус байдлаас шалтгаалан биеийн жинг тодорхойлох боломжгүй байна.



Зураг 10. Булш-3 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 11. Бүсэлхийн 5-р нугалам

Булш-4

Хадгалалт: Ясны хадгалалт, бүрэн бүтэн байдал сайн (Зураг 12). Эрүү, хос эгэм, дал, өвчүү, бугалга, богтос, шуу, хос сүүж, ууц, хос дунд чөмөг, шилбэ, тахилзуур, хөл гарын жижиг яснууд, зарим хавиргууд багана нурууны нугалмууд хадгалагдан үлджээ. Эрүүний үүдэн болон соёо шүднүүд гээгдсэн.

Нас хүйс: Урт мөчдийн ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуу сайн хөгжсөн, сүүжний суудлын сэртэнгийн өнцөг нарийн, сүүжний өнцөг бага байгаа зэрэг нь эрэгтэй хүн болохыг илтгэж байна.

Эрүү шүдний элэгдэл, умдаг ясны заадлын нийлэгжилт, чих

маягийн гадаргуун өөрчлөлт, ТА-3-ийн насжилтын шинжүүд зэргүүдийг харгалзан үзэхэд 26-35 орчим настай байсан бололтой.


Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- L5-р нугалмын үений сэртэн салсан байдалтай байх ба энэ нь бүсэлхийн spondylolysis бололтой (Зураг 13).
- Ясан дээр нүдэнд ил мэдэгдэх эмгэг шинж ажиглагдсангүй.

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөг, шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 170 см өндөртэй. Их биеийн урт нь 78 см, хөлийн урт нь 92 см байна.



Зураг 12. Булш-4 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 13. Бүсэлхийн 5-р нугалам

Булш-5

Хадгалалт: Ясны хадгалалт, бүрэн бүтэн байдал дунд (Зураг 14). Гавлын яс, эрүү, хос дал, өвчүү, бугалга, богтос, шуу, хос сүүж, хос дунд чөмөг, шилбэ, тахилзуур, хөл гарын жижиг яснууд, зарим хавиргууд багана нурууны нугалмууд хадгалагдан үлджээ.

Нас хүйс: Хөмсөгний нумын төвгөр сул хөгжсөн, нүдний аяганы ирмэг хурц, дагзны төвгөр сул хөгжсөн. Урт ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуун сул хөгжсөн, сүүжний

суудлын сэртэнгийн өнцөг нарийн, сүүжний өнцөг бага байгаа зэргээс үзэхэд эмэгтэй хүн бололтой.


Эрүү шүдний элэгдэл, умдаг ясны заадлын нийлэгжилт, чих маягийн гадаргуун өөрчлөлт, ТА-3-ийн насжилтын шинжүүд зэргүүдийг харгалзан үзэхэд 40-46 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- Хоншоорын 1,2-р бага араа эрүүний 2-р бага араа, 1-р их араанд буглаа үүсч байсан байна (Зураг 15).

- Зүүн дунд чөмөгний толгой остеоцит үүссэн байна. Энэ нь остеоартритын шинж юм. (Зураг 16)
- Шилбэний ясны дунд чөмөгтэй нийлэх үений гадаргуу, дунд чөмөгний доод булууны үений гадаргуу элэгдэж гөлийсөн (Зураг 17).

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөг, шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 151 см өндөртэй. Их биеийн урт нь 78 см, хөлийн урт нь 92 см байна. 54,5 кг жинтэй байжээ.



Зураг 14. Були-5 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 15. Хоншоор болон эрүүний шүднүүдийн бугласан байдал.



Зураг 16. Баруун дунд чөмөгний толгой



Зураг 17. Дунд чөмөг болон шилбэний
үений гадаргуу

Булш-6

Хадгалалт: Ясны хадгалалт сайн, бүрэн бүтэн байдал дунд (Зураг 18). Эрүү, баруун дал, зүүн эгэм, хос дунд чөмөг, шилбэ, тахилзуур, хөл гарын жижиг яснууд, зарим хавиргууд, зарим багана нурууны нугалмууд хадгалагдан үлджээ. Эрүүний зарим шүднүүд гээгдсэн.

Нас хүйс: Урт мөчдийн ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуу сайн хөгжсөн, сүүжний суудлын сэртэнгийн өнцөг нарийн, сүүжний өнцөг бага байгаа зэрэг нь эрэгтэй хүн болохыг илтгэж байна.


Эрүү шүдний элэгдэл, чих маягийн гадаргуун өөрчлөлт, ТА-3-ийн насжилтын шинжүүд зэргүүдийг

харгалзан үзэхэд 66-70 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- Эрүүний зүүн 2-р үүдэн бугалсан буглаа үүүссэн байна (Зураг 19).
- Эрүүний зүүн 2-р бага араа унаж түүшин эдгэсэн байдалтай (Зураг 19).
- Мөн торус мандибуларис илэрч байна (Зураг 19).

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөг, шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 160 см өндөртэй. Их биеийн урт нь 78 см, хөлийн урт нь 82 см байна.



Зураг 18. Булш-6 хүний яс анатомийн байрлалаар



Зураг 19. Эрүү шүдний буглаа болон араа шүд унасан байдал

Булш-7

Хадгалалт: Ясны хадгалалт, бүрэн бүтэн байдал сайн (Зураг 20). Гавлын яс, эрүү, хос эгэм, дал, бугалга, баруун богтос, шуу, хос сүүж, ууц, хос дунд чөмөг, шилбэ, тахилзуур, хөл гарын

зарим жижиг яснууд, багана нурууны зарим нугалмууд хадгалагдан үлджээ. Хоншоор, эрүүний зарим шүднүүд гээгдсэн.

Нас хүйс: Хөмсөгний нумын төвгөр сайн хөгжсөн, нүдний аяганы ирмэг

мохоо, дагзны төвгөр сайн хөгжсөн. Урт мөчдийн ясны бахим байдал, булчин бэхлэгдэх гадаргуу сайн хөгжсөн, сүүжний суудлын сэртэнгийн өнцөг нарийн, сүүжний өнцөг бага байгаа зэрэг нь эрэгтэй хүн болохыг илтгэж байна.

Шүдний элэгдэл, чих маягийн гадаргуун өөрчлөлт, ТА-3-ийн насжилтын шинжүүд зэргүүдийг харгалзан үзэхэд 55-57 орчим настай байсан бололтой.

Ажиглалтаар илэрсэн зүйлс:

- Нурууны нугалмын их биеийн

ирмэгээр остеоцит үүссэн байна. Энэ нь насжилтын нөлөөтэй ажиглагдаж буй зүйл ажээ.

- Өөрөөр ясан дээр ажиглагдах ясны өөрчлөлт, бэртэл гэмтлийн ул мөр мэдэгдсэнгүй.

Морфометрийн хэмжилтийн үр дүн: Биеийн өндрийг дунд чөмөг, шилбэний ясны уртын хэмжээнд тулгуурлан томьёонд оруулан тооцоход 164 см өндөртэй. Их биеийн урт нь 77 см, хөлийн урт нь 87 см байна.



Зураг 20. Були-7 хүний яс анатомийн байрлалаар

Дүгнэлт: Нийт илэрсэн 7 олдворын 5 нь эрэгтэй, 2 эмэгтэй хүний олдвор илэрчээ. Эрчүүдийн дундаж өндөр 167,5 байгаа бол эмэгтэйчүүдийнх 154 см байна. Насны бүлгийн хувьд 20-34 насны буюу залуу насны хүмүүс нийт олдворын 1 буюу 14 хувийг, 35-

49 насны буюу идэр насны 2 буюу 29 хувийг, дийлэнх буюу 57 хувийг буюу 4 хүн тус тус эзэлж байна.

Эдгээрээс дүгнэхэд Ар гүнтийн оршуулгын газраас илэрсэн дийлэнх хүмүүс цаг хугацааны аясаар нас барсан байж болох юм. Ихэнх өвчин эмгэгийн

шинжүүд насжилттай холбоотойгоор бий болсон байх ба бэртэл гэмтлийн ул мөр ажиглагдаж байгаа ч эдгэсэн зэргээс үзвэл өвчин эмгэгт ямар нэгэн эмчилгээ хийдэг байсан байж болох юм.

Ном зүй

Наран, Б. (2003). Баруун Монголын эртний нүүдэлчдийн өвчлөлт.

Эрдэнэ, М. (2011). Палеопатологии Хунну Центральной Монголии. Древние Культуры Монголии и Байкальской Сибири, 4, 398–403

Auerbach B. and Ruff C. (2004) Human body mass estimation: a comparison of “morphometric” and “mechanical” methods. *American Journal of Physical Anthropology*, 125: 331–342.

Buckberry J.L. and Chamberlain A.T. (2002) Age estimation from the auricular surface of the ilium: a revised method. *American Journal of Physical Anthropology*, 119: 231–239.

Buikstra J.E., Ubelaker D.H. (1994) Standards for data collection from human skeletal remains. *Arkansas Archaeological Survey*, Fayetteville.

Hillson S.W. (1996) *Dental Anthropology*. Cambridge University Press, Cambridge.

Lovejoy C.O., Meindl R.S., Pryzbeck T.R., Mensforth R.P. (1985) Chronological metamorphosis of the auricular surface of the ilium: A new method for the determination of adult skeletal age at death. *American Journal of Physical Anthropology*, 68: 15–28.

Lukacs J.R. (1989) Dental paleopathology: methods for reconstructing dietary patterns. In: Iscan, M.Y., Kennedy, K.A.R. (eds.), *Reconstruction of Life from the Skeleton*. Alan R. Liss, Inc, New York, pp. 261–286.

Ortner D. (2003). *Identification of Pathological Conditions in Human Skeletal Remains*, second ed.

Smith B.H. (1991) Standards of human tooth formation and dental age assessment. In: Kelley M.A. and Larsen C.S. (eds.), *Advances in Dental Anthropology*. Wiley-Liss, New York, pp. 143–168.

Todd T.W. (1920) Age changes in the pubic bone: 1. The male white pubis. *American Journal of Physical Anthropology*, 3: 285–334.

Walker P.L. (2005) Greater sciatic notch morphology: sex, age and population differences. *American Journal of Physical Anthropology*, 127: 385–391.

White T.D. and Folkens P.A. (2005) *The human bone manual*. Academic Press, Cambridge

МОНГОЛ-УНГАРЫН ХАМТАРСАН KHI LAND ХЯТАНЫ ЛАНДШАФТ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА 2023: ҮР ДҮН, ТӨСӨӨЛӨЛ

Л.Эрдэнэболд

*(ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний
ахлах ажилтан, ШУТИС-ийн багш)*

Ж.Силади Жолт

(HUN-REN судалгааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан)

Э.Уртнасан

(ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан)

Өмнөтгөл

Монгол-Унгар улсын судлаачдын хамтарсан Хятаны археологийн судалгаа төслийг Унгарын Шинжлэх ухааны академийн Хүмүүнлэгийн судалгааны төвийн Угсаатны зүйн хүрээлэн, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн хамтран “Монгол-Унгарын хамтарсан судалгаа-Монгол дахь Хятаны археологийн судалгаа 2017-2023” нэртэйгээр хэрэгжүүлж байгаа билээ. Эл төсөл нь хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжиж байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол улсын төв хэсэг Булган, Төв аймгийн нутаг дахь Хятан улсын үеийн цэргийн бэхлэлт хотууд, тэдгээрийн дагуул газар тариалан, гар урчуудын суурингуудад агаарын зураглал болон ландшафт археологийн судалгаа хийх ажил багтсан юм.

Энэхүү хамтарсан төслийн Монголын талын хээрийн судалгааны ангийн ахлах судлаачаар археологич, профессор Л.Эрдэнэболд, судлаач Э.Уртнасан ажилласан бол Унгар улсын талаас археологич, профессор József Laszlovszky, угсаатны зүйч, доктор

Zsolt Szilágyi, археологич доктор Csilla Siklód, газар зүйч András Harmath нар болон геофизикийн судалгааны баг оролцон ажилласан болно.

Хятаны археологийн судалгаа төсөл нь Хятаны түүхэнд холбогдох дурсгалт газрууд, тэдгээрийн орчмын газар нутгийг тандан судлаж, Ляо гүрний нийгэм, улс төрийн зохион байгуулалт, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг танин мэдэх зорилготой.

Хэдийгээр Монгол дахь Хятаны үеийн хот суурингуудын нэлээдэд нь түүх, археологийн судалгаа хэдийнэ хийгдсэн боловч тэдгээр дурсгалын ойр орчим хийгээд орчин үеийн суурингуудтай хэрхэн холбогдож байгаа талаар нарийвчилсан судалгаа одоогоор үгүй. Бид энэхүү төслийн хүрээнд Хятаны үеийн дурсгалт газруудыг судалж, эзэнт гүрний умард хязгаарын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.

Ингэхдээ орчин үед ихээхэн үр дүнтэй ашиглагдаж байгаа Ландшафтын археологийн зарчимд тулгуурлан, зайнаас тандан судлах шинэ технологи ашиглаж байгаагаар бидний судалгааны арга зүй онцлогтой. Хэдийгээр төсөл маань Хятаны үеийн судалгаа боловч

тухайн дурсгалт газар нутгуудтай холбоотой түүхэн бусад үеүдийн археологийн дурсгалуудыг цогцоор нь судлахад чиглэж байна. Чингэхдээ хүрлийн үеэс өнөөг хүртэл бүхий л цаг хугацааны тухай хүүрнэх түүхэн дурсгалуудыг илрүүлэн судлахыг зорьж байна.

Бид дурсгалт газруудыг ойр тойрны хүрээлэн буй орчин, уул, ус, байгальтай нь холбогдох байдлыг судлах зэргээр ландшафтын археологийн аргачлалаар судалгаагаа явуулж байна. Ингэхдээ тухайн бүс нутгийн гол мөрөн, нуур зэрэг усан хангамжийн системийн онцлог, мөн микро топографийн системтэй судалгаагаар тогтоож болох орчны дурсгалт газруудад (эртний хот суурингийн туурь, булш хиргисүүр, янз бүрийн ердийн хөшөө чулуу гэх мэт) онцгой анхаарч ажиллаж байна.

Хамтарсан төслийн хүрээнд 2022 онд Хүннүгийн үеийн Зүрхийн үзүүр, Хятаны үеийн Хар бухын балгас, Улаан хэрэм, Хар бухын чулуун барилгууд болон Цогт тайжийн Цагаан байшин, Хэрлэн барс хот зэрэг дурсгалт газруудад түүх, археологийн судалгааг явуулсан билээ.

Харин 2023 оны хэрийн судалгаагаар Хар бух балгасны дагуул суурингууд болох Шавартайн голын хэрэм, Цагаан үзүүрийн хэрэм 1, 2, 3, Өрхтэйн балгас, Чин толгой хотын дагуул суурингууд болох Өндөр дэнжийн балгас, Сүүжийн голын хэрэм 1, 2, Улаан хэрмийн дагуул суурингууд болох Мөөрсийн голын хэрэм, Дэрсэн хэрэм 3, 4, Шар талын хэрэм, Хэрмэн дэнж балгасны дагуул суурин болох Бэлхийн балгас 1, 2, Цагаан дэнжийн балгас 1, 2, Хангай

уулын арын балгас зэрэг 20 шахам эртний балгасуудад тандалт судалгааны ажил гүйцэтгэв.

Зүүн хойт Азид X-XII зууны эхэн үед оршин тогтнож асан Хятан улс нь өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байсан хүн амыг өөрийн улс төрийн хараа хяналтдаа барьж байв. Тэд өөрийн улсаас болон зүүн хойд Хятадаас олон мянган цэрэг, энгийн иргэдийг дайчлан татаад, тэдгээрийг монгол нутагт нүүлгэн авчраад суулгасан байжээ. Тэдгээр цэргүүд нь Хятаны улс төрийн дэглэмийг эсэргүүцсэн монголчуудын бослого хөдөлгөөнөөс сэргийлэх, дарангуйлан дарах үүрэг хүлээжээ. Тэр үед монгол нутагт байсан Хятаны цэргүүд Орхон, Хэрлэн, Туул голын ай сав, тэдгээр голуудад цутгадаг жижиг голуудын хөндийгөөр голлон суурьшаад, монголчуудын хөдөлгөөнийг хянаж байв.

Түүхэн сурвалжид тэмдэглэсэнээр Хятан нар анх 924 оны орчим Туул гол орчмын нутгийг эзэгнэсэн мэдээ бий. Тухайлбал, 924 онд Хятан улсыг үндэслэгч, цэргийн жанжин Елюй Абаоци тухуней, дансян, зу-бу нарын газар нутгийг дайлж, Хуйху (уйгур) нарын нийслэл хотыг дайлсан тухай өгүүлсэн байдаг¹. Энэхүү Хуйху буюу Уйгурын хаант улсын нийслэл хот нь Орхон голын хөвөөнд байсан Орду балык хот болох нь тодорхой юм. Үүнээс 70 жилийн дараа Ляо улсын хаан Шэн зун өөрийн эзэнт улсын баруун хойт хил хязгаарыг сахин тохинуулахад ихээхэн хүч тавин чармайж баруун хойт талын Зү бү олон аймгийг дарангуйлах зорилгоор бүхэл бүтэн цэргийн хотын

¹ Н.Н.Крадин ба бусад. Хятанрэм. Чингисийн далангийн зүүн хойт хэсгийн судалгаа. УБ., 2020. Тал 28.

сүлжээг байгуулсан байдаг.

Энэ үеэс хятанчууд хил хязгаараа бэхжүүлж эхэлсэн байна. 994 онд Шэн зун хааны үеэл Хулянь гэгч Зүбү нар руу довтолж уйгурын хуучин цайз байсан газар хотыг сэргээн босгожээ. 10 жилийн дараа энэ нутагт өөр бас гурван хот барьж, хоёр түмэн хятан цэрэг илгээжээ². Үүнээс гадна, Хэрлэнд Зүүн хэрэм, Баруун хэрэм гэсэн хоёр бэхлэлтийг барьжээ³. Эдгээр бэхлэлт хотуудын тухай хятад эх сурвалжид дурдсан байдаг. Тэдгээр нь янз бүрийн хэмжээтэй байдаг нь тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээнээс хамаардаг байсан бололтой.

Ийнхүү дарангуй цэргүүд болон тэднийг дагалдан ирсэн энгийн иргэд нь Монгол нутагт цөөнгүй тооны хот, цэргийн бэхлэлт, тариа ногооны түр зуурын сууринг үүсгэн байгуулсан байдаг. Эдгээр хот суурины дурсгалууд нь хаадын орд өргөө, нийслэл гэхээсээ илүү цэргийн бэхлэлт хотууд, түүнийг дагасан тариаланчид, гар урчуудын суурингууд бөгөөд тэдгээрийн газарзүйн байрлалаас үзвэл, тэд үржил шим сайтай, ус чийг элбэгтэй газруудад хот цайз байгуулан суурьшаад, суурингуудынхаа ойролцоо тариа будаа, хүнсний ногоо тарьдаг байсан аж.

Монгол нутагт сууж агсан Хятаны цэргүүдийн дотор гар урчууд, худалдаачид ч бас байлцсан нь Туул, Хэрлэн голын хөндийд буй Хятан улсын хот суурингуудад явуулсан археологийн малтлага судалгаанаас тодорхой

харагдаж байна. Тэд барилгын дээврийн ваар, бусад чимэглэлийн зүйлс, тоосго болон ахуйн хэрэглээний янз бүрийн хэлбэр, хэмжээтэй ваар сав, суулгууд, чулуун тээрэм, чулуун уур, нүдүүр зэрэг эдлэл хэрэглэлүүдийг үйлдвэрлэн хэрэглэдэг байсан аж. Мөн төмрийн хүдэр хайлуулан, цэргийн болоод аж ахуйн хэрэгцээний эдлэл, багаж зэвсгийн зүйлсийг үйлддэг байжээ⁴. Тэр бүхнийг үйлддэг тусгай газрууд ч байсан бололтой.

Мэдээж хэрэг бэхлэлт хэрэм бүхий томоохон цэргийн суурингууд сонирхол татах бөгөөд сүүлийн үед агаараас авах шинэ технологи сайжирсантай холбоотой гэрэл зургуудаас хэрмийн доторх бүтэц зохион байгуулалтын хэсгийг сайтар харж болохоор байна. Эдгээр томоохон дурсгалуудын бүтэц, зохион байгуулалт, үүрэг зориулалтын талаар өмнө нь судлаачид нэлээд нарийн тодорхойлсон тул тэдгээрийн мэдээлэлд тулгуурлан илүү нарийвчилсан зураг, судалгааны материал цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх боломжтой болжээ.

Харин сүүлийн жилүүдэд тасралтгүй явуулж буй хээрийн судалгааны ажлын үр дүнд, Хятан улсын түүхэнд холбогдох дээр дурдсан цэргийн томоохон суурингуудаас гадна жижгэвтэр хэмжээтэй, өвөрмөц зохион байгуулалт бүхий дурсгалууд цөөнгүй илэрч мэдэгдээд байгаа бөгөөд тэдгээр нь үүрэг зориулалтын хувьд хоорондоо ялгаатай байсан нь мэдэгдэж байна. Тэдгээр жижиг суурингууд нь ихэвчлэн

² Мөн тэнд. Тал 29.

³ А.Очир, Н.Н.Крадин, А.Л.Ивлиев, С.В.Данилов, Ю.Г.Никитин, Л.Эрдэнэболд. Киданский город Чинтолгой балгас. Москва. "Восточная литература" РАН. 2011.

⁴ А.Очир, Л.Эрдэнэболд. Хэрмэн дэнж балгасны тухай дахин өгүүлэх нь. //Nomadic studies. 2011.№ 18. Тал 46-53.

томоохон бэхлэлт хэрэм бүхий хот суурины дурсгалуудын ойролцоо, тэдгээрийн дагуул шинжтэй байгааг харж болохоор байна.

Цаашид энэ талаарх нарийвчилсан судалгааг ландшафтын археологийн арга зүйн тусламжтайгаар явуулж (байгалийн болон хүний гараар бүтээгдсэн усан хангамжийн систем, газар ашиглалтын тогтолцоо, эрт үеийн тахилга шүтлэгтэй газрын онцлог гэх мэт) уг бүс нутгийн талаар ил нарийн мэдээллүүдийг тодруулах шаардлагатай байна. Хээрийн судалгааны үеэр дурсгалт газруудын хооронд, газрын гадарга дээрээс шавраар хийсэн ахуйн хэрэглээний болон барилгын материал хэрэглэгдэх нийг олон тоогоор олсон нь тус газрууд ч мөн суурьшлын бүс байсан болов уу хэмээн таамаглахад хүргэж байна. Дурсгалт газруудын хооронд буй сул орон зайгаас илрүүлсэн хүний үйл ажиллагааг илэрхийлэх цөөн тооны зүйлсээр тухайн дурсгалт газруудын цаг хугацааг тодорхойлоход хүндрэлтэй. Түүврээр илрүүлсэн ахуйн хэрэглээний шавар эдлэлийн зарим үлдэгдэлүүд нь хятан нараас хойших түүхийн цаг үеийг илэрхийлэх бөгөөд зарим тохиолдолд бэхлэлт хэрэм бүхий суурингуудыг хожим нутгийн иргэд суурин амьдрах газар, малын хашаа, хороо, сүм хийд, тахилга шүтлэгийн газар болгож байсан нь дамжиггүй.

Иймээс Туул голын сав дах Хятан улсын түүхэнд холбогдох цэргийн бэхлэлт хотуудыг дагасан дугауул жижиг суурингуудын бүтэц, зохион байгуулалт, үүрэг зориулалтын талаар товч дурдая.

⁵ А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнболд. Хар бух балгас ба Туул голын сав дахь Хятаны үеийн хот, сууринууд. Ред. Д.Цэвээндорж. Улаанбаатар.

1. ХАР БУХЫН БАЛГАСЫН ДАГУУЛ СУУРИНГУУД

Хар бухын балгас нь Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Хар бух гэдэг жижиг голын зүүн хөвөөнөө оршино. Туул голын савд багтах Хар бухын голын хөндийд буй түүх, археологийн олон гайхамшигт дурсгалуудаас хамгийн сүр бараатай, нэрд гарсан нь энэ балгас юм. Энэ балгасыг анх Хятан улсын үед үүсгэн байгуулжээ. Балгас ерөнхийдөө шар шавар дэлдэн босгосон дөрвөлжин зохион байгуулалттай ба хэрмийн гадна талаар сувгаар хүрээлсэн, түүнээс салбарлуулан олон суваг татсан ажээ. Хэрмийн дөрвөн талын хана тус бүрдээ нэг шороон сонор хаалгатай. Хэрмийн хойд талын хана 660 м, зүүн талын хана 760 м, өмнө талын хана 670 м, баруун хана нь 690 м урттай юм.

Хэрмийн дотор талд 4 хаалгыг холбосон хойноос урагш, баруунаас зүүн тийш чиглэсэн өргөн гудамжтай. Гол гудамжуудаас салбарласан олон гудамжны ор мөр ихэд бүдгэрчээ. Хотын төв хэсэг болон бусад хэсгүүдэд тусдаа шороон хэрэмтэй, хэрэмгүй олон тооны шавар барилга байшингийн үлдэгдлүүд байгаа нь олон хүн төвлөрөн сууж байсныг илтгэнэ⁵. Энэхүү томоохон цэргийн бэхлэлт хотыг ойр орчимд хэдэн тооны дагуул жижиг балгасууд байна. Тухайлбал,

Цагаан үзүүрийн хэрэм 1. Булган аймгийн Дашинчилэн сумын Лах багийн нутаг, сумаас баруун урагш 26 км орчим зайтай, хойд өргөрөгийн 48Т 0416622, зүүн уртрагийн 52 76 919 хэмд оршино.

Энэхүү дурсгалыг 2002-2003 онд Туул голын хөндий дэх археологийн дурсгал судлах ангийн судлаачид анх олж илрүүлэн дэвсгэр зураг, тодорхойлолт сэлтийг үйлдэн Хятаны үед хамааруулан үзжээ⁶. Үүний дараа Монгол-Унгарын хамтарсан Khi Land төслийн судлаачид уг хэрмийн хэлбэр бүтэц зохион байгуулалт талаас нь судалж, түүний дэвсгэр зургийг нисдэг дрон ашиглан үйлджээ⁷.

Энэ хэрмийн дөрвөн тал бүр нь 200 м хэмжээтэй аж. Хэрмийн өргөн нь сууриараа 15-16 м байна. Шороо дагшруулан үйлдсэн уг хэрмийн хананы үлдцийн одоогийн өндөр 0,6-1,0 м орчим юм. Хэрмийг тойрсон сувгийн гүн 0,3 м юм. Харин хэрмийн орчмоос болон голын эргээс Хятаны үед холбогдох ваар савны хагархай их хэмжээгээр илэрч байна.

Цагаан үзүүрийн хэрэм 2. Цагаан үзүүрийн хэрэм 1 хэмээх дурсгалаас зүүн урагш 1 км орчим, Савангийн голоос 700 орчим м зайтай. Элхэрмийг анх З.Батсайхан нарын судлаачид агаарын зургийн тусламжтайгаар илрүүлэн олж товч тодорхойлолт сэлтийг нийтлүүлжээ⁸. 2018 онд Монгол-Унгарын хамтарсан Khi land төслийн судлаачид агаарын зургаас

тандан судалж олж илрүүлэн, анхны тодорхойлолт зургийг үйлдсэн байдаг⁹. Түүнээс хойш тоймтой судалгаа хийгдэлгүй өдий хүрсэн байна. Эл шороон хэрмийг бид оршин буй газар зүйн байршлаар нь Цагаан үзүүрийн хэрэм 2 хэмээн тэмдэглэв. Байршил нь хойд өргөрөгийн 48Т 0416908, зүүн уртрагийн 5275872 хэмд байрлана.

Хэрмийн хойт ханын урт нь 126 м, зүүн хана нь 127 м урт, баруун талын хана 125 метр орчим урт байна. Эл хэрэм нь дөрвөн талдаа хаалгатай, шороо дагтаршуулан үйлдсэн ажээ.

Цагаан үзүүрийн хэрэм 3. Байршил нь хойд өргөрөгийн 48Т 0417173, зүүн уртрагийн 5275175 хэмд, далайн төвшнөөс дээш 1116 метр өндөрт байна. Эл хэрмийг анх З.Батсайхан нарын судлаачид агаарын зургийн тусламжтайгаар илрүүлэн олж товч тодорхойлолт сэлтийг нийтлүүлжээ¹⁰.

Агаарын зургаас ажиглавал шороон хэрмийн дөрвөн талд мөн хаалга байсан болов уу гэмээр сэтгэхийтэй аж. Хэрэм нь тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй, зүүн, баруун хана нь бага зэрэг зүүн хойш хандсан байдалтай. Хэрэм нь хааш хаашаа 110x110 м хэмжээтэй.

⁶ А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнэболд. Хар бух балгас ба Туул голын сав дахь Хятан улсын хот суурингууд. Редактор Д.Цэвээндорж. УБ., 2005. Тал. 93-95.

⁷ Л.Эрдэнэболд, С.Жолт, Ж.Лазловский нар. Монгол Унгарын хамтарсан Khi land Хятаны ландшафт археологийн судалгаа төслийн хээрийн судалгааны ангийн тайлан. УБ., 2019. ШУТИС, Археологи, угсаатны зүйн лаборатори. Гар бичмэл; Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд нар. Монголын археологийн өв 10-р боть. Монголын эртний хот суурин. УБ., 2020. Тал.

⁸ З.Батсайхан, У.Эрдэнэбат, Б.Оюунтуяа. Зүбү аймаг ба Туулын голын савд хийсэн хот суурины судалгаа. //Археологийн судлал. Том XXXVI, Fasc 17. УБ., 2017. Тал 254.

⁹ Л.Эрдэнэболд, С.Жолт, Ж.Лазловский нар. Монгол Унгарын хамтарсан Khi land Хятаны ландшафт археологийн судалгаа төслийн хээрийн судалгааны ангийн тайлан. УБ., 2019. ШУТИС, Археологи, угсаатны зүйн лаборатори. Гар бичмэл: Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд нар. Монголын археологийн өв 10-р боть. Монголын эртний хот суурин. УБ., 2020. Тал.

¹⁰ З.Батсайхан, У.Эрдэнэбат, Б.Оюунтуяа. Зүбү аймаг ба Туулын голын савд хийсэн хот суурины судалгаа. //Археологийн судлал. Том XXXVI, Fasc 17. УБ., 2017. Тал 254.

Өрхтэйн балгас. Булган аймгийн Дашинчилэн сумын Лах багийн нутаг, Савангийн голын хойд эрэгт, голоос 200 орчим метр зайтай, хойд өргөрөгийн $47^{\circ} 33' 976$, зүүн уртрагийн $103^{\circ} 56' 332$ хэмд байрлаж байна.

Шороон хэрмийн хойд болон өмнөд хана адил хэмжээтэй, ойролцоогоор 120 м бол баруун, зүүн хана нь арай богино 109 м байна.

Шавартайн голын балгас. Булган аймгийн Гурванбулаг сумын нутаг, Их цагаан толгойн зүүн хойд талд Тогоо 1-р багийн нутаг Шавартайн голын өмнө эрэгт нэгэн шороон хэрэмт балгас байна. Дурсгал хойд өргөрөгийн $47^{\circ} 49' 21,58$, зүүн уртрагийн $103^{\circ} 25' 55,9$ хэмд Цагаан толгойн хөндий хэмээх газарт байрлана. Нутгийнхан тодорхой нэрийдсэн нэршил байхгүй.

Шороон хэрэм тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй, зүүн хана нь 375 м урт, өмнө талын хана нь 430 м урт, баруун хана нь 375 м урт, хойд талын хана нь 400 м хэмжээтэй.

Шороон хэрмийн дотор талд баруун урд буланд 50 м голчтой жижиг нууртай. Энэ нь байгалийн тогтоц бүхий нуур байсныг хэрмийн дотор оруулан барьсан байна.

Хэрмийн дотор нэгэн том шороон дов байна. Шороон довын хэмжээ нь баруунаас зүүн ийш 44 м, хойноос урагш 42 м. Бид барилгын үлдэгдэл болов уу хэмээн таамаглаж байсан эл дов нь нь дугуй хэлбэртэй, дээд тал нь тэгш хавтгай, довжоо маягийн байгууламж байна. Дээд талаас нь болон ойр орчмоос нь барилгын хэрэглэгдэхүүн олодохгүй.

2. ЧИН ТОЛГОЙ БАЛГАСЫН ДАГУУЛ СУУРИНГУУД

Энэхүү балгас нь Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт оршино. Энэ хотын туурь нь 1260×660 м хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй, хойноос урагш сунаж тогтсон, тал бүрээс нь нар тусаж байхаар бодож барьсан зохиомжтой. Хэрмийг шороо дагтаршуулан үйлдсэн ажээ. Сүүлийн жилүүдэд явуулсан археологийн судалгаагаар Чинтолгой балгас нь Хятан улсын үед шинээр байгуулсан хот бус, харин Уйгур улсын үед анх байгуулагдаж, хожим Хятан нар сэргээн засаад ашигласан хот болох нь мэдэгджээ¹¹. Түүний ойр орчимд Чингийн шуудууг дагасан олон тооны барилга байшингийн үлдэгдэл мэдэгдэхээс гадна хэдэн тооны жижиг хэрмийн үлдэгдэл мэдэгдэв.

Өндөр дэнжийн балгас. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт, сумын төвөөс зүүн хойш 24 орчим км зайтай Чин толгойн чулуун байгууламж бүхий толгойн баруун дор хавтгай дэвсэгт нэгэн хульширсан хэрэм буйг бид агаарын зургаас илрүүлсэн билээ. Эл дурсгал нь хойд өргөрөгийн $47^{\circ} 53' 56,9$, зүүн уртрагийн $104^{\circ} 12' 19,9$ хэмд байрлаж байна.

Энэ хэрэм нь Чингийн шуудуу хэмээх жижиг голын хойд эрэгт, голоос 200 орчим м зайтай, тэгш хавтгай дээр байрлах бөгөөд газар нь бага зэрэг хэвгий учир үер ус, он цагийн уртад ихэд элэгдэн тарж, бараг энгийн нүдээр харагдахгүй шахам болжээ. Харин агаарын зургаас сайтар мэдэгдэнэ.

¹¹ А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнболд. Чинтолгойн балгасын тухай. //«Nomadic studies». №8. Улаанбаатар.

Шороон хэрмийн хойд болон өмнө хана нь 68 м урт, зүүн, баруун хана нь 67 м хэмжээтэй байжээ. Хэрмийн дотор үлдэж хоцорсон халаалтын сувгийн үлдэгдэлүүдээс ажиглавал хэрмийн дотор нилээд олон барилга байшингууд байсан бололтой. Ингэхдээ хэрмийн гол төв хэсэгт нэгэн томоохон барилга, харин бусад барилгууд нь шороон хэрмийн баруун ханыг дагасан маягтай байрлаж байсан нь мэдэгдэнэ. Эл хэрэм нь Чин толгой балгастай холбоотой нэг цагт үед холбогдох дурсгал бололтой.

Сүүжийн голын хэрэм. Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг, Лах багийн нутагт эл балгас оршино. Дашинчилэн сумын төвөөс чанх урагш 1 км орчим зайтай, сумын төвийн өмнүүр зүүн хойш эмжин урсах Сүүжийн голын өмнөд эрэгт, голд нилээд шахсан байдалтай оршино.

Бид оршин буй газрынх нь нэрээр Сүүжийн голын дөрвөлжин хэрэм хэмээн нэрийдэв. Энд үндсэндээ том жижиг зэрэгцээ хоёр шороон хэрмийн туурь байна. Эхний хэрэм нь жижиг хэмжээтэй бол нөгөө хэрэм нь нэлээд том хэмжээтэй. Хоёулаа нэг шугаманд хоорондоо 4-5 м орчим зайтай зэрэгцэн байна. Жижиг хэрмийг Сүүжийн голын хэрэм 1 хэмээн нэрийдэн тодорхойлолтыг үйлдэв.

Сүүжийн голын хэрэм 1. Дурсгалын байршил нь хойд өргөрөгийн 47° 49'58,1 зүүн уртрагийн 104° 03'31,9 хэмд оршино. Хэрмийн зүүн, баруун хана нь ялимгүй баруун хойд зүгт 325° хэмд хандсан байна.

Шороон хэрмийн хойд хана 128 м, зүүн хана 123 м өмнөд ханын урт нь 130 м баруун ханын урт нь 124 м. Баруун ханын дунд хэсэгт хаалганы сэтэрхий мэдэгдэж байна. Түүний өргөн нь 6-7 м аж.

Шороон хэрмийн дотор талд ямар нэгэн барилга байшин байсан ул мөр мэдэгдэхгүй.

3.Батсайхан нарын судлаачдын нэгэн өгүүлэлд энэ хавьд нэгэн хэрмийг тэмдэглэсэн нь 170x170 м хэмжээтэй, энгийн нүдэнд үл мэдэгдэм хэмээн тэмдэглэсэн бөгөөд тухайн дурсгалын координатыг тэмдэглээгүй байдаг¹². Энэ хэрэм нь 123x127 м орчим хэмжээтэй, энгийн нүдээр харагдахаар тод хадгалагдан үлдсэн байгаа билээ. Мөн тэд тэмдэглэхдээ эл хэрмэнд хаалга үүд байхгүй¹³ гэсэн бол эл хэрэм нь 2 талдаа сайтар мэдэгдэхээр хаалга үүдний бололтой сэтэрхий илт мэдэгдэм байна.

Хаалганы болон хэрэм сувгийн зохион байгуулалт зэргээс нь үзвэл Туул голын хөндийд байдаг жижиг шороон хэрмүүдтэй бүтэц зохион байгуулалтын хувьд ижил байна.

Сүүжийн голын хэрэм-2. 1-р хэрмийн баруун талд 5,0 м орчим зайтай зэрэгцэн бас нэгэн том хэмжээтэй шороон хэрмийн үлдэц байна. Эл хоёр хэрэм бараг залгаа шахуу бөгөөд голоор нь татсан хэрмийн гадуурх сувгаараа хоорондоо зааглагдаж байна.

Эл дурсгал нь Булган аймгийн Дашинчилэн сумын Лах багийн нутагт, Сүүжийн голын өмнөд эрэгт, хойд

¹² 3.Батсайхан, У.Эрдэнэбат, Б.Оюунтуяа. Зүбү аймаг ба Туулын голын савд хийсэн хот суурины судалгаа. //Археологийн судлал. Том XXXVI, Fasc 17. УБ., 2017. Тал 254.

¹³ Мөн тэнд.

өргөрөгийн 47°49'53,7 зүүн уртрагийн 104°03'36,3 хэмд байрлана.

Хэрэм нь шороо дэлдэн үйлдсэн тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй боловч баруун хана нь хагас дугуйрсан маягтай өвөрмөц зохион байгуулалттай. Эл газар нь Сүүжийн голын хөндийн дэрс өвс ургасан газар учир шороон хэрмийн бүтэц зохион байгуулалт сайн мэдэгдэхгүй, баруун болон зүүн, өмнөд талын хэрэм нь бага зэрэг хадгалагдан үлдсэн бол хойд хэрэм нь Сүүжийн голын усанд идэгдэн мэдэгдэхгүй болжээ.

Мөн ойр орчмоос олдож буй хээтэй, хээгүй ваар савны хагархай хэсгүүд нь хоорондоо ижилсэж байна.

Эмгэнтийн хэрэм 1, 2. Чин толгой балгасын эргэн тойронд Чингийн шуудууг дагасан эртний суурьшлын бүс байхаас гадна Эмгэнтийн хэрэм 1, 2 гэх мэт газар тариалан эрхлэгчид, гар урчуудын суурин байдаг. Эмгэнтийн хэрмийн талаар өмнөх судлаачид тэмдэглэсэн учир дэлгэрэнгүй өгүүлэлгүй орхив.

3. УЛААН ХЭРЭМ ТҮҮНИЙ ОРЧИМ ДАХЬ ДАГУУЛ СУУРИНГУУД

Булган аймгийн Баяннуур сумын нутаг Баян-Улаан уулын зүүн хормой, Шар тал хоёрын нийлэх уулзвар газарт томхон шороон хэрэм байна. Үүнийг анх эрдэмтэн Х.Пэрлээ илрүүлэн олжээ. Энэ хэрэм нь улаан шороог дагтаршуулан

босгосон учир холоос улайран харагдана. Нутгийнхан түүнийг Талын улаан хэрэм, Улаан хэрэм хэмээн.

Энэхүү хэрэм нь шороо дагтаршуулан үйлдсэн бөгөөд дөрвөлжин зохиомжтой. Хойт, урд хоёр хана тус бүр 400 м, баруун болон зүүн хана тус бүр нь 390 м орчим урт байна. Эл хэрэм нь баруун, өмнөд, зүүн гурван талдаа чих бүхий том хаалгатай байжээ. Тэдгээр хаалганууд нь дунджаар 27х24 м хэмжээтэй аж. Улаан хэрмийг тойруулан ухсан гүнзгий сувагтай. Хэрмийн дотор олон барилга байгууламжтай, олон хүн нягт суурьшсан, зохион байгуулалт сайтай шороон хэрэмт хот байжээ¹⁴. Түүний ойр орчимд хэдэн тооны дагуул хэрэм байна. Тэдгээрээс шинээр илэрсэн зарим дурсгалуудыг танилцуулья.

Дэрсэн хэрэм 3. Булган аймгийн Баяннуур сумын Шар тал багийн нутаг, Баян-Улаан уулын өмнөд хормойн Дэрсэйн хөндийн хойд захад нэгэн хуучин балгас буйг А.Очир нарын судлаачид анх илрүүлэн олж тайландаа тэмдэглэсэн байдаг¹⁵. Эл жижиг шороон хэрмийн хойхно талд Дэрсэн хэрэм хэмээх шавар хэрмийн туурь буйг 2003 онд А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнэболд нарын судлаачид олж илрүүлэн анхны дэвсгэр зураг, тодорхойлолтын хамт нийтэлсэн байдаг¹⁶. Түүнээс хойш агаарын зургийн тусламжтайгаар судлаачид эл Дэрсэн хэрмийн эргэн тойронд түүнээс

¹⁴ А.Очир, Л.Эрдэнэболд. Из исследования киданьских городов, городищ и других сооружений в монголии. //Динамизм людей, вещей и технологий на Северо-Восточном Азии Среднего Века. Международный симпозиум, Владивосток.

¹⁵ А.Очир, Г.Анхсанаа, Г.Мандахбаяр. Улаан хэрмийн Шороон бумбагарын орчин тойрны археологийн дурсгалын хайгуул судалгаа бүртгэлийн тайлан. УБ., 2018. Гар бичмэл. Соёлын үндэсний төв.

¹⁶ А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнэболд. Хар бух балгас ба хятан улсын үеийн хот суурингууд. Редактор Д.Цэвээндорж. УБ., 2005. Тал. 95-98.

баруун урагш 500-800 м зайтай 2 ч шинэ хэрмийг илрүүлэн олсныг газрынх нь нэрээр Дэрсэн хэрэм 3, 4 хэмээн нэрийдэв¹⁷.

Эл хэрэм Баяннуур сумын төвөөс чанх хойш 4,8 км орчим зайтай, дэрстэй талын захад тэгш дэвсэг дээр байрлана. Дурсгал хойд өргөрөгийн 47°52'45,3 зүүн уртрагийн 104°27'53,7 хэмд оршино.

Шороон хэрэм газар дээрээ энгийн нүдээр огт харагдахгүй болтлоо элэгдсэн, үндсэндээ түүний шороон далангийн суурь нь цайран харагдаж байна. Харин агаарын зургаас түүний хэлбэр зохион байгуулалт сайтар мэдэгдэж байна. Үндсэндээ гонзгой дөрвөлжин хэлбэртэй, шороо дэлдэн босгосон байсан нь мэдэгдэнэ.

Хэрмийн ойр орчмоос болон хэрмийн дотор талаас ахуйн хэрэглээний болон барилгын материал огт олдохгүй.

Шороон хэрмийн баруун, зүүн хана нь 80 м, өмнөд болон хойд хана нь 290 м орчим хэмжээтэй байжээ.

Дэрсэн хэрэм 4. Булган аймгийн Баяннуур сумын Шар тал багийн нутаг, сумын төвөөс чанх хойш 5 км орчим зайтай нэгэн шороон хэрэм буйг агаарын зургаас анх илрүүлэн олсон юм. Мөн эл хэрмийг өмнө нь А.Очир, Г.Анхсанаа нарын судлаачид хайгуул судалгаа хийх явцдаа олж үзэн тэмдэглэсэн байдаг¹⁸.

Эл хэрэм нь Баян-Улаан уулын өмнөд хормойд, дэрстэй хөндийд

байрлах бөгөөд эл хэсэг нь өтгөн ургасан дэрстэй, намаг шавар ихтэй, хотгор газар билээ. Эл өтгөн дэрстэй хөндийн хойд захад дэрсгүй хэсэгхэн чөлөө бүхий хэсэгт тааруулан барьсан байна.

Эл дурсгал нь шороо дэлдэн үйлдсэн тэгш өнцөгт, дөрвөлжин хэлбэртэй. Хэрмийн шавар хана нь маш их элэгдэн тарж энгийн нүдээр харагдахгүй шахам болж хэрмийн суурь үлдэж хоцорсон. Шороон хэрэм сууриараа 7,5 м орчим өргөн. Дурсгал хойд өргөрөгийн 47°52'13,7, зүүн уртрагийн 104°27'34,7 хэмд байрлана.

Шороон хэрмийн урд хана 264 м, баруун хэрэм нь 175 м үргэлжлээд хуучин голын сайранд тулж эвдэгдэн тасарсан, хойд талын хэрэм нь бүхэлдээ голд идэгдэн тасарч мэдэгдэхгүй болсон бол зүүн талын хэрэм нь 110 орчим м үргэлжлээд мөн голын хуурай сайрт тулж мэдэгдэхгүй болсон байна. Ерөнхийдөө өмнө болон хойд хэрэм нь ойролцоогоор 265 м, баруун зүүн тал нь 250 м хэмжээтэй тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэрийн хэрэм байсан бололтой хэмээн таамаглав.

Шар талын хэрэм. Булган аймгийн Баяннуур сумын Шар тал багийн нутаг, Баян-Улаан уулын зүүн урд талын хөндийд нэгэн хэрмийн туурь буйг бид агаарын зургаас анх олж тогтоосон билээ. Уг газар нь ихээхэн дэрс ургасан, тэгш хавтгай боловч яг энэхүү хэрэм буй газар нь цулгуй дэвсэг байна. Дурсгалын байршил нь хойд өргөрөгийн 47°52'06,6, зүүн

¹⁷ А.Очир, А.Энхтөр, Л.Эрдэнэболд. Туул голын хөндий дэх хятан улсын үеийн хот, суурингууд. УБ., 2020. Тал

¹⁸ А.Очир, Г.Анхсанаа, Г.Мандахбаяр. Улаан хэрмийн Шороон бумбагарын орчин тойрны археологийн дурсгалын хайгуул судалгаа бүртгэлийн тайлан. УБ., 2018. Гар бичмэл. Соёлын үндэсний төв.

уртрагийн 104°31'29,7 хэмд байрлана.

Эл дурсгал нь өдгөө газар дээрээ нүдэнд харагдаж үзэгдэх зүйл үгүй болсон. Гагцхүү шороо дэлдэн үйлдсэн хэрэм байсан суурь нь цайран харагдаж байна.

Шар талын хэрмийн хойд болон урд хана нь 170 м, баруун, зүүн хана нь 122 м хэмжээтэй. Өндөр нь мэдэгдэхгүй бөгөөд ерөнхийдөө бороо усны нөлөөгөөр элэгдэн тарж газрын хөрстэй тэгширсэн. Шороон хэрмийн дотор ямар нэгэн барилга байшингийн үлдэгдэл байхгүй, ойр орчмоос ахуйн хэрэглээний болон барилгын материал гэх зүйлс огт илэрч олдохгүй байна.

Мөөрсийн голын хэрэм. Эл шороон хэрэм нь Төв аймгийн Өндөрширээт сумын нутагт хойд өргөргийн 47° 33.314', зүүн уртрагийн 104° 37.152' хэмд Мөөрсийн голын хөндийд оршино. Хэрэм нь дөрвөлжин зохиомжтой, дөрвөн тал тус бүр 250 м хэмжээтэй. Хэрмийн дээгүүр дэрс их хэмжээгээр ургасан нь хэрмийн дотоод зохион байгуулалтыг мэдэхэд бэрхтэй болжээ.

4. ХЭРМЭН ДЭНЖ БАЛГАС ТҮҮНИЙ ОРЧИМ ДАХЬ ДАГУУЛ СУУРИНГУУД

Энэ хот нь Монгол Улсын Төв аймгийн Заамар сумын нутаг Хэрмэн дэнж хэмээх газарт оршино. Туул гол руу зүүн биеэс нь шахаж тогтсон Агит, Төмст хэмээх хоёр уулын дундах цалгай хөндийн өмнөд хэсгийг нутгийнхан Хэрмэн дэнж, уг дэнж дээр буй эртний балгасыг Хэрмэн дэнжийн балгас хэмээн нэрийджээ.

Хэрмэн дэнжийн гол балгас нь шавар дэлдэж босгосон шороон хэрэмтэй, хэрэмгүй хэдэн жижиг суурингаас бүрдэнэ. Тэдгээр нь Хэрмэн дэнжийн балгасын дагуул жижиг хотууд байсны үлдэц юм. Эл балгасны гол төв хэсгийн хойд талын шороон хэрмийн баруун хана нь 360 метр, хойд хана нь 310 м, урд тал нь 380 м, зүүн хана нь 330 м урттай, хэрэм ерөнхийдөө дөрвөлжин зохиомжтой аж. Гол хэрмийн зүүн этгээдийн хойд, урд хэсгийг заагласан шороон хэрэм нь дунд хэсэгтээ том гулдан хаалгатай байжээ. Түүний ойр орчимд хэрэмтэй, хэрэмгүй хэдэн тооны дагуул суурингууд байгаагаас гадна түүнээс 15-20 хүртэлх км зайтай хэдэн тооны дагуул бололтой суурингийн үлдэгдэлүүд байна¹⁹.

Цагаан дэнжийн балгас 2. Энэ туурь нь Булган аймгийн Баяннуур сумын Шар тал 2-р багийн нутагт, Туул голын урд эрэгт байрлана. Туул голоос 400 орчим метр зайтай, хойд өргөрөгийн 47° 57'23,4, зүүн уртрагийн 104°40'20,0 хэмд оршино.

Шороон хэрмийн хойд хана нь 58 метр, зүүн талын хана нь 73 м, урд хана нь 58 метр, баруун талын хана 75 метр урттай, шороон хэрмийн баруун ханын хойд хэсэгт бас нэгэн явган хаалганы бололтой сэтэрхий мэдэгдэж байна. Сэтэрхийн өргөн 3-4 м.

Шороон хэрмийн хойд хананд тулгаж барьсан байдалтай зуувин дөрвөлжин хэлбэрийн ганц том барилгатай. Барилгын үлдэгдэл голоороо бага зэрэг хотгор. Эл барилга өмнө талын хаалгыг голлосон маягтай баригдсан.

¹⁹ А.Очир, А.Энхтөр. Хэрмэн дэнжийн балгас. //Монгол-Солонгосын эрдэм шинжил- гэний II Симпозиумын илтгэлийн эмхэтгэл. Монгол хэлээр 15-23-р талд, солонгос хэлээр. Сөүл.

Барилгын тууриас цагаан шаргал шавраар хийж сайтар шатаасан барилгын дээврийн ваарны хагархай цөөнгүй олдож байна.

Цагаан дэнжийн балгас 1, 2 нь Хэрмэн дэнжийн балгастай холбоотой бөгөөд нэгэн цаг үед байгуулагдсан дурсгал боллоотой. Цагаан дэнж 2 туурь нь мөн Хятан улсын үед холбогдох боломжтой бөгөөд Цагаан дэнжийн балгас 1-тэй холбоотой, түүний нэг хэсэг нь гэж хэлж болно.

Бэлхийн балгас 1. Төв аймгийн Заамар сумын Бат-Өлзий 4-р багийн нутаг Бэлхийн тархи хэмээх газарт энэ балгас оршино. Эл Бэлхийн гол нь ерөнхийдөө хуурай сайр бөгөөд бороо хуртай жил урсдаг Нутгийнхан шороон хэрмийг энэ хуурай сайрын нэрээр Бэлхийн дөрвөлжин хэрэм хэмээнэ. Эл шороон хэрэм нь хойд өргөрөгийн $48^{\circ}12'14,95$, зүүн уртрагийн $104^{\circ}48'21,41$ хэмд оршино.

Анх 2009 онд Монгол, ОХУ-ын хамтарсан Төв азийн нүүдэлчдийн хот суурины судалгаа төслийн судлаачид нутгийн иргэдийн аман мэдээгээр олж үзсэн бөгөөд анхны тодорхойлолт, дэвсгэр зургийг үйлджээ²⁰.

Бэлхийн балгас нь 247×247 м харьцаатай, гадуур нь намхан нарийн суваг ухаж, түүний шороог гарган овоолж дэлдэн байгуулсан зохион байгуулалттай байжээ.

Хэрэм дотроос болон Бэлхийн голын эргийн бороо усанд идэгдсэн эргээс нь эргэх хүрд дээр хийгдсэн толигор гадаргуутай, хээтэй ваар

савны хагархай хэлтэрхий болон төмөр эдлэлийн хэсгүүд, үнс нурам, малын яс их хэмжээгээр илэрч мэдэгдэж байгаагаас гадна үр тариа нүдэх болон цайруулах самбар чулууны хагархай хэлтэрхий олдож байна. Энэхүү балгас нь Бэлхийн голын хөвөөг дагасан тариа ногооны суурин байсан, цөөн тооны хүмүүс төдийлөн урт хугацаанд оршин суугаагүй болов уу хэмээн таамаглаж байна.

Бэлхийн балгас 2. Төв аймгийн Заамар сумын Бат-Өлзий 4-р багийн нутаг, Бэлхийн голд 2020 онд нэгэн балгас буйг бид агаарын зургаас олж илрүүлэн 2021 онд газар дээр нь очиж хэмжилт судалгааг явуулж нийтэлсэн юм²¹. Энэхүү дурсгал нь хойд өргөрөгийн $48^{\circ}12'12,73$, зүүн уртрагийн $104^{\circ}53'57,22$ хэмд байрлаж байна. Эл дурсгалыг бид Бэлхийн балгас 2 хэмээн нэрийдэв. Эл хэрэм нь агаарын зургаас сайн харагдах боловч газар дээрээ маш их элэгдэн намсаж бүдгэрсэн, энгийн нүдээр харагдахгүй шахам болжээ.

Шороон хэрэм нь тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй, шавар шороо дагтаршуулан үйлдсэн дөрвөн талт хэрэм аж.

Шороон хэрмийн хойт талын ханын урт нь 181 метр, баруун талын ханын урт 239 м, зүүн ханын урт нь 237 м, өмнө талын хана мэдэгдэхгүй болж баларсан учир ойролцоогоор хойд ханын ижил 180 м хэмжээтэй байсан болов уу хэмээн таамаглав.

Шороон хэрмийн баруун урд буланд байгуулсан давхар шороон

²⁰ Монгол-Буриадын хамтарсан төв Азийн нүүдэлчдийн хот суурины атлас төслийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. УБ., 2010. НСИСОУХүрээлэнгийн номын сан. Гар бичмэл.

²¹ Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд нар. Монголын археологийн өв 10-р боть. Монголын эртний хот суурин. УБ., 2020.

хэрэм мэдэгдэж байна.

Шороон хэрмийн дотор талаас түүврээр барилгын хэрэглэгдэхүүн болон ахуйн хэрэглээний зүйлс олдохгүй байна. Эл шороон хэрэм нь Хятан улсын үед холбогдох Бэлхийн балгаснаас ердөө 6 км орчим зайтай, зэрэгцэн оршиж байгаа, Бэлхийн голын эрэгт голоос 2,5 км орчим зайтай байгаа зэргээс нь бид Хятан улсын үеийн тариа ногооны суурин болов уу хэмээн таамаглаж байна.

Дүгнэлт

2023 онд ийнхүү хоёр улсын хамтарсан Хятаны газар нутаг дахь ландшафт археологийн төсөл амжилттай хэрэгжсэн бөгөөд Туул голын хөндий болон түүнд цутгадаг жижиг голуудын хөндийд илэрч мэдэгдээд буй 20 шахам газар тариалан, гар урчуудын суурингуудад тандалт судалгааг явуулж сонирхолтой үр дүнд хүрээд байна. Бидний тайлан боловсруулалтын ажил явагдаж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар дараах үр дүнд хүрээд байна. Үүнд.

1. Туул голын савд Хятаны цэргийн томхон суурингууд, том хотуудын дагуул маягаар байгуулагдсан жижиг суурингууд олон байжээ. Тэдгээр дагуул жижиг суурингуудын оршин суугсад том хотуудад суугсдын хүнс бэлтгэх, бэхлэлт цайз, орон сууц барих, тариалан эрхлэх зэрэг ажил хийдэг байж. Хятаны цэргийн эрхтэн, засаг захиргааны албан тушаалтан нар голлон том хотууд (жоу)-д оршин сууж, дагуул суурингуудад тухайн хотынхоо ойролцоо байрладаг асан нь тэдгээрийн байрлал, зай зэргээс харагдана. Тухайлбал, Хар

бух балгасын дагуул суурингууд нь Найдаг уулын дөрвөлжин, Цагаан үзүүрийн хэрэм 1, 2, 3, Шавартайн голын хэрэм, Хэрмэн дэрс зэрэг бол Чин толгойн дагуул нь Өндөр дэнжийн балгас, Эмгэнтийн хэрэм, Сүүжийн голын хэрэм, Мөөрсийн голын хэрэм, Улаанхэрмийн дагуул нь Талын хэрэм, Дэрсэн хэрэм 1, 2, 3, 4, Хэрмэн дэнжийн балгасын дагуул нь Цагаан дэнжийн балгас 1, 2, Бэлхийн балгас 1, 2, Лүнгийн дөрвөлжин гэх мэт байсан бололтой. Тэдгээр суурингуудын газарзүйн байрлалаас үзвэл, тэд үржил шим сайтай, ус чийг элбэгтэй газруудад голчлон байрлах агаад суурингуудынхаа ойролцоо тариа будаа, хүнсний ногоо, тариа тарьдаг байсан аж. Эдгээр жижиг суурингуудын ойролцоогоос суваг шуудуу татсан ул мөр, тариалангийн янз бүрийн хэмжээтэй тээрмийн чулуунуудын хагархай ч нэлээд олдож байна.

2. Энэ төрлийн жижиг хэрэмт суурингууд нь ихэвчлэн дотроо барилга байшингийн ор туурь байдаггүй, голдуу өмнө талдаа хаалга үүдтэй, шороо шавар дэлдэн босгосон хэрэмтэй, гадуураа намхан шуудуу сувагтай байдаг билээ. Эдгээр шороон хэрэмт суурингууд нь дутуу баригдсан гэхэд дотроос нь болон ойр орчмоос ахуйн хэрэглээний зүйлс, ваар савны хагархай хэлтэрхий их хэмжээтэй олддог нь хүмүүс ямар нэгэн хэмжээгээр тодорхой хугацаанд суурин сууж амьдарч байсныг илтгэдэг. Бидний санахад эдгээр нь Хятан улсын дарангуй цэргийн хүнсний хэрэгцээг хангах зорилготой тэднийг дагалдан ирсэн тариа ногооны ажил эрхэлдэг хүмүүсийн түр зуурын суурин

болгон ашиглаж байсан бололтой. Өөрөөр хэлбэл хэрмийн дотор гэр майхан мэт улирлын чанартай сууцууд барьж, хавар, намар, зуны улиралд хэсэгхэн хугацаанд байрлаж тариа ногооны ажлаа эрхлээд өвлийн улиралд эдгээр жижиг суурингуудаас холгүй орших Хар бух, Чинтолгой, Хэрмэн дэнж, Улаан хэрэм, Хэрмэн дэнж мэтийн том хотуудад очиж өвөлждөг байсан байж болох юм. Тэдгээр том хотуудад хийсэн археологийн малтлага судалгаагаар өвөл, зуны аль ч улиралд хүн амьдарч суух боломжтой барилга байшингийн үлдэгдэл, халаалтын суваг гэх мэт зүйл²² илэрч байдаг нь үүнийг илтгэх мэт. Тэрчлэн шороон хэрмүүдийн ойр орчмоос барилгын материал олноод байдаггүй. Бидний судалгаанд хамрагдсан 20 шахам жижиг суурингийн үлдэгдлээс ердөө 2-3 суурингаас барилгын дээврийн нөмрөг болон тосгуур ваарны цөөн тооны хагархай хэлтэрхий илэрч мэдэгдэв. Харин ахуйн хэрэглээ ваар савны хагархай цөөн тоогоор олдож байгаа нь түр зуурын суурин болохыг илтгэнэ.

3. Түүхэн сурвалж бичигт өгүүлснээс үзвэл, хятанчууд энэ нутагт амьдрах нөхцөл хүнд хэцүү байжээ. Монголд сууж байсан газар тариалан, гар урлал эрхэлж байсан хүмүүс өөрсдийгөө хамгаалах, нүүдэлчдийн довтолгооноос сэргийлэх зорилгоор багавтар хэмжээтэй хэдий ч хана хэрэм барьж өөрсдийгөө болон мал сүргээ хамгаалж байсан нь илэрхий байна. Туул голын хөндийг дагасан жижиг голуудын хөндийгөөр буй балгасууд нь бүгд гадуураа гүн суваг

шуудуу бүхий өндөр хана хэрэмтэй боловч дотроо огт барилгагүй эсхүл цөөн тооны барилгатай болох нь мэдэгддэг. Тэгэхээр тэнд байнга оршин суудаггүй зөвхөн улирлын чанартай газрууд байжээ.

4. Тэдгээрийн байршил, дотоод, гадаад бүтэц зохион байгуулалт нь янз бүр агаад эдгээр дагуул суурингууд өөр өөр үүрэг зориулалттай байсан нь тодорхой байна. Шавар, шороо дэлдэн үйлдсэн дөрвөлжин хэлбэртэй хэрмүүд байгаа боловч тухайн хэрэм дотор барилга байшингийн үлдэгдэл огт мэдэгдэхгүй байна. Тиймээс эдгээр хэрмүүд нь мал аж ахуйн зориулалттай юу? эсхүл түр сууж байсан хүмүүсийн гадны аюулаас хамгаалах хүрээ хашаа байсан болов уу, дутуу хийгээд орхисон уу гэсэн асуулт урган гарч байна. Зарим нь оршуулгын газрын зориулалттай байсан болов уу хэмээн таамаглахад хүрч байгаа ч тэдгээр дурсгалт газруудад нарийвчилсан судалгааг одоогоор хийгээгүй байна. Цаашид энэ талаарх нарийвчилсан судалгааг археологийн арга зүй, сансрын болон агаарын зургийн тусламжтайгаар явуулж байгалийн болон хүний гараар бүтээгдсэн усан хангамжийн систем, газар ашиглалтын тогтолцоо, эрт үеийн тахилга шүтлэгтэй газруудын талаар илүү нарийн мэдээллүүдийг тодруулах шаардлагатай байна.


5. Хээрийн судалгааны үеэр дурсгалт газруудын дотроос болон ойр орчмын газрын гадарга дээрээс шавраар хийсэн ахуйн хэрэглээний болон барилгын материал олон тоогоор олдож байгаа нь тус

²² Н.Н.Крадин, А.Л.Ивлиев, А.Очир, С.В.Данилов, Ю.Г.Никитин, С.В.Данилов, Л.Эрдэнэболд. Киданьский город Чинтолгой балгас. Москва. "Восточная литература" РАН. 2011.

газрууд нь багагүй удаан хугацаанд ашиглагдсан суурьшлын бүс байсныг илтгэнэ. Гэвч дурсгалт газруудын хооронд болон ойр орчмоос олж илрүүлсэн хүний үйл ажиллагааг илэрхийлэх цөөн тооны зүйлсээр тухайн дурсгалт газруудын цаг хугацаа, үүрэг зориулалт зэргийг тодорхойлоход хүндрэлтэй. Түүврээр илрүүлсэн ахуйн хэрэглээний шавар эдлэлийн зарим

үлдэгдлүүд нь хятан нараас хойших түүхийн цаг үеийг илэрхийлэх нь элбэг бөгөөд зарим тохиолдолд бэхлэлт хэрэм бүхий эдгээр жижиг суурингуудыг орхигдон хаягдснаас хойш нутгийн иргэд суурьшин амьдрах газар, малын хашаа, хороо, сүм хийд, тахилга шүтлэгийн газрын зориулалтаар ашигласаар ирсэн байдаг.

Хавсралт зураг-1



Туул голын дагуух Хятаны үеийн хот, суурин болон том хотуудын дагуул суурингийн байршилг харуулсан зураг



📍 — Сүүлийн жилүүдэд шинээр илэрүүлсэн дагуул суурингууд

Туул голын хөндий болон сүүлийн жилүүдэд шинээр илрүүлсэн дагуул суурингуудын тархац

Хавсралт-2. Шинээр илрүүлсэн дагуул суурингийн зарим гэрэл зураг



Шавартайн голын хэрэм. Хойд талаас



Дэрсэн хэрэм-4. Баруун урд талаас



Цагаан үзүүрийн хэрэм-2. Хойд талаас



Шавартайн голын хэрэм. Зүүн урд талаас

МОНГОЛ ОРНЫ ЗАРИМ ЭМИЙН УРГАМЛААС ЯЛГАСАН ЭНДОФИТ МӨӨГӨНЦРИЙН БАКТЕРИЙН ЭСРЭГ ИДЭВХИЙН СУДАЛГАА

Т.Адьяадолгор

(ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга)

Эндофит бичил биетэн нь эзэн ургамалдаа ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ашигтай шинж чанар үзүүлэн ургамлын дотор амьдардаг бичил организм юм (Freeman et al. 1904). Эндофит бичил биетний судалгаа манай оронд эхлээд 10 орчим жил болж байгаа хэдий ч дэлхий дахин бол эрчимтэй судлагдаж буй судалгааны чиглэл юм (Adiyadolgor et al 2019). Эндофит

бичил организм нь эзэн ургамлынхаа өсөлт хөгжлийг дэмжихээс гадна эзэн ургамалтайгаа адил төст биологийн идэвх нэгдэл тэр дундаа хоёрдогч метаболит нийлэгжүүлэх чадвартай байдаг (Singh and Dubey 2015). Түүнчлэн бактери мөөгөнцрийн эсрэг идэвхтэй химийн нэгдэл нийлэгжүүлдэг байна (Yang et al. 2004, Zhang et al. 2006, Tejesvi et al. 2007).

Хүснэгт 1. Судалгаанд ашигласан дээж ургамлуудын мэдээлэл

No	Ургамлын нэр	Ургамлын овгийн нэр	GPS	Хаанаас
1	<i>Sphaerophysa salsula</i>	Fabaceae	50° 6'476" N, 92°22'553" E	Увс аймаг
2	<i>Halerpestes salsuginosa</i>	Ranunculaceae	50° 2'666" N, 92° 16'961" E	
3	<i>Convolvulus arvensis</i>	Convolvulaceae	50° 8'888" N, 91° 38'901" E	
4	<i>Nitraria sibirica</i>	Nitrariaceae	50° 9'153" N, 92° 19'306" E	

Эндофит мөөгөнцөр ялгах арга зүй: Эндофит бичил биетний цэвэр өсгөвөр ялгахад эхлээд дээж ургамлын үндэс, иш, навч, цэцэг, жимс зэрэг хэсгүүдээс зүсэж бэлтгэн (3x3 см), тоос шороо бохирдлыг урсгал усаар сайтар угаана. Угаасны дараа 70%-ийн этилийн спиртээр 30 сек, 10%-ийн натрийн гипохлоридоор 1 мин, 70%-ийн этилийн спиртээр дахин 30 сек ариутгана. Гадаргууг ариутгасны дараа ариутгасан нэрсэн ус ашиглан гадаргуугийн

үлдэгдэл уусмалыг угааж, уг уснаас хяналт болгон авна. Үүний дараа ариутгасан ургамлын хэсгээ ариутгасан фильтрийн цаасан дээр тавьж хатаана. Хатсаны дараа ариутгасан шилэн дээр тавьж ариутгасан хутга, пинцетээр (0.5 x 0.5см) зүсэж дотор эдийг ил гаргаад зохих антибиотик агуулсан PDA, YM, Gauze-1 ба LB агар хатуу орчин дээр суулгаж, мөөгөнцрийг 28°C-д 7-21 хоног өсгөвөрлөнө. Ургасан бичил биетнийг зохих тэжээлийн орчинд шилжүүлэн

суулгаж цэвэршүүлнэ. (Enkh-Amgalan, 2013).

Төрлийн хамаарлыг тодорхойлох: Бичил биетний геномын ДНХ-г “Prepman Ultra Sample Reagent” цомог ашиглан үйлдвэрлэгч компанийн зааврын дагуу бэлдэнэ. Мөөгөнцрийн ITS хэсэг болон 28S rPHX генийн D1/D2 домейныг хамтад нь ITS5 болон NL4 гэсэн хос праймер ашиглан ПГУ хийж олшруулсан. ПГУ-г FastTag цомгийг ашиглан, GeneAmp PCR System 9700 машинд 94°C-д 2 мин (1цикл); 92°C-д 10 сек; 56°C-д 30 сек; 68°C-д 90 сек (30 цикл), 68°C-д 5 мин горимын дагуу явуулна. ПГУ бүтээгдэхүүнийг Accuprep® kit ашиглан цэвэршүүлж, нуклеотидын дарааллыг ZanaaSpex компаниар тодорхойлуулна. Нуклеотидын дарааллыг MEGA 10 программ ашиглан харьцуулалт хийнэ. Нуклеотидын дарааллыг MEGA 10 программ ашиглан харьцуулалт хийнэ. (Arbefeville et al, 2017; Tamura et al, 2013).

Мөөгөнцрийн биологийн идэвхийг тодорхойлох


Дээж бэлтгэх: Мөөгөнцрийн өсгөврийг 50 мл PDB шингэн тэжээлт орчинд 7 хоног сэгсрэгч ашиглан ургуулна. 7 хоног ургуулсны дараа өсгөврийн шингэн болон мицель хэсгээр нь 2 салгана. Үүний дараа өсгөврийн шингэн болон мицель хэсгийг тус бүр 25 мл органик уусгагч болох этил ацетат, гексан болон мөн адил хэмжээний хлороформоор (хлорофор/метанол 4:1) 3-н удаа хандлаад мөөгөнцрийн 2 хандаа хоёр тусад нь бэлтгэн авна. Дараа нь мөөгөнцрийн хандаа 30°C-д ууршуулаад 1 мл метанолд уусган хадгална.

Бактерийн эсрэг идэвх тодорхойлох: Эндофит мөөгөнцрийн бактерийн эсрэг идэвхийг үзэхдээ өмнө нь бэлтгэсэн мөөгөнцрийн өсгөврийн шингэн болон мицелийн ханд дээр үзнэ. Тест организмаар *E. coli* (SZMC 0582), *Pseudomonas aeruginosa* (SZMC 21886), *S. aureus* (SZMC 14532), *B. subtilis* (SZMC 14624), *Micrococcus luteus* (SZMC 6207) and *Streptomyces albus* (SZMC 0282) ашигласан. Мөөгөнцрийн өсгөврөө 4×10^5 cells/mL байхаар тооцоолоод 96-well plate дээр 24 цаг at 37°C өсгөвөрлөнө. Эерэг контролоор ампициллин ашигласан. Бактерийн эсрэг идэвхийг спектрометр 620 нм хэмжин тодорхойлно.

Мөөгөнцрийн эсрэг идэвх тодорхойлох: Мөөгөнцрийн эсрэг идэвх тодорхойлохдоо 4 тест организм *F. culmorum* (SZMC 11039), *R. solani* (SZMC 21048), *A. niger* (SZMC 0851) and *C. albicans* (SZMC 1533) ашигласан. Өсгөврөөс 6 мм диаметртэй блок зүсэж аваад, тест организмтай орчинд тавьж 28°C 48 цаг өсгөвөрлөсөн. Мөөгөнцрийн өсгөврийн эргэн тойронд үүссэн цэвэр хүрээг хэмжиж тодорхойлсон (Mounug, 2016).

Үр дүн

Эндофит мөөгөнцөр ялгах болон төрлийн хамаарлыг тодорхойлох: 4 дээж ургамлаас нийт *C. arvensis* (10), *H. salsuginosa* (12), *N. sibirica* (8) and *S. salsula* (10) 40 эндофит мөөгөнцрийн цэвэр өсгөвөр навч, иш, үндэс болон цэцгээс ялгаж авсан (Зураг 1).



Зураг 1. Дээж ургамлуудаас ялгаж авсан эндофит мөөгөнцрийн өсгөвөр

Мөөгөнцрийн өсгөврийн төрлийн хамаарлыг тодорхойлохдоо молекул биологийн аргаар тодорхойлсон. Түүнчлэн ген банкны мэдээллийн сантай харьцуулан төрлийн хамаарлыг тодорхойлов. Ингэхэд нийт 40 өсгөврүүд дараах 6 төрөлд хамаарагдаж байв. Үүнд: *Fusarium* (13), *Alternaria*

(17), *Didymella* (3), *Penicillium* (3), *Phoma* (3), болон *Camarosporidiella* (1). Мөөгөнцрийн төрлийн хамаарлыг тодорхойлоход *Alternaria* болон *Fusarium*. төрлүүд зонхилж харин *Camarosporidiella*, *Penicillium* болон *Phoma* төрлийн өсгөврүүд хамгийн бага байв.

Хүснэгт 2. Эндофит мөөгөнцрийн төрлийн хамаарлыг тодорхойлсон үр дүн.

Collection code	Closest relative based on sequence homology	Similarity (%)	GenBank accession No	Host plants
SZMC 26975	<i>Alternaria</i> sp.	99.0	MT134965	<i>S. salsula</i>
SZMC 26976	<i>Alternaria</i> sp.	98.0	MT134966	
SZMC 26977	<i>Alternaria</i> sp.	100.0	MT134964	
SZMC 26978	<i>Fusarium proliferatum</i>	100.0	MT134967	
SZMC 26979	<i>Fusarium redolens</i>	99.0	MT134968	
SZMC 26980	<i>Fusarium armeniacum</i>	99.0	MT134969	
SZMC 26981	<i>Didymella glomerata</i>	97.0	MT134970	
SZMC 26982	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134971	
SZMC 26983	<i>Fusarium oxysporum</i>	99.0	MT134972	
SZMC 26984	<i>Fusarium tricinctum</i>	96.0	MT134973	

Collection code	Closest relative based on sequence homology	Similarity (%)	GenBank accession No	Host plants
SZMC 26985	<i>Alternaria</i> sp.	99.0	MT134974	
SZMC 26986	<i>Alternaria</i> sp.	99.0	MT134975	
SZMC 26987	<i>Penicillium chrysogenum</i>	94.0	MT134976	
SZMC 26988	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134977	
SZMC 26989	<i>Fusarium proliferatum</i>	100.0	MT134978	
SZMC 26990	<i>Fusarium verticillioides</i>	88.0	MT134979	<i>H. salsuginosa</i>
SZMC 26991	<i>Didymella</i> sp.	97.0	MT134980	
SZMC 26992	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134981	
SZMC 26993	<i>Alternaria</i> sp.	91.0	MT134982	
SZMC 27024	<i>Alternaria alternata</i>	95.0	MT134983	
SZMC 27025	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134984	
SZMC 26996	<i>Alternaria</i> sp.	99.0	MT134985	
SZMC 26997	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134986	
SZMC 26998	<i>Penicillium chrysogenum</i>	98.0	MT134987	
SZMC 26999	<i>Fusarium chlamydosporum</i>	97.0	MT134988	
SZMC 27000	<i>Fusarium chlamydosporum</i>	99.0	MT134989	
SZMC 27001	<i>Fusarium oxysporum</i>	96.0	MT134990	<i>C. arvensis</i>
SZMC 27002	<i>Alternaria alternata</i>	99.0	MT134991	
SZMC 27003	<i>Alternaria alternata</i>	100.0	MT134992	
SZMC 27004	<i>Alternaria</i> sp.	99.0	MT134993	
SZMC 27005	<i>Phoma</i> sp.	99.0	MT134994	
SZMC 27021	<i>Didymella</i> sp.	99.0	MT134995	
SZMC 27033	<i>Fusarium</i> sp.	99.0	MT145329	
SZMC 27036	<i>Phoma</i> sp.	99.0	MT145332	
SZMC 27034	<i>Paraphoma chrysanthemicola</i>	99.0	MT145330	
SZMC 27006	<i>Penicillium rubens</i>	96.0	MT134996	<i>N. sibirica</i>
SZMC 27012	<i>Alternaria tenuissima</i>	99.0	MT134997	
SZMC 27035	<i>Camarosporidiella moricola</i>	99.0	MT145331	
SZMC 27007	<i>Fusarium verticillioides</i>	95.0	MT134998	
SZMC 27041	<i>Fusarium tricinctum</i>	100.0	MT134999	

Дээж ургамлуудаас ялгагдсан өсгөврүүдийг харьцуулахад *N. siberica* ургамлаас 3 *Fusarium*, 1 *Alternaria*, 2 *Phoma*, 1 *Penicillium*, 1 *Alternaria*, 1 *Camarosporidiella* төрлүүд илэрсэн бол Cui et al. судалгаагаар *Alternaria* and *Fusarium* төрлийн 24 өсгөвөр ялгагдсан байна. Уг судалгаатай харьцуулахад *Phoma*, *Penicillium*, and *Camarosporidiella* төрлүүд анх удаа бидний судалгаагаар илэрсэн байна.


Дээж ургамал *S. salsula* -ийн хувьд өмнө эндофит мөөгөнцрийн судалгаа хийгдэж байгаагүй ба бидний судалгаагаар 10 эндофит мөөгөнцрийн өсгөвөр уг ургамлаас ялгагдаж тэдгээр нь *Alternaria*, *Fusarium*, болон *Didymella* төрлүүд анх удаа илэрсэн байна.

C. arvensis ургамлаас өмнө нь 85 эндофит мөөгөнцрийн өсгөвөр ялгаж тэдгээр *A. alternata* (1), *A. flavus* (1), *A. parasiticus* (1), *F. oxysporum* (36), *F. solani* (1), *Macrophoma phaseolina* (1) and *S. kiliense* (2), *Acremonium rutilum* (1), *A. sclerotigenum* (3), *A. creber* (2), *A. terreus* (1), *F. oxysporum* (33), *F. solani* (1) болон *V. fungicola* (2) (Abdel-Sater et al. 2021) байв. Харин энэ судалгаагаар бид

Alternaria, *Penicillium*, *Fusarium*, *Phoma* and *Didymella* төрлүүд ялгав.

Halerpestes salsuginosa нь хараахан эндофит бичил биетний судалгаа хийгдээгүй байгаа бөгөөд энэ судалгаагаар *Alternaria* sp., *Penicillium*, *Didymella* болон *Fusarium* төрлүүд анх удаа уг ургамлаас ялгав.


Бактерийн эсрэг идэвх тодорхойлсон үр дүн: Энэхүү бактерийн эсрэг идэвхийг тодорхойлох туршилтад нийт 40 өсгөврийн 240 ханд бэлтгэн 6 тест организмын эсрэг үзсэн. Ингэхэд 3 өөр төрлийн органик уусгагчид хандалсан өсгөврүүдийн шингэн ханднууд нь мицелийн ханднуудаас илүү өндөр идэвхийг 6 тест организмын эсрэг үзүүлсэн (Зураг 2 and 3). Түүнчлэн, мөөгөнцрийн шингэн ханд болон мицелийн ханднууд бн тест организм дундаас *S. aureus* and *S. albus* -ийн эсрэг харьцангуй өндөр идэвхтэй буюу мөөгөнцрийн шингэн хандны 167, харин мицелийн хандны 175 ханд 80- 96.35% хооронд идэвх үзүүлсэн. Тэдгээр идэвх өндөр өсгөврүүдийг төрлийнх нь хувьд авч үзвэл ихэнх нь *Fusarium*, *Alternaria* болон *Didymella* төрлүүд байсан.



Зураг 2. Мөөгөнцрийн шингэн хандны бактерийн эсрэг үзүүлсэн идэвх (CB: хлороформд хандалсан мөөгөнцрийн шингэн ханд, EB: EtOAc-этил ацетатд хандалсан мөөгөнцрийн шингэн ханд, HB: гександ хандалсан мөөгөнцрийн шингэн ханд).

Нийт ханданд хэрэглэсэн 3 органик ханднаас гександ хандалсан мөөгөнцрийн шингэн ханд болон мицелийн хандууд 6 тест организмын эсрэг идэвх бага үзүүлсэн. Харин эсрэгээрээ этил ацетатад хандалсан мөөгөнцрийн ханднууд хамгийн сайн идэвхийг 6 тест организмын

эсрэг үзүүлсэн. Нийт 40 өсгөврөөс *F. tricinctum* (SZMC 27041) болон *F. armeniacum* (SZMC 26659) хоёр өсгөврийн 3 органик уусгагчид хандалсан шингэн болон мицелийн ханднууд хамгийн өндөр идэвхийг 6 тест организмын эсрэг үзүүлсэн байна.



Зураг 3. Мөөгөнцрийн мицелийн хандны бактерийн эсрэг үзүүлсэн идэвх (CM: хлороформд хандалсан мөөгөнцрийн мицелийн ханд, EM: EtOAc-этил ацетатад хандалсан мөөгөнцрийн мицелийн ханд, HM: гександ хандалсан мөөгөнцрийн мицелийн ханд).

Мөөгөнцрийн эсрэг идэвхийг тодорхойлсон үр дүн:

Мөөгөнцрийн эсрэг тестийн хувьд нийт 40 өсгөврийн 240 ханданд туршсан. Тест организмууд нь өвчин үүсгэгч *C. albicans*, филаментус мөөгөнцрүүд болох *A. niger*, *F. culmorum* and *R. solani*. Туршилтын дүнд этил ацетат хандны *D. glomerata* (SZMC 26649) өсгөвөр хамгийн том хүрээ буюу 23 мм -ийг *C. albicans* эсрэг үзүүлсэн бол дараагийн том хүрээ буюу 22 мм-ийг хлороформ хандны тухайн өсгөвөр болох *D. glomerata* (SZMC 26649) үзүүлсэн. Түүнчлэн *D. glomerata* (SZMC 26648, 26650, 26649), *Aspergillus* sp. (SZMC 26977), *A. tenuissima* (SZMC 27025) болон *F. redolens* (SZMC 26979) өсгөврүүд 4 тест организмын эсрэг харьцангуй өндөр идэвх өгсөн.

Харин зарим өсгөврүүд 4 тест организмаас 3-ийн эсрэг өндөр идэвхтэй байсан ба тэдгээр өсгөвөрт *Fusarium* sp. (SZMC 26656, 26660), *F. tricinctum* (SZMC 26657, 26984), *A. alternata* (SZMC 26651) болон *P. chrysogenum* (SZMC 26987) хамаарагдаж байв (зураг 4). Нийт 40 мөөгөнцрийн хандны идэвх өндөр өсгөврүүд нь төрлийн хувьд *Fusarium* болон *Alternaria* өсгөврүүд байсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь *C. albicans* -ийн эсрэг идэвхтэй байв. Хандалсан органик хандны хувьд авч үзвэл этил ацетатад хандалсан өсгөврүүд *A. niger* болон *R. solani* -ийн эсрэг идэвх үзүүлсэн бол ихэнх идэвх өндөр ханднууд нь хлороформын хандны өсгөврүүд, харин гександ хандалсан өсгөврийн ханднууд идэвх муу байсан.




Figure 4. Мөөгөнцрийн эсрэг идэвх үзүүлсэн үр дүн. HB-гександ хандалсан өсгөврийн шингэн ханд, HM-гександ хандалсан өсгөврийн мицелийн ханд, EB-этил ацетатад хандалсан өсгөврийн шингэн ханд, EM-этил ацетатад хандалсан өсгөврийн мицелийн ханд, CB-хлороформд хандалсан өсгөврийн шингэн ханд, CM-хлороформд хандалсан өсгөврийн мицелийн ханд

Дүгнэлт

4 дээж ургамлаас нийт *C. arvensis* (10), *H. salsuginosa* (12), *N. sibirica* (8) and *S. salsula* (10) 40 эндофит мөөгөнцрийн цэвэр өсгөвөр навч, иш, үндэс болон цэцгээс ялгаж авсан. Мөөгөнцрийн 40 өсгөврүүд *Fusarium*, *Alternaria*, *Didymella*, *Penicillium*, *Phoma Camarosporidiella* гэсэн 6 төрөлд хамаарагдаж байв. Үүнээс *Alternaria* болон *Fusarium* төрлүүд зонхилж *Camarosporidiella*, *Penicillium* болон *Phoma* төрлийн өсгөврүүд хамгийн бага байв.

Мөөгөнцрийн өсгөврийн шингэн ханд нь мицелийн ханднаас идэвхээр харьцангуй өндөр байв. *F. tricinctum* SZMC 27041 болон *F. armeniacum* SZMC 26659 өсгөврүүд 6 тест организмын эсрэг хамгийн өндөр идэвхтэй байсан. Харин мөөгөнцрийн эсрэг идэвхийн хувьд этил ацетатад хандны *D. glomerata* SZMC 26649 өсгөвөр хамгийн том хүрээг үүсгэсэн.

Ашигласан бүтээл

Aramsirirujiwet Y, Gumlangmak C, Kitpreechavanich V. (2016) Studies on antagonistic effect against plant pathogenic fungi from endophytic fungi isolated from *Hottuynia cordata* thunb. and screening for siderophore and indole-3-acetic acid production. *KKU Res. J.* 21:55-66.

Arnold AE. (2007) Understanding the diversity of foliar endophytic fungi: progress, challenges, and frontiers. *Fungal Biol. Rev.* 21: 51–66.

Arnold AE. (2008) Endophytic fungi: hidden components of tropical community ecology. In *Tropical Forest Community Ecology*, W.P. Carson and S.A. Schnitzer, eds. (West Sussex, UK: Wiley-Blackwell). 254–271.

Bálint M, Tiffin P, Hallström B, O'Hara RB, Olson MS. (2013) Host genotype shapes the foliar fungal microbiome of balsam poplar (*Populus balsamifera*). *PLoS One* 8(1): e53987.

Barka AE, Gognies S, Nowak J, Audran J-C, Belarbi A. (2002) Inhibitory effect of endophyte bacteria on *Botrytis cinerea* and its influence to promote the grapevine growth. *Biol. Control.* 24: 135-142.

Berg G. (2009) Plant–microbe interactions promoting plant growth and health: perspectives for controlled use of microorganisms in agriculture. *Appl. Microbiol. Biotechnol.* 84: 11-18.

Brown ED, Wright GD. (2016) Antibacterial drug discovery in the resistance era. *Nature* 529: 336-343.

Cao Y, Fu D, Liu T, Guo G, Hu Z. (2018) Phosphorus solubilizing and releasing bacteria screening from the rhizosphere in a natural wetland. *Water* 10: 195.

Chadha N, Prasad R, Varma A. (2015) Plant promoting activities of fungal endophytes associated with tomato roots from central Himalaya, India and their interaction with *Piriformospora indica*. *Int. J. Pharm. Bio. Sci.* 6: 343–333.

УНГАРЫН ТАРКАНЬ СЮЧЬ ЭРНЮГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Богнар Сабина

*(Унгар улсын HUN-REN судалгааны хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан)*

Эрдэм шинжилгээний хурлын эрхэм төлөөлөгчид өө!

Та бүхэнд Таркань Сючь Эрнюгийн нэрэмжит Эрх зүйн соёлын түүх, эрх зүйн угсаатны зүйн судалгааны багийн ажлыг богино хэмжээний киногоор танилцуулахдаа таатай байна. Энэхүү кино нь судалгааны багийн хамгийн сүүлийн үеийн үр дүнгийн талаар мэдээлэл өгөх болно.

Tárkány Szücs Ernő Kutatócsoport - PTE UNIVTV (4.57 perc) <https://www.youtube.com/watch?v=FSxSIGs1acg>

2021 онд Таркань Сючь Эрнюгийн судалгааны баг байгуулагдсаны 10 жилийн ойг тэмдэглэсэн. Ильеш Дьюлагийн нэрэмжит байсан Пичийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн Сексард хотын факултетьд 2011 оны 10 дугаар сарын 5-нд таван их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсад болон Унгар улсад алдартай эрх зүйн угсаатны зүйч Таркань Сючь Эрнюгийн нэрээр нэрлэгдсэн эрх зүйн соёлын түүх, эрх зүйн угсаатны зүйн судалгааны баг байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэхүү баг нь зөвхөн нэрээр нь нэрлэгдээд зогсоогүй түүний оюуны өвийг чухалчлахыг зорьсон. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд 10 удаагийн эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, мөн төдий

хэмжээний шинжлэх ухааны ботийг хэвлүүлэн гаргасан. Арван удаагийн эрдэм шинжилгээний хурлын дийлэнх нь Олон улсын чанартай хурлууд байсан. Өнгөрсөн жил манай судалгааны баг байгуулагдсаны 10 жилийн ойг тэмдэглэснээс гадна Таркань Сючь Эрнюгийн 100 жилийн ойг тэмдэглэсэн. Энэхүү хоёр ойн арга хэмжээ нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд биднийг маш их эрчимжүүлж, үр дүнтэй ажлуудыг хийхэд ихээхэн түлхэц болсон. Мөн ойн баярын хүрээнд бид 3 боть ном хэвлүүлсэн. Эхнийх нь манай судалгааны багийн цуврал номын 10 дахь боть, дараагийнх нь Таркань Сючь Эрнюгийн судалгаануудыг англи, герман хэл дээр хэвлүүлсэн. Мөн түүний эрдэм шинжилгээний ажил бүтээл нь англи, герман хэл дээр хэвлэгдэн гарсан.

Манай судалгааны баг Тештаментум сантай ажиллах хамтын ажиллагааг маш чухал гэж үздэг. Учир нь энэхүү сангийн удирдах зөвлөлд Таркань Сючь Эрнюгийн хүү Др.Таркань Сючь Аттила байдаг. Ойн арга хэмжээг зохион байгуулахад Тештаментум сангийн тусламж дэмжлэг бидэнд хэрэгтэй байсан. Хоёр ойн арга хэмжээний хүрээн дэх Эрдэм шинжилгээний хурлыг Таркань Сючь Эрнюгийн төрөлх хотод зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний хурал маань өнгөрснийг дүгнэж, ирээдүйд хийх

ажлын төлөвлөгөөгөө хэлэлцсэн хурал болсон. Өнгөрснийг хэлэлцэхдээ бид судалгааны түүх болон үр дүнг толилуулсан. Мөн судалгааны багийн гишүүдээ танилцуулан, тэдэнд дурсгалын батламжийг гардуулсан.

Эрдэм шинжилгээний хурлын үеэр Таркань Сючь Эрнюгийн нэрэмжит медалийг Хуудмезө-вашар-хэйгийн судалгааны төвийн судлаач Тиборт гардуулсан. Эрх зүйн соёлын түүх, эрх зүйн угсаатны зүйн судалгааны чиглэлээр эвлэлдэн нэгдсэн олон нийтийн зүгээс энэ чиглэлээр бүтээсэн ажлыг минь үнэлж, Таркань Сючь Эрнюгийн 1-р зэргийн медалийг надад олгосон нь маш том хүндэтгэл юм.

Шинжлэх ухааны салбаруудын хамтын ажиллагааны хүрээнд зөвхөн эрх зүйн түүхээс гадна эрх зүйн угсаатны зүйг шинээр гаргаж ирснээрээ онцлогтой юм. Бидний цаашдын судалгаанд түүхийн шинжлэх ухаан маш том боломжийг олгож байна. Энэ ташрамд, мэргэшсэн, олонд танигдсан судалгааны баг хамт олныг, түүний дотроос их сургуулиудын профессоруудыг мөн онцлох хэрэгтэй бөгөөд Таркань Сючь Эрнюгийн эрх зүйн соёлын түүх, эрх зүйн угсаатны зүйн судалгааны баг өнгөрсөн цаг хугацаанд бүтээсэн ажлынхаа үр дүнд Унгарын шинжлэх ухааны салбарт болон олон улсын шинжлэх ухааны тавцанд өөрийн гэсэн онцлог байр суурийг эзлээсэй гэж хүсэж байна.

Таркань Сючь Эрнюгийн судалгааны баг нь эрдэмтэн судлаачдад нэн

шаардлагатай мэргэжлийн орчин, хамтын сэтгэлгээ болон цааш хөгжих боломжийг олгодог. Миний бодлоор өнгөрсөн 10 жилийн хугацаанд дотоодын судалгааны баг бөх бааз суурь тавигдаж, харилцан бие биенээ дэмжсэн, маш өргөн хүрээтэй хамтын ажиллагаа бий болсон: Энэ хүрээнд бид хууль зүй, түүх, угсаатны зүйн эрдэмтэн судлаачдаас ихийг сурах боломж бүрдсэн. Бидний туулж өнгөрүүлсэн 10 жилийн туршлага, арга барил дээр тулгуурласан хамтын ажиллагаа, судалгааг ирэх 10 жилд Олон улсын тавцанд гаргахад хангалттай гэдэгт бид итгэлтэй байна.

Олон улсын хамтын ажиллагаа түүн дотроос Монгол улстай холбоотой хамтын ажиллагаа нь онцгой байр суурийг эзэлдэг. 1922 онд Тагани Карой тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль эрх зүй, зан үйлийн талаарх Олон улсын судалгааны ажлын хураангуйг герман хэл дээр нийтэлсэн. Таганийн бүтээлд эртний Монголын зан үйл, эрх зүйтэй холбоотой монгол хэлний нэр үгс жаран найман удаа тэмдэглэгдсэн байдаг. Мөн Таркань Сючь Эрню нэр үгсийн шинж чанарыг судалж үзээд монголчуудын нөлөөлийг тодорхойлсон. Тиймээс бид эрх зүй, угсаатны зүй, түүхийн шинжлэх ухааны чиглэлээр хамтран ажиллах мэргэжил нэгт судлаачдыг тэсэн ядан хүлээж байна!

Манай судалгааны багийн 34 гишүүн болон гадаадын 4 хүндэт гишүүнийхээ нэрийн өмнөөс та бүхэнд талархал илэрхийлье!

УНГАРЫН МЭНДЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

Кишш Роберт Рихард

(ЭЛТЕ Их Сургууль, Орчин үеийн Унгар хэлний тэнхимийн багш)

Сайн байцгаана уу, эрхэм Монгол анд нөхдөө? Эрдэм шинжилгээний хуралд оролцож буй хүн бүхнийг бурхан өршөө! Энэ бүгдийг орчуулахад нэлээн хүндхэн байж магадгүй.

Унгар хэлэнд маш олон мэндчилгээний төрлүүд байдаг. Дэлхийн ард түмний хэлүүдтэй харьцуулан үзэхэд унгар хэлэнд илүү олон төрлийн мэндчилгээ байдаг гэж хэлж болно. Энэ бүхэн хэрхэн яаж бүрэлдсэн бэ гэдэг нь сонирхолтой бөгөөд бид бусад хэлнээс мэндчилгээний олон хэллэг, хэлбэрийг авахын зэрэгцээ шинээр олон хэллэг, мэндчилгээг бий болгон хэрэглэж байна.

Намайг Киш Роберт Рехард гэдэг. Та бүхний амар амгаланг айлтган мэндчилье! Би 1989 оноос хойш Унгарын мэндчилгээний төрлүүд түүний хэрэглээний талаар судалж байгаа бөгөөд боловсролын докторын зэргээ энэ сэдвээр хамгаалсан. Түүнээс хойш олон жил энэ чиглэлээр Етвөш Лорандын Шинжлэх Ухааны сургууль болон бусад их, дээд сургуулиудад багшилж байна.

Ахой энэхүү мэндчилгээг слав хэлнээс авсан бөгөөд хил орчмын унгарчууд илүү хэрэглэдэг. Би Шопроны ойролцоох жижиг хотод төрсөн бөгөөд тэнд герман хэлнээс гаралтай **Чүүс** гэдэг мэндчилгээг хэрэглэдэг. **Сэрвүүс** гэдэг мэндчилгээ маань латин хэлнээс гаралтай бол **Сиа** бол латинаас герман хэлээр дамжин орж ирсэн. **Сиа**-г ихэнх хүмүүс англи хэлнээс гаралтай гэж

боддог ч энэ хэллэг нь унгар хэлэнд түүнээс ч өмнө хэрэглэгддэг байсан. Үүнээс гадна бид англи мэндчилгээний үгсийг бас ашигладаг. Тухайлбал, **Hello** гэдэг мэндчилгээ. Энэхүү хэллэгийг уулзах бас салж явахдаа аль алинд нь хэрэглэдэг болохоор хэзээ ч хэрэглэж болох мэндчилгээ юм. Унгар хэлэнд өөр сонирхолтой мэндчилгээний хэлбэрүүд ч маш их байдаг. Жишээлбэл: **Пүси, пүсок, ча, чао, сиука** гэх мэт халуун дулаан өнгө аястай мэндчилгээний хувилбарууд байдаг. Мэндчилгээний хэлбэр нь янз бүрийн нөхцөл байдал, орчинд хэрэглэгддэг учраас маш олон төрлийн эх сурвалжаас судлах шаардлагатай болдог.

Мэндчилгээ нь унгар хэлэнд тодорхой байр суурийг эзэлдэг. Мэндчилгээний гарал үүсэл нь маш их сонирхолтой. Учир нь хүй нэгдлийн үед мэндчилгээ нь аливаа харилцааны үед амьд гарах нэгэн боломж байсан. Дохио зангаагаар харилцдаг аман болон аман бус мэндчилгээний хувилбар ч байсан. Тухайлбал, гараа өргөн мэндлэх нь надад дайсагнах санаа байхгүй, миний гарт ямар нэгэн зэвсэг байхгүй гэдгийг илтгэдэг. Тэгэхээр мэндчилгээ нь хүй нэгдлийн үед амьд явах баталгааны нэг хувилбар байсан гэж хэлж болно. Хэрвээ мэндэлвэл хэн ч биднийг алахгүй эсвэл бид хэнийг ч алахгүй гэсэн үг юм. Дараагийн чухал мэндчилгээ бол тэврэлт. Тэврэлт нь нөгөө хүнд зэвсэг байхгүйг бүрэн баталгаажуулах “үйл явц” байсан гэж болно. Түүнээс хойш хүн төрөлхтний

түүхэнд маш олон мэндчилгээний хувилбар бий болсон.

Ромын үед *Аавэ* гэдэг мэндчилгээг эзэн хаантай мэндлэх үед хэрэглэдэг байсан. Дундад зууны үед өөр хоорондоо бичсэн захидлууддаа сайн сайхан, энх тайвныг хүсэн ерөөдөг байсан. Тухайлбал: *Бурхан чамтай хамт байг, Бурхан чамайг эрүүл энх байлгах болно* гэх мэт.

Үгэн мэндчилгээ нь яваандаа нийгмийн гарал үүслийг илтгэгч харилцааны чухал хэрэгсэл болсон. Тухайлбал: *Сервус Хүмелиниус буюу дорд боол бивээр* гэдэг мэндчилгээний хэлбэр байна. Тэгэхээр нийгмийн бүлгүүдийн харилцаанд давхаргаас хамаарсан мэндчилгээний хэлбэр хэрэглэгдэж ирсэн. Өөрөөр хэлбэл, захирах захирагдах нийгмийн давхаргуудын хооронд мэндчилгээний хувилбарууд өргөнөөр хэрэглэгдэх болсон ба эдгээрээс гаралтай хэллэгүүд өнөөдөр ч хэрэглэгдсээр байгаа. Шимой Жигмондын тодорхойлсноор, тэдгээр нь мэндчилгээний тогтмол хэлбэрүүд бөгөөд нэг нэгнийгээ хүндэтгэсэн сайн харилцааны эхлэл тавих үүднээс хэрэглэгддэг хувилбар юм.

XIX зууны төгсгөл, XX зууны эхний хагас хүртэл дээр дурдсан мэндчилгээний хувилбар нь ахмад үеэс залуу үед өвлөгдөн хэрэглэгдэж байсан. Дэлхийн хоёрдугаар дайны дараах нийгмийн давхаргуудын өөрчлөлтүүдтэй холбоотойгоор мэндчилгээний хувилбаруудад ч өөрчлөлтүүд гарсан. Уламжлалт мэндчилгээний хувилбаруудын хэрэглэгдэхүүн багасаж, заавал хэрэглэгдэх мэндчилгээний хувилбарууд унгар хэлэнд хэрэглэгдэж эхэлсэн. *Эрх чөлөө, Урагшаа* гэсэн үгс мэндчилгээнд

томоохон байр суурийг эзлэх болсон. Тухайн үеийн улс төр, нийгмийн зохион байгуулалт нь мэндчилгээнд нөлөөлсөн. Залуу үеийнхэн ч ахмад үеийнхэндээ мөн мэндчилгээний хувилбаруудыг дамжуулдаг гэдгийг бас бид судалсан.

Унгар хэлний бас нэг онцлог нь ахмад үеийг хүндэтгэн *Та*, нас чацуу хүмүүсийг *Чи* хэмээн дуудаж харилцах юм. Энэ нь мэндчилгээнд бас чухал үүрэгтэй байдаг. Сонирхолтой нь, Домоко Агнешийн судалгаагаар 5-аас дээш насны хүүхдүүд эцэг эхээ *Та* гэж мэндчилж байсан бол өсвөр үеийнхэн *Чи* гэсэн хувилбарыг өргөнөөр ашигладаг байна. Залуу үеийнхний дунд мэндчилгээнүүд нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Өнөөдөр залуу үеийнхэн маань ахмад үеийнхэндээ илүү их мэндчилгээний хувилбаруудыг зааж өгч байгаа нь ажиглагдаж байна. Мэндчилгээ нь хүмүүсийн харилцаанд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, анх удаагаа уулзаж байгаа бол өөрөөр мэндчилж, таньдаг хүнтэйгээ уулзаж байгаа бол арай өөрөөр мэндчилдэг.

Судалгаагаар, унгар хэлэнд 200-аас олон мэндчилгээний хувилбар байдаг бөгөөд бид тийм олон төрлөөр нэг нэгэнтэйгээ мэндэлдэг гэсэн үг. Тухайн нөхцөл байдал, орчин, нэг нэгнийгээ хэр таних, телевизээр юу үзсэн гэх мэтээс шалтгаалж, олон хувилбарыг ашигладаг. Тогтмол хэрэглэгддэг мэндчилгээнүүд байдаг ч тэдгээрийн хувилбарууд нь Шинжлэх ухааны салбарын судлах ёстой нэгэн онцгой сэдэв байж болох юм.

Миний үзэж байгаагаар мэндчилгээ нь харилцааны эхлэл болон төгсгөлийг илэрхийлэгч хэрэгсэл юм. Мөн нийгмийн харилцааны гол хэлбэр. Мэндлэх хүний нас, хүйс, нийгмийн

давхарга, албан тушаал, харилцаа үүсэж буй газар, орчин зэргээс шалтгаалж мэндчилгээ нь олон төрөл байна. Орчин нөхцөлөөс шалтгаалан янз бүр байдаг мэндчилгээ нь харилцааны эхлэл болон төгсгөлийг нэгэн зэрэг илтгэх боломжтой. Тухайлбал, кино театрт, олон хүн цугласан газар үүссэн мэндчилгээний харилцаанд уулзах болон салж явахдаа хэлдэг мэндчилгээг нэгэн дор ашигладаг. Энэ нь мэдээлэл солилцох харилцааг үүсгэхгүй, зөвхөн мэнд эрэх мэндчилгээний богино хувилбар юм.

Албан тушаалаас хамаарсан мэндчилгээний хэлбэрүүд орхигдож байгаа гэхдээ тухайн хүний насны байдлаас шалтгаалсан мэндчилгээний хувилбар чухал үүрэгтэй хэвээр байгаа. Нас чацуу хүмүүстэй эсвэл ахмад хүнтэй мэндлэх нь онцлогтой хэвээр байгаа.

Унгар хэлэнд мэндчилгээг орлуулагч үгс байдаг. Дээр өгүүлсэн мэндчилгээний 200 үгэнд тэдгээр үгсийг оруулаагүй болно. Мэндчилгээг орлуулах үгс тоолохын аргагүй олон байдаг. Унгар хэлний мэндчилгээний судалгаа, түүний ангилал зэрэг нь олон жилийн түүхтэй, эртнийх юм. Унгар хэлний мэндчилгээний судалгаан дээр П.Төрөк гэдэг хүн 1897 онд ажиллаж байсан. Тэрээр мэндлэх хэсгийг онцлон судалсан. Кертис Мону өөрийн гэсэн монографийн аргаар мэндлэх ёсыг судалсан. Ноён, зарц гэсэн давхарга бүхий нийгэмд мэндчилгээ чухал үүрэгтэй байсан. Дэлхийн 1,2-р дайны хооронд мэндчилгээний чиглэлээр судалгаанууд нэлээн хийгджээ. Гэхдээ эдгээр нь Шинжлэх ухааны үүднээс бус голдуу өөрсдийн туршлага дээрээ үндэслэсэн судалгаанууд байсан. Ийм

хэлбэрээр мэндчилгээний этимологи судалгаа явагддаг байсан. Тэгэхдээ тухайн үед л өөрсдийн туршлага дээр үндэслэдэг байсан бол хэсэг хугацааны дараа шинжлэх ухаанчаар хандах болсон байна.

Унгар хэл өнөөдөр өмнө хэрэглэгдэж байгаагүй мэндчилгээний хэлбэрүүдээр баяжсан байна. Тухайлбал, **Гарыг чинь үнсье!** Энэхүү мэндчилгээ Мария Терезия хатан хааны үеэс дэлгэрсэн мэндчилгээ. Австри, Унгарын хаант улсын үед хүндэтгэлийн мэндчилгээний энэ хувилбар нь эхэндээ ихэс дээдсийн бөгжийг үнсэж мэндчилдэг байсан бол сүүлдээ гар үнсдэг болсон. Энэ нь явсаар **Гарыг чинь үнсье** гэсэн мэндчилгээ болсон. Үүнийг эхэндээ эмэгтэйчүүд, бүсгүйчүүдэд хүндэтгэлийн хэлбэрээр хэрэглэдэг байсан бол одоо үед залуу бүсгүйчүүд ахмад багшийгаа хүндэтгэн хүйс харгалзахгүйгээр хэрэглэх болсон. Тэгэхээр өнөөдөр эдгээр мэндчилгээний хувилбарын анхны утга санаа байхгүй болсон гэсэн үг. Үүнээс үзвэл, Унгар хэлэн дэх хүндэтгэлийн хэллэг, мэндчилгээний үгс нь байнга хувьсан өөрчлөгдөж, хөгжиж байна.

Угсаатны зүйн хувьд мэндчилгээний хувилбаруудыг судалж үзэхэд, өмнө дурдсан 200 мэндчилгээг нас, хүйс, боловсрол нийгмийн давхарга, орчин зэргээс шалтгаалж янз бүрээр ашигладаг байна. Өдрийн аль цагт байгаагаас хамааран мэндчилгээнүүд өөр өөр байдаг бол мөн шашин шүтлэгээс шалтгаалсан мэндчилгээнүүд ч байдаг. Мөн Унгарын нутаг тус бүрт мэндчилгээнүүд нь өөр өөр байхаас гадна хилийн чанад дахь унгарчуудын хувьд өвөрмөц мэндчилгээний хувилбарууд байдаг. Нийгмийн давхаргын бүлгүүд дотор тухайлбал, оюутнуудын дунд

өдөр тутмын маягийн мэндчилгээний хувилбарууд өргөн дэлгэрсэн байдаг.

Орон нутгийн гэмээр зарим мэндчилгээнүүд ч өргөн тархсан байдаг. Тухайлбал, Унгар, Австрийн хилийн ойролцоох Шопрон хотын мэндчилгээнүүд дээр бид нэлээд өргөн хүрээтэй судалгаа хийсэн. Тэнд л гэхэд сургуулийн орчинд залуу үеийнхний дунд уламжлалт, тогтсон мэндчилгээнээс гадна өвөрмөц хувилбаруудыг ч мөн ашигладаг. Залуучуудын дундах **Чао, Hello, Сув, Суйка** гэх мэт уламжлалт бус мэндчилгээний хувилбаруудыг олныг жагсааж болно. **Пуси-үнсье** гэх мэт... Мэндчилгээ нь өгүүлбэр дотор ямар утга илэрхийлж буйгаас шалтгаалж бас янз бүрийн үүрэгтэй байдаг. Тэгэхээр мэндчилгээ нь өгүүлбэрийг эхлэл, төгсгөлөөс шалтгаалан өөр өөр байдаг гэж хэлж болно.

Уламжлалт мэндчилгээнүүд нь цаг үеэсээ шалтгаалан анхны утгаа бүрэн алдсан тохиолдол олон байдаг. Тухайлбал, **Гарыг нь үнсэе, Дорд боол бивээр** гэх мэт. 1990 оноос хойш унгар хэлэнд маш олон шинэ мэндчилгээний хувилбарууд бий болсон. Тухайлбал, мэргэжлийн мэндчилгээний үгс, цэргийн, эмч нарын, улс төрийн мэндчилгээ гэх мэт шинэ үгсээр баяжсан. Мэдээж хэрэг цаг хугацааны шалгуураар мэндчилгээний зарим үгс ор сураггүй үгүй болдог. Хэдийгээр мэндчилгээний үгс устаж үгүй болж буй ч гэсэн шинэ үгсээр баяжаар байдаг. Судалгаагаар тогтоогдсон мэндчилгээний 200 үгийг хүн болгон мэддэг, олон нийт өргөн хэрэглэдэг учир унгар хэл баялаг юм. Хүн бүр өдөр тутамдаа ашигладаггүй ч гэсэн мэндчилгээний үг гэдгийг хүн болгон мэддэг.

Утга зохиолын хэлэнд 210-220 мэндчилгээний үгс байгааг бид судлан тогтоосон. Энэ нь, унгар хэл нь өдөр тутмын мэндчилгээний үгсээс гадна утга зохиолын хэлний мэндчилгээний үгсээр баялаг гэдгийг харуулж байна. Дахин тодотгож хэлэхэд мэндчилгээг орлуулах үгс унгар хэлэнд тоолохын аргагүй олон байдаг.

Интернет хөгжсөн энэ үед мэндчилгээний үгс цөөрөөгүй харин улам нэмэгдсээр байна. Үүнийг дагаад залуучуудын хэрэглэдэг бичгийн мэндчилгээ нь аман мэндчилгээнээсээ илүү их болж байгааг судалгаанууд харуулж байна. Аман болон утга зохиолын мэндчилгээнээс гадна захианы мэндчилгээ мөн байдаг. **Өдрийн мэнд хүргэе, Szia, Hello, Chao** гэсэн мэндчилгээнүүдийг өргөнөөр ашиглагдаж байна. 1962 онд Жон Аустины хийсэн судалгааг авч үзвэл, үг нь өгүүлбэрт тодорхой ойлголтыг илэрхийлдэг бол мэндчилгээний үгс нь тодорхой үйл явцыг эхлүүлдэг гэжээ. Жишээлбэл, **Өдрийн мэнд, Баярлалаа** гэх мэт.

Аман болон аман бус мэндчилгээнүүд өөр өөрийн онцлогтой байдаг. Гараа өргөж мэндлэх нь сайныг хүсэх ба нөгөө талаас зэвсэггүй гэдгээ илтгэдэг гэдгийг бид дээр дурдсан. Баяр хүргэх эсвэл санал нийлэх үед гар барин мэндэлдэг. Гар барин мэндлэх хэлбэрийг зарим улсад хэрэглэгдэггүй ч Унгарт өргөн хэрэглэгддэг. Улс орнуудын соёл уламжлал, хувь хүний орон зайнаас шалтгаалж мэндлэх ёс нь өөр өөр байдаг. Америкчуудын хувьд мэндлэх, гар барих үед тодорхой зайтай зогсох шаардлага үүсдэг. Япончуудтай мэндлэх үед гар барихгүй мэхийн ёсолдог мэндчилгээ дэлгэрсэн байдаг.

Гарын алгыг дээшээ эсвэл доошоо харуулан мэндлэх нь зэвсэггүй гэдгийг илтгэх мөн сайн сайхныг хүссэн мэндчилгээ юм. Мөн нэг нэгнийхээ тохойг барин мэндлэх ёсон бас байдаг. Үнсэж мэндлэх ёсон бас байдаг. Нэг эсвэл хоёр удаа үнсэж мэндлэх нь зарчмын хувьд мөн ялгаатай.

Эцэст нь дүгнэн хэлэхэд, унгар хэлэнд 200-аас илүү мэндчилгээний

хувилбар байдаг төдийгүй тэднийг орлуулах үгсийн тоо бас тоологдошгүй их байдаг. Та бүхний сонирхлыг татсан гэж найдаж байна. Баяртай. Та бүхний цаашдын энэ өдрийн ажилд амжилт хүсье. **Чүүс, Ахой, Вислат, Чао** та бүхэн Унгарын баялаг мэндчилгээнүүдээс өөртөө хамгийн дотно санагдаж буйг сонгоорой.

УНГАРЫН СУДЛААЧ БАЛИНТ ГАБОРЫН МОНГОЛ НУТГААР АЯЛСАН ЗАМЫГ ТОДРУУЛАХ НЬ

Ш.Мөнхбаатар

(Чингис хааны өв соёлын хүрээлэн)

1873 онд Унгарын судлаач, хэл шинжээч Балинт Габор монгол нутагт ирж хээрийн судалгаа хийжээ. Тэрбээр монголчуудын аман түүх, үлгэр домог, ёс заншил, ахуй амьдралтай холбогдох мэдээ баримтыг цулгуулаад буцсан байна. Энэ түүхэн үйл явдал одоогоос 150 жилийн өмнө болжээ. Уг илтгэлд түүний монгол нутагт ирсэн замыг хуучнаар аль хошуу, өнөөгийн ямар аймаг, сумын нутаг болохыг тодруулахыг зорилоо.

Балинт Габор 1844 оны 3 дугаар сарын 13-нд Трансильваны Кээдивашархэйний дэргэдэх Сэнткатолнад мэндэлжээ. Бага наснаас эхлэн гадаад хэл сурч эхэлсэн бөгөөд хэлний авьяастай хүүхэд байв. Тэрбээр 1856 онд Кээдивашархэйн дунд сургуульд сурч хичээлийнхээ хажуугаар грек, франц, итали хэлийг эзэмшин, Трансильваны бусад хотод байдаг араб, еврей, түрэг, перс зэрэг хэл мэддэг хүмүүсийг олж уулзан хэлийг нь сурч байжээ.²³ 1866 онд Унгар хэлний толь бичгийн зохиогч Фогараши Яаноштай танилцаж монгол хэл сурч эхэлсэн байна. Энэ нь түүнийг хожим монгол нутагт ирж хээрийн судалгаа хийх суурийг тавьсан бололтой.

1871 онд Балинт Габор Халимаг, Баруун Монгол, Казаний Татарт очиж угсаа гарвал, хэл, соёлын баримт цуглуулж фин-угор хэлийг судлах

болсон байдаг. 1872 оны 5 дугаар сарын 12-нд галт тэргээр Астраханаас Санкт-Петербургт хүрчээ. Түүний захидлаас үзвэл Монголд очих сонирхолгүй байсан нь харагддаг. Тэрбээр “Санкт-Петербургт монгол, угор хэлийг сурч болохыг өгүүлсэн бөгөөд Монголд очих шаардлагагүй”²⁴ гэж үзсэн байна. Гэвч 1873 оны 4 дүгээр сард намар Монгол нутаг руу явах болжээ. Түүний аян замын тэмдэглэлд “Эрхүү, Хиагт, Маймаачин, Ерөө гол, Шарын гол, Төхөмийн даваа, Хараа гол, Бургалтай, Өргөө” гэсэн нэр тодорхой дурдагдсан байдаг. Эдгээр нэр бол өртөөний нэр юм. Өртөө бол тогтсон зам, чиглэлтэй, тусгай албан хаагчтай, тэднийг захирах зангитай, эзэмшил газар нутагтай, тусгай хуулиар зохицуулагдсан элч төлөөлөгчийн замдаа бууж амрах, унаа морь сэлгэх, хоол унд хэрэглэх журамтай, харилцаа холбооны үүрэг бүхий газар юм.

1759 онд Хүрээнээс Хиагтын хооронд өртөө байгуулжээ. Үүнд Хүй (küi), Бургалтай (burgaltai), Булган толгой (bulgangtolugai), Баян баруухай (bayangbaruqai), Хараа гол (qaragool), Номт (nomtu), Дэрс булан (dersübulang), Ерөө гол (erügool), Нарийн могой (naring mogai), Гялаан нуур (gilang nuur) гэсэн 11 өртөө байсан юм. Эндээс өртөө тус бүрийн

²³ *Бирталан Агнеш. Чингис хааны цагаан сэтгэлт ард түмэн. УБ., 2016. т. 37*

²⁴ “*Visszatértem után pedig a khalymik népnyelvet kell megismertetnem német nyelven.*”
In: Akadémiai Értesítő VI. p. 209 (cf. Kara: Bálint Gábor keleti levelei.).

байршлыг Хүрээнээс Хиагт гэсэн байдлаар нягталж үзвэл:

1. Хүй өртөө. Хүрээнээс Хиагт хүрэх эхний өртөө Хүй юм. Тус өртөөний тухай П.Кафаров “Толгойтын даваанаас буухад нэгэн гол таарсныг Хүйн гол гэх ажээ. Голын эргийн нуга даган явсаар, аажмаар баруун хойшоо эргэн голоос нэлээд алдарсан хойноо нэгэн өртөөнд дээр ирвэл Хүйн өртөө юмсанж”²⁵ гэжээ. Харин А.Позднеев “Рашаантын голын хөндий рүү буухад замын баруун талд Гахай уул тосно. Рашаантын голын хөндий үргэлжилсээр Хүйн хөндийтэй нийлэх бөгөөд Хүрээнээс Хиагтын эхний өртөө болох Хүйн өртөө уг голын эрэгт оршдог юм”²⁶ гэж тэмдэглэжээ. А.Позднеевын дурдах Гахай уулыг БНМАУ-ын Геодези, зураг зүйн газраас гаргасан 1:125.000 масштабтай 1986 оны Төв аймгийн Батсүмбэр сумын нэрийн зурагт тэмдэглээгүй байна. Хэдий тийм боловч Хүй өртөө Батсүмбэр сумын нутагт Улаанбаатар хотоос чанх хойд зүгт 38 км зайтай Тасархай толгойн урд талд, Мөөгтийн амны зүүн талд Хүйн нуурын баруун дэнжид байрлана. Хүй өртөөний буудалдаг газар Хүрээ нутаглаж байсны тэмдэг болгон хөшөө босгожээ.

2. Бургалтай өртөө. П.Кафаров “Өлийн даваанаас Бургалтайн хөндий рүү буухад байгаль нь хачин сайхан,

хөрс нь улаавтар өнгөтэй. Өртөөний баруун талаар Бургалтайн гол өмнө зүг рүү урсана”²⁷ гэж өгүүлсэн байдаг. Бургалтай өртөө өнөөгийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Шанагын Зүүн уулын урд, Бургалтай голын хойд хөндийд байрлаж байжээ.²⁸ Хүй өртөөнөөс Бургалтай өртөөнд хүрэхэд гол гэтэлж, намаг шавар, өндөрлөг газраар явдаг тул бартаа ихтэй гэж ойлгож болно. Энэ нь Хүйн өртөөнөөс баруун хойд зүгт 18 км зайтай ажээ.

3. Хунцал өртөө. Архивын баримтад Бор нуур (boru nuur)²⁹ гэж тэмдэглэжээ. “Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс”-нд тус өртөөг Булган толгой (buluyangtoluyai)³⁰, Хүрээний хойдох 11 өртөөний цэсэнд Булган толгой (bulayangtoluyai)³¹, “Энэ нэгэн дэвтэр”-т Булган толгой (bulayangtoluyai)³² гэж тус тус бичжээ. Н.Я.Бичурин 1821 оны 7 сарын 21-ний өдөр тус өртөөгөөр дайран явсан байдаг. Түүний тэмдэглэлд “30 орчим ли яваад уул давж нэргүй жижиг нуурын дэргэдэх Хатцэль (Хунцал) хэмээх эдлэнд (өртөөнд Ш.М.) буудаллав. Энд айлын бууц зөндөө байсан бөгөөд суурьшигчид хангалттай олон гэдэг нь илэрхий. Би салхилахаар хусан ойтой уулаар алхав. Нууранд олон ангир хөвж явна”³³ хэмээн өгүүлдэг. Түүнтэй хамт явсан Игорь Тимковский мөн л “1821 оны 7 сарын 21-ний 4

²⁵ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 223

²⁶ А.Позднеев. Дорожня замьтки на пути по Монголии въ 1847 и 1859 гг. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ. 1892. стр. 227

²⁷ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 224

²⁸ Төв аймгийн Батсүмбэр сумын газар нутгийн нэрийн зураг. УБ., 1983

²⁹ Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. ХМ-146, Д-1, ХН-4, 9, 10, 11,

³⁰ Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс. Эмхэтгэсэн Ш.Нацагдорж, Ц.Насанбалжир. УБ., 1962. т. 22

³¹ Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. ХМ-1, Д-1, ХН-5748, Ну-38.

³² Ene nigen debter amui. Галиглаж хөрвүүлсэн Ж.Гэрэлбадрах. УБ., 2006. т. 147

³³ Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2019. т. 68

цагт бид Хунцал өртөөнд хүрч ирэв”³⁴ хэмээн бичжээ. Түүнээс 26 жилийн дараа 1847 оны 6 сарын 2-нд П.Кафаров Хунцал өртөөнд ирэхдээ “Уг өртөөний ойр хавийн газар Харчин нутгийнхтай төстэй санагдсан юм. Цайвар хужир намхан дэрстэй, эргэн тойрных нь толгод хээр талыг санагдуулна. Нэгэн жижиг нуурын эргэн тойронд сондуул, намаг ихтэй, өвс нь тачирхан ч ялаа шумуул ихтэй байлаа”³⁵ гэж тэмдэглэжээ. Сурвалжийн мэдээ, албан баримт, аялагчдын тэмдэглэлд өртөөний нэр зөрүүтэй буй нь Монгол нутаг дахь замын чиглэл улирал, байгаль, цаг уурын хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж байсантай холбоотой юм.

4. Хоринт өртөө. 1820 оны 9 сарын 10-нд Е.Тимковский тус өртөөний сууринд иржээ. Тэрбээр “Бороо голыг бид дахиад 3 цагийн үед гаглаад Ноён уулын хормойд орших Хуримт өртөөнд хоноглохоор буув. Бидний буусан гэрээс баруун урагш нэгэн сунагар урт нуруу харагдах нь яг л шороон далан мэт, түүний төгсгөл дээр Хуримт хэмээх сүрлэг цохио сэрийнэ”³⁶ гэж бичжээ. Үүнээс яг нэг жилийн дараа хамт буцсан Н.Я.Бичурин “1821 оны 7 сарын 21-ний өдөр бид 50 орчим ли яваад Бороо голын эрэг дээр мөн ийм нэртэй эдлэнд (өртөөнд-Ш.М) буудаллав. Энэ бүх зам уул бэлийг дайран өнгөрчээ. Буудал (өртөө-Ш.М) хүрэхэд арван ли зайд замын баруун талд өндөр сүрлэг Ноён уул оршино”³⁷ гэж өгүүлдэг.

Н.Я.Бичурины тэмдэглэлээс Бороо голын өртөөнд ирсэн мэт ойлгогдоно. Гэтэл Е.Тимковский “Хунцал өртөөнөөс мөн л 6 цагт хөдөлж, 10 орчим мод яваад, Ноён уулын баруун хормойг ороон Сүсэгтийн хөндий рүү орж, хус, гачуур их ургасан өтгөн ой харж нүдээ баясган явсаар үдийн 12 цаг болж байхад Хуримт өртөөнд хүрэв”³⁸ гэж өгүүлсэн байна. Тэднийг явж байх үед Бороо голын зүүн тал Ноён уулын баруун суганд буюу одоогийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багийн нутаг Хуримтад нутаглаж байжээ. Харин П.Кафаровыг 1847 оны 6 сарын 2-нд ирэхэд Баянбярүүхайд нутаглаж байсан бололтой байдаг.³⁹ Баянбярүүхайн хөндий Хуримтаас урд зүгт өнөөгийн Төв аймгийн Борнуур сумын Арангат Баянгол багийн нутагт бий. Байршил нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багийн нутаг Ноён уулын баруун хормой ажээ. Энэ нь сумын төвөөс урд зүгт 10 км, Хунцал өртөөнөөс хойд зүгт 30 гаруй км-т юм.

5. Хараа өртөө. Н.Я.Бичурин “Ноён уулын зүүн тал Хараа голын баруун эрэгт буудаллав”⁴⁰ гэж бичдэг. П.Кафаров “Хөндийн хойд захыг зүүнээс баруун тийш урсах Хараа гол эмжжүхүй. Тэр хавьд голын өргөн 20 алхам л байх тул бид бууж, хөл нүцгэлэн гатлаад том ногоон сондуул дамжин явсаар Хараа өртөөнд хүрч буув”⁴¹ гэж өгүүлжээ. Хараа өртөөний суурин Сэлэнгэ аймгийн Мандал сум

³⁴ Е.Тимковский. 1820-1821 оны Монгол. Орчуулсан Ж.Нэргүй. УБ., 2019. т. 382

³⁵ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 224

³⁶ Е.Тимковский. 1820-1821 оны Монгол. Орчуулсан Ж.Нэргүй. УБ., 2019. т. 71

³⁷ Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2019. т. 69

³⁸ Е.Тимковский. 1820-1821 оны Монгол. Орчуулсан Ж.Нэргүй. УБ., 2019. т. 382

³⁹ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 224

⁴⁰ Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2019. т. 70

⁴¹ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 227

Хэрх багийн нутаг Элсний хөндийн баруун, Ширхэнцэг уулын зүүн талд, Хараа голын ард нутаглаж байжээ. Энэ нь Баянбаруухай өртөөнөөс баруун хойд зүгт 22 км зайтай оршино.

6. Шанд дов өртөө. Н.Я.Бичурин “Бид шулуун замаар 35 ли орчим явж Мангадай уулыг давж Баянголын эрэг дээр мөн тийм нэртэй эдлэнд (өртөөнд Ш.М) буув”⁴² гэжээ. Тус өртөөг мөн л нутаглан буй газрынх нь нэрээр Шанд дов, Баянгол хэмээн бичсэн ажээ. Шанд довыг 1984 онд Улсын геодези, зураг зүйн газраас гаргасан 1:125.000 масштабтай газрын зурагт Шант овоо гэж бичсэн байна. Шанд дов Баянголоос хойд зүгт 6 орчим км зайтай. Баянголын өртөө Баянгол сумын Төмөрт багийн нутаг Манхдайн давааны ар талд байжээ.⁴³ Энэ нь Хараагийн өртөөнөөс хойд зүгт 25 км орчим зайтай юм.

7. Номт өртөө. Уг өртөөний тухай П.Кафаров “Хоёр захаараа намаг, бургас ихтэй Сайрын голыг гатлан Номт өртөөн дээр хүрч очив. Эргэн тойронд нь эзгүй мянган толгод үргэлжилнэ”⁴⁴ гэж өгүүлжээ. Архивын зарим баримтад тус өртөөг Өрмөгтэй (örmegetei) хэмээн бичжээ.⁴⁵ Номтод зуны цагт нутаглаж, өвлийн улиралд Өрмөгтэйд буудаг байжээ. Нутгийн иргэд Өрмөгтэй төмрийн хүдэртэй аянга их буудаг газар гээд тэнд буудаггүй. Номт өртөө Дархан уул аймгийн Хонгор сум, Шарын голын уурхай хоёрын заагт Шарын голын зүүн

эрэг дээр зусч Өрмөгтэй өртөө Дархан уул аймгийн нутаг Дархан уулын хойно орших Өрмөгтэй уулын урд хормойд өвөлждөг байжээ.

8. Дэрст булан өртөө. Эл өртөөг П.Кафаров “Хүйтний голыг гатлаад Дэрст булан хэмээх өртөөнд хүрэв. Тус өртөө тэр хавьдаа хамгийн өндөр уулын хормойд оршино”⁴⁶ гэж тэмдэглэжээ. Хүйтний голын хойно буй хамгийн өндөр нь Хонгор уул юм. Нутгийн ахмадууд Дэрст булан өртөөг Тайны Гозгор уулын энгэрт зусдаг хэмээн тайлбарлан ярьж байв. Дэрст булан өртөө Сэлэнгэ, Ерөө хоёр сумын зааг дээр Хүйтний голын хөндийд байрлаж байжээ.

9. Ерөө гол өртөө. П.Кафаров “Ерөө голын хөндийд Ерөөгийн өртөө байрлана. Хойд талаараа уулс үргэлжилж голын сав дагуу бургас багширна”⁴⁷ хэмээн өгүүлжээ. Ерөө голын өртөө өнөөгийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Тал булагт өвөлжиж, Амбасын дов хэмээх газар зусдаг байв. Энэ нь Ерөө сумаас 20 км орчим зайтай Ерөөгийн дунд гүүрний хойд талд юм.⁴⁸

10. Нарийн могой өртөө. П.Кафаров “Ерөөгийн хөндийг туулаад уужимхан хавцал руу шургаж өгссөөр Нам даваа руу гарч, тэндээсээ нарийхан хавцал уруудан буугаад битүү ногоон зүлэгтэй талаар явж сүүлдээ намгийн сондуул дундуур Нарийн могойтын өртөөнд

⁴² Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орчуулсан Б.Даши-Ёндон. УБ., 2019. т. 70

⁴³ Сэлэнгэ аймгийн Баянгол сумын газар нутгийн нэрийн зураг.

⁴⁴ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 227

⁴⁵ Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. ХМ-146. Д-1. ХН-62

⁴⁶ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 228

⁴⁷ Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 228

⁴⁸ Сэлэнгэ аймгийн Ерөө сумын газар нутгийн нэрийн зураг. УБ., 1983

хүрлээ”⁴⁹ хэмээн өгүүлдэг. П.Кафаров явсан газрынхаа тухай цөөн хэдэн газрын нэрийг л дурдсан байгаа юм. Нам даваанаас хойш Бумбатын шовх уул, Байц уул, Бичээч толгойн дундуур явж Бумбат голыг гатлан өгсөж Нарийн могойн өртөөнд хүрнэ. Нарийн могой өртөө одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Их могой багийн нутагт сумын төвөөс урд зүгт 30 км-т Даяанч уулын зүүн хойно, Бага Мэлхийн толгойн баруун талд байрлана. Нарийн могой өртөө нь Ерөө голын өртөөнөөс хойд зүгт 25 км зайтай оршино.

11. Гялаан нуур өртөө. П.Кафаров “Ерөөгийн салбар уулсыг орхиод хоёр ч нарсан төгөлийг өнгөрвөл Хиагтын сүмийн цагаан орой цавцайн, гонх нь сэрийгээд, хажууд нь цайны агуулахын бараа харагдав. Эндээс бид Гялаан нуурын өртөө рүү бууж ирлээ”⁵⁰ гэж бичжээ. Гялаан нуурын өртөөнөөс Алтанбулаг ойрхон байгааг уг тэмдэглэлээс мэдэж болно. Гялаан нуур Алтанбулаг сумаас урд зүгт 8 км зайтай. Нарийн могой өртөөнөөс гарч Зүүн Тогос уулын зүүн сугаар гарч Их, Бага цоорхойг даган Доргонтын нарс, Тужийн нарсыг дайраад Худгийн гуу хүрч Талын нурууны зүүн амаар гарч Гялаан нуурын өртөөнд хүрнэ. Гялаан нуур Сэлэнгэ аймаг Алтанбулаг сумын Талын нуруу багийн нутаг Бунхан балгасын урд оршино. Нарийн могой өртөөнөөс хойд зүгт 23 км зайтай юм.

Балинт Габорын Хүрээнд очиж хээрийн судалгаа хийгээд буцахдаа эдгээр өртөөгөөр дайран явсан нь тодорхой байна. Балинт Габор Хүрээнд ирсэн тухайгаа “*Өдөржин маш хурднаар давхисаар бид нар Монгол улсын нийслэл Өргөө хотод ирсэн. Энэ үед лам нар бүрээтэй адил хөгжмөөр Майдар бурхны аялгууг үлээж байсан*”⁵¹ гэжээ. Баалинт Габор Хүрээний өдөр тутмын амьдралын сонирхон үзэж хятад, орос, монголчуудын амьдардаг суурингаас маш их хэмжээний мэдээлэл цуглуулж судалгаандаа ашиглаж байжээ. Тэрбээр “*би багштайгаа хотын төвөөр орохдоо тэнд байсан эд зүйлийн нэрийг ч асууж явав. Тэгэхдээ би хятад хүмүүсийн болон лам нарын гал тогооны цэцэрлэгээр орж, ургамал ногооны нэрийг асуусан боловч маш цөөхөн хүн мэдэж байсан*”⁵² гэж бичжээ. Тэрбээр Хүрээнд байх хугацаандаа аман ярианы жишээ агуулсан эх бичвэр 12 хуудас, оньсого 1 хуудас, хошин яриа 6 хуудас, үлгэр 10 хуудас, ардын ёс заншил 12 хуудас, маань мэгзэм 2 хуудас, хараал 1 хуудас, тангараг 1 хуудас, Чингис хаантай холбоотой 9 хуудас, далны ясаар мэргэлэх 9 хуудас баримт тэмдэглэж авчээ.⁵³ Үүнээс гадна Монгол гэрийн онцлог, монголчуудын баяр ёслол, ан амьтдын үр төлийг бичиж авсан байна.

⁴⁹ Сэлэнгэ аймгийн Ерөө сумын газар нутгийн нэрийн зураг. УБ., 1983

⁵⁰ Сэлэнгэ аймгийн Ерөө сумын газар нутгийн нэрийн зураг. УБ., 1983

⁵¹ Бирталан Агнеш. Чингис хааны цагаан сэтгэлт ард түмэн. УБ., 2016. т. 61

⁵² Бирталан Агнеш. Чингис хааны цагаан сэтгэлт ард түмэн. УБ., 2016. т. 63

⁵³ Ágnes Birtalan. Gábor Bálint of Szentkatolna, A Romanized Grammar of the East- and West-Mongolian Languages. Budapest . 2009. p. XVII-XIX

Баалинт Габор Хиагтаас Хүрээ, Хүрээнээс Хиагт хүртэл Халхын Түшээт хан аймгийн Илдэн засгийн хошуу, Баатар засгийн хошуу, Эрдэнэ засгийн хошууны нутаг дахь 11 өртөөгөөр дайран гарчээ. Илдэн засгийн хошуунд 2, Баатар засгийн хошуунд 4, Эрдэнэ засгийн хошуунд 5

өртөө байв. Тэдгээр нь Одоогийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт 3, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт 1, Дархан уул аймгийн Хонгор суманд 1, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 1, Алтанбулаг сумын нутагт 2 өртөө тус тус байжээ. Түүний Хиагтаас Хүрээ хүртэл явсан зай 320 орчим км юм.

ДИОСЕГИ ВИЛМОШ (1923–1972) БОЛОН УНГАР-МОНГОЛЫН СУДАЛГААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Силади Жолт

*(HUN-REN Судалгааны сүлжээний
Нийгмийн ухааны хэлтсийн судлаач)*

Диосеги Вилмош нь XX зууны дунд үеийн Унгарын угсаатны зүй судлалын гол төлөөлөгч бөгөөд хилийн чанадад тухайлбал, Өмнөд Сибирь, Дундад Ази болон Төв Азид хийсэн бөө мөргөлийн судалгаагаараа алдаршсан хүн юм. Бид 2022 онд түүний нас барсны 50 жилийн ой, 2023 онд түүний мэндэлсний 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Диосеги Вилмош амьдралынхаа 49 жилийн богинохон хугацаанд маш их материал цуглуулсан бөгөөд түүнийг нас барснаас хойш хагас зуун жил өнгөрсөн ч тэдгээрийг бүрэн судалж амжаагүй л байна. Унгарын судлаачид Диосегигийн цуглуулсан материалыг судалж, боловсруулах, хэвлэгдээгүй бичвэрүүд, өдрийн тэмдэглэл, захидлуудыг судалгааны эргэлтэнд оруулах, бөөгийн талаарх бичвэрүүд, түүний хээрийн ажлын явцад цуглуулсан аудио бичлэгүүдийг орчуулж, хэвлэн нийтэлж⁵⁴ олны хүртээл болгох мөн судалгааны ажлынх нь хамгийн чухал зорилго болох Бөөгийн архивд хүндэтгэлтэй хандахыг хичээсээр ирсэн. Түүний мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан ажлууд нь цаашид биднийг

эрч хүчтэй ажиллахад илүү урам зориг өгч байна.

HUN-REN (хуучнаар Унгарын Шинжлэх Ухааны Академи)-ийн Хүмүүнлэгийн ухааны Судалгааны төвийн Угсаатны зүйн хүрээлэн сүүлийн жилүүдэд түүний өвийг боловсруулах ажлыг дахин эхлүүлсэн бөгөөд Угсаатны зүйн хүрээлэн, Угсаатны зүйн музей материалуудыг хэвлүүлэх нь чухал гэж үзсэн. Иймд ойрын хугацаанд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж магадгүй.

Сибирийн бөө шүтлэгийн элементүүдийг нарийн арга зүйгээр судалснаар эртний Унгарын сүсэг бишрэлийн гарал үүслийн асуудлыг тодруулахыг хүсчээ. Энэхүү салбарын архив, музейн сан хөмрөгт судалгаа хийхдээ тухайн үеийнхээ ёс суртахуун, үзэл санааг тухайн ард түмний нийтлэг жишиг гэж үздэг байжээ. Өнөө үед бид түүний судалгааны арга барилын бүх зүйл дээр санал нийлдэггүй шалтгаан нь Шинжлэх ухаан өнөөдөр өөр өөр стандартад нийцүүлэн ажиллаж, судлаачид ч өөр өөр өнцгөөс ханддаг болсон. Гэхдээ эдгээр нь Диосегигийн цуглуулсан, бичсэн зүйлийн үнэ цэнийг бууруулж чадахгүй юм.

⁵⁴ Угсаатны зүйн музей Диосегигийн мэндэлсний 100 жилийн ойд (2023.05.06) зориулан зохион байгуулж буй бага хуралтай давхцуулан Диосегигийн цуглуулсан аудио материалын дижитал хувилбарыг нийтлэх боломжтой вэбсайтыг эхлүүлсэн нь чухал алхам юм.). <https://dioszegi.neprajz.hu/> (2023. 08. 12.)

Судалгааны ажил нь түүний боловсруулсан аргачлалын дагуу хийгдсэн бөгөөд аль эрт хэвлэгдсэн юм (Диосеги 1954).

Нэг ёсондоо Диосеги дэлхийн 2-р дайны дараа Унгараас Сибирь, Төв Азийг судлах ажлыг дахин эхлүүлсэн хүмүүсийн анхдагч байсан.

Улс төрийн нөхцөл байдал нь өмнөх арван жилийнхээс илүү дээр болсон тэр цаг үед Диосеги энэ талбарт гарч ирсэн ч тухайн үеийн Шинжлэх ухааны тодорхой ойлголт нь судлаачдын чөлөөт байдлыг эрс хязгаарладаг байсан. 1950-1960-аад оны зааг дээр зарим судлаачид ЗХУ болон Монгол руу аялах боломжтой болсон. 1957 онд Унгарын дорно дахины судлалын залуу судлаачид хожмын нэрт монгол судлаач Кара Дьёрд (1935–2022), манж тунгус судлаач Күхолмын Каталин (1926–2012) болон төвд судлаач Рона-Таш Андраш нарын хамт Диосеги өөрийн хамгийн их очихыг хүссэн газар болох Сибирь лүү явж, улмаар дорно зүгт Монгол руу аялах боломж бүрдсэн⁵⁵.

Тэд бүгд Унгарын дорно дахины нэрт судлаач Лигети Лаёшын (1902–1987) шавь нар байсан нь тохиолдлын хэрэг биш юм. Лигети нь тухайн салбарт тууштай хэмээн үзсэн шавь нараа чадах чинээгээрээ дэмжиж ирсэн бөгөөд 1950-иад онд түүний хашиж байсан албан тушаал нь мөн түүнд энэ тал дээр илүү өргөн боломжийг олгосон. Лигети хүнийг танихдаа сайн

хүн байсан гэдгийг энд онцлох ёстой. Өмнө дурдсан Лигетийн бүх шавь нар нь өөр өөрсдийн чиглэлээр олон улсад нэр хүндтэй судлаачид болжээ.

Одоогоор Унгар-Монголын хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн хүрээлэн Диосегигийн судалгааны ажилд дүн шинжилгээ хийж байна. Тухайлбал, А HUN-REN ВТК Угсаатны зүйн хүрээлэн болон Монголын Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн зэрэг хоёр улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудыг нэрлэж болно.

Унгарын угсаатны зүйн музей, Чингис хааны үндэсний музей нь Унгарын угсаатны зүйчийн авсан гэрэл зургуудыг хэвлэн нийтлэх, түүний цуглуулсан бөөгийн эд зүйлсийг харуулсан каталогийг хэвлүүлэх ажилд идэвхтэй оролцож байна.

2023 оны 11 дүгээр сарын 24-нөөс 12 дугаар сарын 8-ны өдрүүдэд Чингис хаан Үндэсний музей нь Диосегигийн зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан.

Диосеги Вилмошийн намтар: Диосеги Вилмош 1923 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Будапешт хотноо мэндэлсэн. Эцэг нь шугам зургийн инженер байсан бол эх нь гэртээ хүү, охин хоёроо хардаг байсан. Охин дүү нь Диосегигээс 7 насаар дүү байсан. Түүний дурдатгалаас харахад, Вилмош ном их уншдаг сониуч нэгэн байсан бөгөөд хүүхэд байхаасаа л эртний нүүдэлчин унгарчуудын талаар ихийг мэдэхийг

⁵⁵ Тэднээс гадна 1957 оноос угсаатны хөгжим судлаач Викар Ласло (1929–2017), Уралын филологич Берецки Габор (1928–2012) нар Ижил мөрний бүсэд Казань Татар, Башкир, Чуваш, Мари, Удмуртын нутаг дэвсгэрт хээрийн судалгаа хийжээ. 1959 онд археологич, физикийн антропологич Габор Миклош очиж үзэх боломжтой болжээ.

хүсдэг байжээ. Тэрээр гимназид байхаасаа дорно дахины хэлийг сурч эхэлсэн, гэхдээ турк, япон хэл сурч эхэлсэн тухайгаа эцэг эхдээ мэдэгдээгүй байдаг. Тэрээр Унгарын эртний түүх, сүсэг бишрэл, дорно дахины талаар сонирхогч бусад залуучуудын нэгэн адил дорно дахины судлаач, төвд судлаач Көрөши Чума Шандорын хийсэн аялал болон судалгааны ажлуудыг шимтэн уншдаг байв. Их сургуульд турк, монгол хэл шинжлэлийн чиглэлээр суралцаж улмаар Лигети Лаёшын (1902–1987) зөвлөснөөр манж-тунгус хэлийг судалсан. Дараа нь Лигетигийн удирдлагаар “Манж хэлээр үг бүтээх нь” сэдвээр докторын зэрэг хамгаалсан.

Диосеги 1947 онд Угсаатны зүйн музейд ажилд орсон нь ирээдүйн карьерыг нь тодорхойлж өгсөн гэж болно. Энд “Азийн цуглуулга”-ын сан хөмрөгийг хариуцдаг байсан. Сибирийн талаарх судалгааныхаа хүрээнд тэрээр сүсэг бишрэлийн ертөнц, бөө мөргөлийн уламжлалыг судлахад илүү анхаарч, энэ талаар олдож болох бүхий л номыг уншжээ. Хожим нь энэхүү “цуглуулагчийн” хүсэл тэмүүлэл нь хэвээр үлдэж, уран зохиолын бус номнуудынхаа тоог байнга нэмэгдүүлдэг болжээ. Тэрээр судалгааны аяллаасаа аль болох олон эх материал болон хуулбаруудыг эх орондоо авчирдаг байсан. Түүний бүтээсэн тэрхүү “номын сан” нь тухайн үеийн тусгай ном зохиолын хамгийн өргөн сан хөмрөгтэй нь байсан.

Диосеги бөөгийн уламжлалыг олонд таниулах, судлах чиглэлээр хийсэн судалгаагаараа илүү дурсагддаг ч үүнээс

гадна унгар ардын аман зохиолын цуглуулга нь бас түүний ажлын нэлээд хэсгийг бүрдүүлдэг. Тэрээр Сибирийн бөө мөргөлийн судалгааны ажилтайгаа зэрэгцүүлэн унгар хэлээр ярьдаг нутгуудыг хамарсан ардын аман зохиол цуглуулах, судлах, унгар болон хөрш зэргэлдээ ард түмний угсаатны зүйн ном зохиолыг судлах, бүртгэх ажлыг эхлүүлсэн юм. Тэрээр 1954 онд анхны гадны улсын аялал болох Турк руу явахаасаа өмнө унгарчуудын дунд орших сүсэг бишрэлийн ертөнцтэй танилцахын тулд унгар хэлээр ярьдаг ихэнх нутгаар явсан.

Диосегигийн сонирхол нь түүнийг Ази руу байнга хөтөлж байв. 1957 онд Зөвлөлт Холбоот Улс руу явах боломж олдсон. Гуравхан сарын тэтгэлэг авсан ч тэрээр аль болох удаан хугацаагаар явмаар байна гэдгээ хэнээс ч нуугаагүй. Гайхалтай шийдэмгий, тууштай хөөцөлдөж, олон удаа буцаагдсаны эцэст гурван сарын тэтгэлэгээ нэг жил хагас болгосон тэрээр ихэнх цагаа Санкт-Петербург (Ленинград) хотын музейд ажиллаж өнгөрүүлжээ.

Тэрээр судалгаатайгаа холбоотой бүхий л зүйлсийн зургийг авч, тэмдэглэж бас хуулж авсан. Унгар цуглуулга буюу бөөгийн архиваа бий болгох төлөвгөөнийхөө хүрээнд цуглуулганд орж болох бүгдийг л олж авахыг хичээсэн гэсэн үг. Тэрээр орос хэл дээрх бөө шүтлэгийн номнуудыг цуглуулж, Унгарт өмнө нь танигдаагүй ховор номуудыг эх хувиар нь эсвэл микро хальсан дээр буулган авчирч, музейн цуглуулгуудын зургийг авсан.

Тэрээр судалгааны ажлынхаа ихэнхийг орон нутгийн болон хотуудын музей, судалгааны хүрээлэнгүүдэд (Санкт-Петербург, Москва, Эрхүү, Красноярск, Новосибирск, Улаанбаатараас гадна) хийж, номын фонд, архив, эд зүйлсийн цуглуулгатай танилцсан. Энэ үеэрээ хэдэн долоо хоног богино хугацааны хээрийн судалгаа хийхээр явсан ч музейн агуулахуудад байх нь гэртээ байгаа юм шиг санагддаг байсан гэдэг. Хээрийн судалгаа хийхээр явж буй нутгийн иргэдийн хэл болох түрэг, монгол хэлийг сурах боломж хомс байсан учир орос хэлтэй иргэдээс ажилдаа туслахыг хүссэн.

Тэрээр ЗХУ-д нэг жил хагас байх хугацаандаа Сибирыг хоёр удаа очсон. (1957 оны намрын эхээр болон 1958 оны зун) 1957 онд Буриадад очиход нь Сараксинова дагалдан явсан бөгөөд түүний өвөг дээдэс нь бөө байсан гэнэ. Диосеги энд анх удаа бөөтэй уулзсан. Тэндээсээ Красноярск хотоор дамжин Сибирийн Абаканы түрэгүүд дээр очиж хэд хэдэн бөөтэй уулзан олон чухал баримтыг хальсанд буулгаж авсан. 1958 онд тэрээр эхлээд Красноярскаар дамжин Карагас руу яваад дараа нь бага зэрэг тойруу замаар Эрхүүгээр дамжин Ока мөрний хөвөөнд амьдардаг Тувагийн соётууд дээр очиж өвөрмөц мэдээллүүдийг баримтжуулсан. 1958 оны 9 дүгээр сард тэр өвдсөн тул Будапештэд буцаж ирсэн. Ховор, чухал олон эд зүйлсийг авчирсан тэрээр Угсаатны зүйн музейд эртнээс төлөвлөсөн бөөгийн архиваа байгуулж эхэлсэн бөгөөд Соёлын яам, Унгарын Шинжлэх ухааны академиас санхүүгийн дэмжлэг авчээ.

1950 онд Унгар, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноор Шинжлэх Ухааны салбар дахь хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд унгарын судлаачид тус улсад зорчих боломж нээгдсэн. Ингээд 1960 онд Диосеги Монголд ирсэн.

Монголын Шинжлэх ухааны салбарын нэрт эрдэмтэн Бямбын Ренчин (1905–1977) Лигетитэй тогтоосон сайн харилцааныхаа ачаар 1956 онд Унгарт докторын зэрэг хамгаалсан. Энэ үеэр тэрээр Унгарын судлаачдыг эх орондоо урьжээ. Дараа зун нь Кара Дьёрдийн багийнхан Монголыг зорьсон бол 1960 оны 1 дүгээр сарын 1-нд Алтай судлалын багийн судлаач Бетленфолви Геза (1936-2022), тэр зун нь Диосеги тус тус Монголд иржээ. Тэр үеэр Ринчен Монголын тусгаар тогтнолын талаарх хатуу байр сууринаасаа болж улс төрийн шалтгаанаар шахагдаж эхэлсэн ба Зөвлөлт-Монголын Засгийн газар түүний үйл хөдлөлийг хязгаарласан тул Диосегитэй хамт хээрийн судалгаанд явж чадаагүй юм. Ийм учраас унгар судлаач хөдөө орон нутагт ажиллахдаа өөр хамтрагч олохоос өөр аргагүй болсон. Түүний сонголт нь хоёр мундаг залуу байсан бөгөөд тэд хожим нь Монголын угсаатны зүйн судалгаанд болон бөө мөргөлийн судалгаанд онц байр суурийг эзэлжээ. Диосеги Монголд байсан хоёр сарын хугацаандаа гурван удаа богино хугацааны хээрийн судалгаа хийсэн.

Тэрээр Дорнод аймгийн хорь буриадууд, хамниганчууд, Хөвсгөл нуурын зүүн талаар амьдарч байсан ариг урианхай, нуурын баруун талд амьдарч байсан дархад, тува цаатны нутгаар

судалгаа хийсэн. Сүүлийн судалгааны ажил нь хамгийн урт хугацаатай байсан. Диосеги эхлээд Монголын угсаатны зүйч С.Бадамхатантай (1933–1998) хамт дорно зүгт буриадын нутаг руу явсан. Үүний дараа тэр ганцаараа Хөвсгөлд хээрийн судалгаа хийсэн. Энэ үедээ Улаан-Уул сумын багш О.Пүрэвтэй (1931–2010) уулзсан. О.Пүрэв хожим угсаатны зүйч, дархад бөөгийн уламжлалын талаарх судлаач болсон нь магадгүй Диосегигээс авсан урам зоригтой холбоотой байж ч мэдэх юм.

Монголд хийсэн хээрийн судалгаа нь Диосегигийн хөдөө нутгаар цаг хугацаатай уралдан хурдтай явж, тулгарсан бэрхшээлүүдийг хэрхэн даван туулж байсныг тод харуулдаг. Ийн явахад нь шийдвэр гаргагчдаас томилогдсон хөтөч нар түүний ажилд тусалдаг. Энэ нь нэг талаар Сибирьт байсны нэгэн адил орон нутгийхангай хэл амаа ойлголцоход зохих бэрхшээлүүдтэй тулгаруулж байсан. Мөн бөө мөргөлийн талаар судалгаа хийхийн тулд орон нутгийн намын удирдлагуудын сайн санааны дэмжлэгийг авах ч шаардлагатай байсан. Зарим тохиолдолд тэд зөвхөн “гадаадын” иргэнд төдийгүй хөтөч хийх хүмүүстээ ч үл итгэдэг байсан тул тэдэнтэй хамтран ажиллахад хүндрэлүүд үүсдэг байсан. Диосегийг бөөгийн зан үйлийн ёслолд оролцохыг хориглодог байсан, гэхдээ тэр нууцаар оролцдог байсан тухайгаа өдрийн тэмдэглэл, захидалдаа тэмдэглэсэн байдаг.

Диосеги үндэсний уламжлал, шашин шүтлэг хаалттай байсан үзэл суртлын эрин үед бөө мөргөлийн уламжлалын талаар судалгаа хийхийг оролдсон. Гэхдээ тэр эдгээр

хүндрэлийг даван туулж чадсан нь унгар судлаачийн шийдэмгий байдлыг харуулж байна. Тухайлбал, тухайн үед орон нутгийн намын дарга нартайгаа хамтран ажиллахаас татгалзсан хэргээр Хөвсгөл аймгийн Мөрөн хотод шоронд хоригдож байсан дархадын бөө Дамдин (заарин)-тай Диосеги уулзаж чадсан байна. Түүнийг Диосегитэй уулзуулахаар шоронгоос түр гаргасан бөгөөд энэхүү бөө мөргөлийн талаар чухал материал олж чадсан юм. Богино хугацаанд ажиллаж, судалгаа хийх бүрэн боломжтой нөхцөл бүрдээгүйгээс үүдэн мэдээлэл хязгаарлагдмал байсан ч тэрээр монгол бөөгийн уламжлал нь нэг угсаатны бус, харин үндэстэн хоорондын харилцаа оршин тогтнож байгаатай холбоотой - бүс нутгийн хувилбарууд (буриад-хамниган, дархад-урианхай) гэдгийг тодорхойлсон. Тэрээр эдгээр угсаатнуудын тухай хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн ба бөө мөргөлийн уламжлалыг Өмнөд Сибирь болон Монголын хойд хэсэг дэх угсаатны үйл явцын зураглалд хэрхэн ашиглаж болох талаар ч бичсэн. Энэ сэдэв нь түүний судалгааны ажлын хамгийн чухал чиглэлүүдийн нэг болжээ. (Вилхелм 2004.)

Диосегигийн судалгааны ажил нь зөвхөн энэ сэдвийг сонирхож буй хүмүүсийн анхаарлыг татаагүй юм. Мөрдлөг хавчлаган дунд түүний хийсэн хээрийн судалгаа буюу эртний зан үйл сүсэг бишрэлийн талаарх ажил нь өнөөдөр Монгол оронд ямар гайхалтай сэргэж байгааг харсан бол тэр гайхах байсан байх. Өнөөгийн Монголын шинэ үеийн бөө мөргөл нь өөрөө угсаатны зүйн судалгааны сонирхолтой сэдэв юм.

1990 оны нийгмийн шилжилтийн дараа шашин шүтлэг чөлөөтэй болж, бөө шүтлэгт сүэглэх хүмүүсийн тоо нэмэгдэж, Диосегигийн олж, судалж байсан уламжлал нь орчин үеийн соёлын нэг хэсэг болсон (Хангартнер 2010). Өнөөгийн бөө нар эртний бөөгийн уламжлалаасаа өвлөн авсан боловч бөөгийн зан үйлийг цаг үетэйгээ нийцүүлэн арай өөрөөр үйлдэхээс гадна тэдний нийгэмд эзлэх байр суурь мөн өөр болсон. Тэд үйлчлүүлэгчдийнхээ хүрээг бий болгох эсвэл үйл ажиллагаагаа сурталчлахын тулд өмнө нь чухалчлан мөрдөгдөж байсан цээр ёсуудыг өөрчилж байгаа нь ч бас байна.

1920 оны Ардын хувьсгал, 1924 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхаглах, хуучин нийгмийн элитүүд болон сэхээтнүүдийн хэлмэгдүүлэлт (1937-1939 оны сүүлчийн давалгаа), өөрөөр хэлбэл ЗХУ-ын өмнөх үе болон дараа үе хоорондын уялдаа холбоог Диосеги 1960-аад онд олж харсан. Мөн Монголын угсаатны зүйн түүхэнд тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Зөвхөн энд төдийгүй Сибирийн нутагт коммунизм, намын үзэл суртлаас болж нутгийн уламжлалт соёл, түүнийг тээгч бөө, туульч хүмүүс нуугдмал байдалд орсон тэр цаг үед Диосегигийн хийсэн судалгаа нь тухайн ард түмний соёлын нэг хэсэг болсон бөө мөргөлийн үнэ цэнийг сэргээхэд чухал ач холбогдолтой байсан. Ийнхүү Диосеги Вилмош нь орон нутгийн боловсон хүчин, сэхээтнүүдэд угсаатны болон үндэсний уламжлалт бөө мөргөлийн

гүйцэтгэсэн үүргийн талаар таниулж идэвх зүтгэл гаргасан юм.

Диосеги Унгарын угсаатны зүйн судалгаа, олон улсын (барууны) бөө мөргөлийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан боловч өнгөрсөн жил бид түүний алс холын нутгуудад хийсэн судалгааг өнөөгийн судлаачид хэрхэн ойлгож, үнэлж байгаа талаар чухал туршлага хуримтлуулсан. Диосеги 1964 онд Сибирь лүү явсан бөгөөд энэ аяллаар түүний том мөрөөдөл биелж, тэндээсээ Алтай руу явж чадсан. Тэрээр Новосибирскээс Горно-Алтайск руу аялж, дараа нь Алтайгаас хойд зүгт орших Бий голын дагуу амьдардаг Куманди хэмээх жижиг үндэстэнд зочилж, тэндээсээ Монгол улсын хилийн ойролцоох Кош-агаш сууринд зочлоход энд теленгит болон казахууд цуг нэг доор амьдардаг байсан. Гэхдээ тэр үед Диосеги эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тул судалгаа болон цуглуулгаа бүрэн хийж чадаагүй. Тэр өдрийн тэмдэглэлээ алдсан тул бид түүний Теленг дэх хээрийн ажлын талаар бага мэддэг. Диосеги дорно зүгт хийсэн сүүлчийн аяллаасаа буцаж ирэхдээ эрүүл мэндийн хувьд тааруухан байсан бөгөөд хожим нь шинжлэх ухаан, улс төрийн шалтгааны улмаас тэрээр очих дуртай нутагтаа буцаж очих боломжгүй болжээ.

Амьдралынхаа сүүлийн найман жилд тэрээр Сибирийг хийхээр төлөвлөж байсан хээрийн судалгааны ажлынхаа зөвшөөрлийг хүлээсээр байсан боловч түүний эрүүл мэнд нь улам доройтсоор байсан. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд тэрээр Алтай (түрэг,

монгол, тунгус), Уралын (самоед, ханты, маньси) ард түмэн, үндэстэн хоорондын харилцааны сэдвээр судалж байсан ч ажлаа дуусгаж чадаагүй. Диосеги угсаатны зүйн хүрээлэнд⁵⁶ ажиллаж байхдаа ухаан алдаж унаад амьдралынхаа сүүлийн саруудыг эмнэлэгт өнгөрүүлсэн. (Ортугау 2010: 316) Тэрээр уйгагүй хөдөлмөрлөж, тууштай хээрийн судалгаа хийснийхээ эцэст Будапешт хотын Буда дахь Форкошритийн оршуулгын газарт амар амгаландаа нойрссон юм.

Диосегигийн бүтээлийг зөвхөн одоогийн тэмдэглэлт ойн баяртай нь холбогдуулж дурсах нь хангалтгүй юм. 2021 оны намар HUN-REN Хүмүүнлэгийн судалгааны төвийн Угсаатны зүйн хүрээлэнд Диосегигийн өвийг зохион байгуулах хөтөлбөрийг эхлүүлсэн. 2023 онд түүний өвийг чухал сан хөмрөгөөр баяжуулсан.

Диосеги Вильмошын хоёр дахь эхнэр Морвай Юдитийн охид болох Сулноки Каталин, Сулноки Анна нар олон янзын, маш үнэ цэнтэй өвийг судалгааны архивт хүлээлгэн өгсөн. Тэдгээрт 9 хайрцаг хувийн материал (намтар, гэрчилгээ, гишүүнчлэлийн үнэмлэх, сургууль, их сургуультай холбоотой бичиг баримтууд, залуу насных нь зохиол, бүтээлийн жагсаалт), гар бичмэл, тэмдэглэл, цуглуулга, ажлын өдрийн тэмдэглэл, Унгар болон Сибирь дэх өдрийн тэмдэглэл, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой бусад баримт

бичиг, 260 гэрэл зураг, 17 аудио бичлэг 500 ширхэг захидал байсан. Судалгааны архивт нэмэгдсэн шинэ материалуудын дотор Диосегигийн 1960 онд хийсэн судалгааны аялал, 1964 онд хийсэн сүүлчийн аялалтай холбоотой өдрийн тэмдэглэл, захидал харилцаанд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй юм. Харамсалтай нь, 1964 оны сүүлчийн аяллын талаарх өдрийн тэмдэглэлүүд алга болсон тул түүнийг нөхөж олох хэцүү байгаа ч энэхүү тэмдэглэл нь судлаачдын сонирхлыг татсан хэвээр байна.

Өдрийн тэмдэглэл, захидлуудыг нийтлэхтэй холбогдуулан өмнө нь Морвай Юдиттэй тохиролцсоны үндсэн дээр Шанта Иштван болон Шумфои Кара Давид нар ажлаа эхлүүлээд байна. Баримт бичгийн эх хувь нь мөн судалгааны архивд байгаа тул материалыг цэгцэлж, хэвлэлд бэлтгэхэд ямар ч саад байхгүй. Ингэснээр бид Диосегигийн өвөрмөц өвийг боловсруулах чиглэлээр нэгэн алхам хийж магадгүй юм.

2022 оны судалгаа

Бид 2022 онд HUN-REN ВТК болон Угсаатны зүйн хүрээлэнгийн Шанта Иштван, Шумфои Кара Давид нартай хамтран Диосегигийн 1960 онд Хөвсгөлд хийсэн судалгааны мөрөөр хээрийн судалгаа хийсэн.⁵⁷

⁵⁶ 1963 оноос угсаатны зүйн судалгааны бүлгийн гишүүн, 1967 оноос үүссэн хүрээлэнгийн ажилтан. Захиргааны утгаараа угсаатны зүйн мэргэжил эзэмшээгүй ч тус хүрээлэнгийн угсаатны судлалын тэнхимийг мөн хэсэг хугацаанд удирдаж байсан.

⁵⁷ 2009 онд Шомфай Кара Давид 1960 онд Диосегигийн анхны хээрийн ажлыг удирдаж байсан Монголын дорнод нутагт очсон.

Диосегигийн 1960 онд хийсэн судалгааны мөрөөр тухайн үед Унгарын угсаатны зүйчтэй уулзаж байсан бөө нарын талаарх хүмүүсийн дурсамжийг сонсохоор Мөрөн хотыг бид зорьсон юм. Үүний зэрэгцээ өнөө үед оршин буй бөөгийн уламжлалыг эхний ээлжинд Мөрөн хотын ойр хавьд амьдарч буй хотгойд, дархад бөө нарын дундаас хайх хэрэгтэй хэмээн бид үзсэн.

Бид хээрийн судалгааны өмнө ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнд Диосегигийн 1960 оны аяллын тухай лекц уншсан. Эндээс харахад, Монголын мэргэжил нэгт нөхөд маань Диосегигийн тухай маш бага мэдлэгтэй байсан, харин түүний дэмжсэн монгол судлаачид (С.Бадамхатан, О.Пүрэв)-ын талаар илүү их мэдэж байсан бөгөөд 1950-1960 онуудад эхэлсэн Олон улсын Шинжлэх ухааны хамтын ажиллагаа аажмаар сэргэж, Монголын угсаатны зүйн хөгжил, судалгааны чиглэл, институцийн тогтолцоог бүрдүүлэхэд хэрхэн нөлөөлснийг бид уулзалтын үеэр хэлэлцсэн. Энэхүү үйл явц өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд социализмын үед бий болсон Монголын сэхээтнүүд, өнөөгийн хойч үе, зохион байгуулалтын бүтэц нь Олон улсын Шинжлэх ухааны чиг хандлагад улам бүр дасан зохицож байгаа өөрчлөлтийг мэдэрч байна.

Диосеги болон гадны судлаачид тухайн үеийн Монголын сэхээтнүүдэд урам зоригийг өгдөг байсан. Түүгээр ч барахгүй энэ цаг үед үзэл суртлаас шалтгаалан үндэсний соёл, уламжлалаа судлахад хаалттай, хориотой байсан.

Мөрөн хотод бид өнөөг хүртэл бөөгийн зан үйлээ идэвхтэй хийж буй

хотгойд бөөтэй уулзаж, зан үйлийнх нь уламжлалын талаар чухал мэдээлэл олж авсан. Харамсалтай нь, бидний зорин очсон бөө ч тэр, хотгойд нутгийн ард түмэн ч тэр өмнө нь Диосегигийн уулзсан Нанзад бөө болон түүний зан үйлийн талаар огт мэдэхгүй байсан. Бид Улаанбаатарг буцаж ирээд түүний талаар сонссон. Монголын нийслэл хотод тухайн үед түр хугацаанд байсан залуухан хотгойд бөөтэй уулзахад тэрээр Нанзадын тухай багшаасаа сонсоноо хэлсэн. Түүний хэлснээр, Нанзад Хөвсгөл нутгаасаа явж нийслэл хотод ойрхон суурьшсан тул хэн ч түүнийг танихгүй байсан. Тэрээр тайван амьдрахын тулд бөөгийн амьдралын зам мөрөө орхисон. 1960 онд Ринчен гуай түүнийг Унгарын судлаачтай танилцуулахын тулд яаж олсон бэ гэдэг асуулт гарч ирнэ. Энэ нь монгол судлаачийн улс төрийн хэлмэгдүүлэлтэнд хэрхэн нөлөөлсөн байж болох вэ. Харамсалтай нь, Диосегигийн Хөвсгөлд хийсэн хоёр дахь хээрийн судалгааны тэмдэглэлд энэ тухай мэдээлэл дутмаг учир бид бүх үйл явдлыг үнэн зөвөөр сэргээж чадахгүй байна. Нанзад бөөгийн талаар цуглуулсан бичлэг Унгар руу явсан нь тодорхой бөгөөд Татар Магдолна сүүлд тэдгээрийг боловсруулах үүргийг хүлээсэн. Гэхдээ өнөөг хүртэл энэхүү аяллын талаар нарийвчилсан тайлан гараагүй байгаа тул бид Диосегигийн цуглуулсан бөөгийн бичвэрүүдийг дахин нягталж үзэхээс гадна Нанзад зааринтай холбоотой мэдээллийг нэмэлтээр цуглуулж, тухайн хувь хүн болон Диосегигийн хийсэн судалгааг үр дүнгүй замхруулах ёсгүй. Учир нь түүний гүйцэтгэсэн судалгаа нь уламжлалт соёлын чухал гэрч байхыг үгүйсгэхгүй. Өнөөгийн хотгойдын бөө

нар шинэ үед нэмж сурсан, “орчин үеийн” болон уламжлалт зан үйлийн журмыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь бидний ажигласнаар зарим үед эртний уламжлалтай холбоотой хорио цээрийг үл тоомсорлодгоос гадна янз бүрийн угсаатны (дархад, хотгойд, буриад, ойрд) бүлгүүдийн хуучны зан үйл холилдсон байх магадлалтай.

Эдгээртэй танилцах, Диосегигийн хийсэн судалгаа болон өнөөдрийн туршлагаудын хоорондын уялдаа холбоог судлахад анхаарал хандуулах шаардлагатай юм.

Диосегигийн судалгааны өнөөгийн үр нөлөө

Диосегигийн цуглуулсан материал төдийгүй Унгарын угсаатан судлаачийн Монголд хийсэн хээрийн судалгаа нь Угсаатан судлалын судалгаанд нөлөөлсөн гэдгийг бид өмнө нь онцолсон. Түүний үйл ажиллагааг тухайн үеийн судлаачид сонирхоод зогсохгүй өнөөгийн Монголын угсаатны зүйч, антропологичдод чухал сургамж болдог. Мэргэжлийн судлаачид төдийгүй бөөгийн уламжлал, нүүдэлчдийн уламжлалт соёлыг сонирхогчид ч үүнд анхаарлаа хандуулж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Тийм ч учраас одоо түүнтэй холбоотой хэд хэдэн нэвтрүүлэг гарч байгаа бөгөөд энэ нь Диосегигийн цуглуулсан материалыг өнөөгийн мэргэжлийн судлаачид болон энгийн үзэгчдэд толилуулах зорилготой юм.

Энэхүү нийтлэлийн эхэнд бид 2023 оны 11 дүгээр сарын сүүлчээр Чингис хаан Үндэсний музейд нээгдсэн үзэсгэлэнгийн талаар дурдсан. Унгарын

Угсаатны зүйн судлаачийн 1960 онд Монголын хөдөөгийн өдөр тутмын амьдралын хэв маягийг харуулсан 120 гэрэл зургийг эндээс болон холбогдох каталогоос олон нийт үзэх боломжтой.

Унгарын Угсаатны зүйн музейн цуглуулгад Диосегигийн үлдээсэн 800 орчим гэрэл зураг нэмэгджээ. Үзэсгэлэнгээс гадна бидний төлөвлөгөөнд угсаатны зүйн гэрэл зургуудыг багтаасан илүү чухал цуглуулгын каталогийг бий болгох болно. Энэ талаар холбогдох байгууллагуултай хэлэлцээ хийгдэж байна. Төсөл хэрэгжинэ гэж найдаж байна! Үүнийг бид ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Чингис хааны Үндэсний музейтэй хамтран 2024 онд гаргахаар төлөвлөж байна.

Унгарын Угсаатны зүйн музейд Диосегигийн цуглуулсан бөөгийн уламжлалтай холбоотой эд зүйлсийг толилуулж буй *Sámánkatálogus* (Wilhelm 2016) номыг Монголд хэвлүүлсэн нь үүнээс хавьгүй илүү дэвшилтэт зүйл юм. Унгарын Үндэсний музей, Чингис хааны Үндэсний музей хоорондын хамтын ажиллагааны хүрээнд уг каталогийн монгол орчуулгыг хэвлэхээр болжээ.

Цаашид институциудын хоорондын судалгааны хамтын ажиллагаа хэрэгжинэ гэж найдаж байна. Одоогоор бид тэдгээрийн загварыг гаргахаар ажиллаж байна.

Ашигласан материал:

Diószegi Vilmos 1954. A honfoglaló magyar nép hitvilága (ösvállásunk) kutatásának módszertani kérdései. *Ethnographia* 65. évf. 1-2. 20-68.

Dömötör Tekla 1973. Néphitkutatás és őstörténet (Diószegi Vilmos emlékére) *Létünk*. 4-5. (szeptember-október.) 63–66.

Morvay Judit 1998. Utószó. In Diószegi Vilmos: *Sámánizmus*. Szerk. Sántha István Terebess Kiadó, Budapest. 105-118.

Ortutay Gyula. 2010. *Napló 3. 1967-1977*. Alexandra Kiadó, Pécs.

Sántha István 2003 “Hangalov gyűjtőfüzeteiből (1909)” [From the Diaries of *M.N. Xangalov*, the Buryat Ethnographer (1909)]. *Népi kultúra – Népi társadalom*. Akadémiai kiadó, Budapest, 273-300.

Sántha István 2010. Diószegi Vilmos néprajzi expedíciói Dél-Szibériában és Észak-Mongóliában (1957-1964). In: Bali János – Bati Anikó – Kiss Réka (szerk.): *Inde aurum – inde vinum- inde salutem Paládi-Kovács Attila 70. születésnapjára*. ELTE BTK Tárgyi Néprajz Tanszék – MTA Néprajzi Kutatóintézet Budapest 2010: 527-539.

Somfai Kara Dávid 2002 Dél-

szibériai törökök. Diószegi nyomában Szibéria földjén In: *Halkuló sámánobok, Diószegi Vilmos szibériai naplói, levelei*. (szerk. Sántha István). Documentatio Ethnographica 18. L'Harmattan: Budapest. 455-466.

Somfai Kara Dávid 2007 Bulagatburját fisámánfi szövegek Saraksinova és Diószegi Gyűjtéséből. In: *Ethno-Lore*. (szerk. Hoppál Mihály – Vargyas Gábor – Berta Péter). Budapest: MTA Néprajzi Kutatóintézetének. 545-560.

Somfai Kara Dávid 2011 Tuva sámánok énekei, Diószegi Vilmos kéziratok hagyatéka (2.). In: *Ethno-lore* 28. Budapest: MTA Néprajzi Kutatóintézet. 205-234.

Wilhelm Gábor 2004. Diószegi Vilmos munkássága és az összehasonlító etnológiai módszertan. *Néprajzi értesítő*. L.XXXVI. Évf. 49-67.

Wilhelm Gábor (szerk.): *Sámántárgyak. A Néprajzi Múzeum tárgykatalógusai 23*. Néprajzi Múzeum, 20

СҮХБААТАР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ЭРТНИЙ ТАМГА ТЭМДГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Д.Амараа

СУИС-ийн Урлаг судлалын докторант

Товчлол

Дорнод Монгол бүс нутаг тэр дундаа Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт буй хүн чулуу, хадны зураг, бичээс, тамга, тэмдгийн дурсгалууд нь эртний Хүннү, Түрэг, Уйгар, Татар, Кидан зэрэг нүүдэлчин овог аймгуудын угсаа гарал, түүх соёлыг тодруулахад чухал эх сурвалж болох бөгөөд утга агуулга, цар хүрээгээр монгол орны төдийгүй бүс нутгийн хэмжээнд томоохонд тооцогдох чухал үнэ цэнтэй өв дурсгал юм. Тус аймгийн нутагт буй зарим томоохон дурсгалт газрын археологийн судалгаа харьцангуй хожуу хийгдэж эхэлсэн бөгөөд одоогоор Донгойн ширээгийн цогцолборын судалгааны ном (2017), Их мандал, Жаргалантын адгийн ширээ, Таван толгойн бичээсийн талаар судлаачдын өгүүлэл хэвлэгдэн судалгааны эргэлтэнд орсон бөгөөд бусад дурсгалын утга хамаарал, гарвал үүсэл, он цагийг тодруулахаар судалгааны ажил хийгдсээр байгаа билээ. Одоогийн байдлаар 6 сумын нутагт Түвшинширээ-1, Баяндэлгэр-2, Эрдэнэцагаан-3, Онгон-1, Наран-2, Асгат-1 нийт 10 газар (хад чулуун дээр-8, гэрэлт хөшөөт цогцолбор-1, хүн чулуу-1) тамга дүрс сийлсэн дурсгал байгаагаас 2022 онд шинээр илэрсэн Таван толгойн бичээсээс бусад дурсгалууд Сүхбаатар аймгийн соёлын өвийн бүртгэлд оржээ. Энэхүү бичвэр эрдэмтэд судлаачдын судалгаа

шинжилгээнд нэмэр болно хэмээн итгэж байна.

Түлхүүр үг: Дорнод Монгол, Донгойн ширээ, Таван толгой, Хөндлөн хавцал, Рашаан тээг, Жаргалантын адгийн ширээ, Мандалын хад, Бударын чулуу, Ганзай хад, Хүннү тамга, хүн чулуу

Судлагдсан байдал


Сүхбаатар аймгийн хэмжээнд одоогоор илэрч олдоод байгаа эртний тамга тэмдэг, бичээсийн судалгааны анхны эхлэл нь 1927 онд ЗХУ-ын шинжээч В.А.Казакевич Дорнод Монголын нутгаар хэл шинжлэл, угсаатны зүйн судалгаа хийх явцдаа “I.Намогильные статуи в Дариганге II. Поездка в Дарьгангу” нэртэй судалгааны ном хэвлүүлсэн бөгөөд Дарьганга дахь хадны хятад бичээсийг анх судлан тэмдэглэж өгүүлэл нийтлүүлжээ. [Казакевич 1933:151-160]. 1957, 1958 оны үед Улсын төв музейн судалгааны ангийн археологич Д.Наваан Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Устай бургастай, Молцог элс зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн үед холбогдох олдворууд, Наран сумын нутгаас “Бичигт цагаан хад нэртэй чулуун дээрх олон тооны бичээс дурсгалыг шинээр илрүүлсэн тухай “Эртний мөр” [Наваан 1960] номондоо бичсэн байна. Түүхч Г.Сүхбаатар Дарьгангад хэрэглэж байгаа малын тамганы

судалгаа хийж “Об имах и тамгах табунов Даригангы” [Сүхбаатар 1960] ном хэвлүүлжээ. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс тус улсын эртний түүхийн газрын зураг зохиох ажлын хүрээнд археологич Н.Сэр-Оджавын ахалсан хээрийн шинжилгээний анги 1961 онд Сүхбаатар аймгийн хэдэн сумдын нутгаар явахдаа дээрх дурсгалуудыг үзэж хуулга авсан тухай тайландаа тусгасан. [Н.Сэр-Оджав 1963:11]. Доктор Л.Жамсран гуай дээрх хоёр бичээсийг 1977 оноос судалж, XV, XVII зуунд холбогдох дурсгал хэмээн тайлж уншин өөрийн бүтээлдээ нийтэлсэн байна. [Жамсран 1994:63]. Археологич Д.Баярын удирдсан ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги 1981 онд Сүхбаатар аймгийн нутагт судалгаа хийхдээ Эрдэнэцагаан сумын нутаг Хөндлөн хавцал, Дөрвөлжин тээг зэрэг газраас чулуун дээр сийлсэн тамганы дүрслэл бүхий дурсгал илрүүлэн тодорхойлолт бичиж, гэрэл зургаар баримтжуулан тайландаа хавсаргажээ. [Монголын археологи 2016:311-312]. Эрдэнэцагаан сумын Жаргалантын адгийн ширээ хэмээх газар буй хадны зургийн дурсгалыг Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд Соёлын өвийн төвийн судлаачид 2008 онд үзэж судлан 2011 онд товхимол хэвлүүлсэн байна. [Энхбат, Даваацэрэн, 2011:73]. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн доктор Ц.Төрбат, Н.Батболд нарын судлаачид 2016 онд Жаргалантын адгийн ширээ, Рашаан тээгийн хадны дурсгалыг дахин судалжээ. [Монголын археологи 2016:361]. Түвшинширээ сумын нутаг Донгойн ширээн дурсгалыг анх 2010 онд МУИС-ийн Археологи, антропологи тэнхимийн

профессор Д.Түмэнгийн ахалсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги хайгуул хийх явцдаа олон хөшөө, цэцэг хээ дүрсэлсэн хавтан бүхий цогцолбор дурсгалыг илрүүлсэн тухайгаа тэмдэглэсэн байдаг. [Түмэн нар 2010:169]. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаач, доктор Ц.Болорбатын удирдсан хайгуулын баг 2011 онд Дэлгэрхаан уулын хавьд хайгуул хийх үедээ уг дурсгалын хөшөөнд эртний түрэг бичээс буйг илрүүлсэн юм. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги 2013 онд хоёр удаа уг дурсгалт газарт малтлага судалгаа хийсэн байна. [Болорбат нар 2014:95-99]. Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хүрээнд 2015-2016 онд “Донгойн ширээ”-ний цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулах, гэрэлт хөшөөдийг бүртгэн баримтжуулах, эртний бичээс болон тамганы хэв хуулга авах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. [Цогтбаатар нар, 2017:228-234]. Баяндэлгэр сумын Их Мандал уулын археологийн судалгааг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн доктор Я.Цэрэндагва, судлаач С.Далантай нар 2006-2008 оны хооронд тус газраас чулуун зэвсгийн дурсгал, олон арван тамга тэмдгийн дүрслэл, хадны зураг зэргийг шинээр илрүүлэн бүртгэн баримтжуулсан бөгөөд судалгааны ажил өнөөг хүртэл хийгдэж байна. [Сүхбаатарчуудын өв соёл. 2019:34-40]. Сүхбаатар аймгийн Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн Б.Золхүү, археологич А.Болортунгалаг нар 2018 онд Соёлын өвийн тооллого хийх явцдаа Онгон сумын Бударын чулууны хадан дээр зосон болон

сийлмэл зураг, тамга дүрслэл, 2020 онд Наран сумын нутаг Ганзай хад, Агуйт зэрэг газраас мөн адил дүрслэлтэй дурсгал шинээр нээж илрүүлэн тус аймгийн соёлын өвөөр бүртгэн баримтжуулжээ. 2021 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн доктор Н.Батболд нар дээрх бүртгэл мэдээллийн мөрөөр Бударын чулуунд ажиллаж, дурсгалуудыг бүртгэн баримтжуулж, шинээр нэмж хэд хэдэн хадны зураг илрүүлжээ. [Батболд нар, 2021:136-137] Баяндэлгэр сумын Таван толгой хэмээх газраас хаданд сийлсэн руни бичиг, тамга тэмдэг бүхий шинэ дурсгалыг Д.Амараа 2022 оны 5-р сард хээрийн

судалгаа хийх үедээ баримтжуулсан бөгөөд доктор Р.Мөнхтулга, Монголын Үндэсний түүхийн музейн мэргэжилтэн Г.Бүрэнтөгс нарын хамт судалгааны өгүүлэл болгон хэвлүүлсэн байна. [Нүүдэлчдийн өв судлал 2022:35] Соёлын өвийг хамгаалах үндэсний төвийн Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаагийн ахалсан тус газрын мэргэжилтнүүд 2019 онд Эрдэнэцагаан сумын Жаргалантын адгийн ширээ, 2022 онд Хөндлөн хавцал зэрэг газар байгаа эх дурсгалуудаас цаасан болон уян хэв, хуулга авах, 3D хэмжээсээр скайнердах ажлыг хийж гүйцэтгэжээ.



Зураг-1. Сүхбаатар аймгийн нутагт буй тамга тэмдэг дүрслэсэн дурсгалт газрууд (Д.Амараа. 2022)

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Сүхбаатар аймгийн хэмжээнд эртний бичээс, тамга тэмдгийн дүрслэл илэрч олдсон 10 дурсгалт газар байгаагаас харьцангуй сайн судлагдсан дурсгал бол Түвшинширээ сумын нутаг Донгойн ширээд буй гэрэлт хөшөөт цогцолбор юм. 2013 онд ШУА-ийн Археологийн

хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги уг дурсгалт газарт хоёр удаа гүймэг малтлага судалгаа хийж, хөшөө чулууны 20 гаруй хугархайг илрүүлэн, зарим хөшөөний цаасан хэв хуулгыг авч, судлаач Р.Мөнхтулга, Т.Осава нар зарим хөшөөний бичээсийг цаасан хэвэнд тулгуурлан урьдчилсан байдлаар

уншиж, 72 мөр, 3857 үсэг, 1193 үг, 86 орчим тамга байгааг тодруулан, “орд гэр минь ээ”, “ноён минь ээ”, “нутаг минь ээ” гэх үгсийн олон давтан бичсэн болохыг тайлжээ. Хамгийн өндөр нь болох 7-р хөшөө нь 6.4 м бөгөөд тус хөшөөний суурь гэх зүйл илрээгүй байна. Нийт 14 гэрэлт хөшөөнд руни бичээс, 11 хөшөөнд тамга, 2 хөшөөнд хятаны бага бичээстэй (хар бэх болон сийлмэл). 11 хөшөөнд нүдээр ил үзэгдэх 17 төрлийн (дан болон үүсмэл) 79 тамга тодорхой мэдэгдэх бөгөөд зурмал дугуй (онги), гурвалжин (дором), дөрвөлжин, янгир, саран тамгыг хамгийн олон дүрсэлсэн. Өөр хэд хэдэн хөшөөнд уг тамганы салбар тамга мөн сийлэгджээ. Нэг хөшөөнд 1-17 хүртэлх тамга сийлэхдээ голчлон хөшөөний дунд хэсэгт дүрслэх боловч дээд, доод хэсэгт дүрслэх тохиолдол ч байна. [Цогтбаатар нар, 2017:228-234].

Баяндэлгэр сумын нутаг Таван толгой, Их мандал уулнаас тус тус тамга тэмдэг сийлсэн дурсгал илэрч судалгааны эргэлтэнд оржээ. Таван толгой хэмээх жижиг ухаагийн оройд буй хадны баруун хажуу талд руни бичээс, тамга, зүүн талд нь янгир тамга сийлсэн байна. Бичээсийн дээд хэсэгт нар толгойтой могой тамга, урд зүгт хандуулсан янгир тамга, түүний дээр гурвалжин тамга сийлсэн бол бичээсийг тойруулан янгир, могой тамганы олон хувилбарыг зураасаар хүрээлэн сийлж дүрсэлсэн байна. Энэхүү газар нийт 20 орчим тамга дүрслэгдсэн гэж судлаачид үзжээ. [Мөнхтулга 2022:48]. Тус сумын төвөөс зүүн зүгт 17 км зайтай Их мандал уулын өвөр болон хойд талд голын сайр дагасан өндөр хад асга бүхий тогтоцтой газруудад сийлмэл зураг, тамга дүрслэсэн таван газар байгаа бөгөөд одоогоор судалгааны

эргэлтэнд орсон хоёр хэсэг хаданд бөөн байдлаар сийлсэн 30 орчим тамга байна. [Далантай. 2019:34-40]. Хадны урд нүүрэн талын босоо хэсэгт янгир, онги, холбоо онги, зарим тамга нь олон давтамжтайгаар дүрслэгджээ. Голдоо хэрээстэй онгин тамга 4, дан, холбоотой онгин тамга 10 гаран байна.

Онгон сумын Бударын чулуу хэмээх боржин чулуун өвөрмөц тогтоцтой хад цохио бүхий газар баялаг өгүүлэмж, хүүрнэлтэй зосон болон сийлмэл зураг арвин бий. Энд буй тамганууд нь хадны орой хэсэгт байгаа бөгөөд дүрслэл нь зөв эргэсэн хас, дээрээ сартай, чагттай онгин тамга, хоёр тийш харсан саран, дээрээ босоо хоёр зураастай саран, доош харсан чойндон зэрэг 10 орчим тамга олдоод байна. [Батболд нар, 2021:136-137]. Наран сумын нутагт Агуйт, Ганзай хаданд хүн, мал дүрсэлсэн цөөн тооны сийлмэл зурагтай хамт онги, чагтан тамга дүрслэгджээ.

Эрдэнэцагаан сумын нутагт Хөндлөн хавцал, Рашаан тээг, Жаргалантын адгийн ширээ зэрэг гурван газарт хад чулуун дээр сийлсэн тамганы дүрслэл илэрч олдоод байна.

Рашаан тээг. Эрдэнэцагаан сумын төвөөс хойш 80 км зайтай Гашууны хөндийд голын хойд дэвсгэг дээр чулуун овооны зүүн талд хар хөх өнгөтэй 14 ширхэг том, жижиг хүрмэн чулуу сул таруу байдалтай хэвтүүлсэн байна. Эдгээрийн гурван чулуун дээр тамга дүрсэлсэн. Энэхүү газар гурван хэсэг чулуун дээр нийт 17 орчим тамга дүрслэгджээ.

1-р чулуу. Сул хэвтэх 110x75см чулууны хавтгай дээд хэсэгт зураасаар хөвөөлж хүрээлэх аргаар олон тамга сийлсэнээс 9 тамга дүрс тодорхой

мэдэгдэх бөгөөд бусад дүрслэл нь баларсан байна.

2-р чулуу. Газар зоолттой намхан чулуун дээр дугуй онги болон 4 тамга зэрэгцүүлсэн бөгөөд дүрслэл нь нэлээн бүдгэрчээ.

















3-р чулуу. Сул байх бөөрөнхий хэлбэртэй чулуун дээр маш чухалд тооцогдох 4 тамга сийлсэн ба дүрслэл сайтай нэг тамганы дээд хэсэг хагарсан эсвэл дутуу сийлсэн нь тодорхойгүй.

Хөндлөн хавцал. Зотол хан уулаас баруун хойш 8км орчим баруун урдаасаа зүүн хойш сунаж тогтсон хад чулуутай амыг Хөндлөн хавцал гэнэ. Худгийн урд талд хавтгай том чулуун дээр цөөн тооны тамга дүрс сийлсэн байна. Том хавтгай чулууны (210x140, Д.Баярын хэмжээс) хүрээтэй чагт (30x30см), чагт (30x30см), нэлээн бүдгэрсэн янгир болон доод хэсэгт гурван тийш харсан саран тамга (25x23см) сийлжээ. /Зур-3/ Энэ дурсгалаас холгүй хаданд гурван бөөрөнхий дүрсийг хооронд нь шулуун урт зураасаар холбосон чөдөр тамга сийлсэн нь бүдгэрсэн мөн хоёр тийш эргэсэн хагас дугуй дүрс байна.

Жаргалантын адгийн ширээ. Монголын археологийн судалгаанд чухал ач холбогдолтой цогцолбор дурсгал бол Эрдэнэцагаан сумын төвөөс зүүн хойш 45км зайтай Жаргалантын адгийн ширээ хэмээх баруунаас зүүн тийш сунаж тогтсон урт ширээгийн хойш харсан хэсэгт бүлэг хаданд хүний нүүр, мал, ан амьтны олон арван сийлмэл дүрс урласан байдаг.

Энэхүү газар 26 хадан дээр зуу илүү дүрс тэмдгийг баримтжуулж авсан байна. [Төрбат нар, 2017:238]. Уг газар байгаа адууны зурагтай (унагагай гүү) хадны дээд хэсэгт тамга дүрс бий. Мөн 2008 оны соёлын өвийн тооллогоор тус аймгийн музейн мэргэжилтнүүд судалгааны ажлаар явж байхдаа дээш харсан хадан дээр том хэмжээтэй хас тамга сийлсэн байхыг үзэж, гэрэл зургаар баримтжуулсан гэх боловч одоогоор тэр зураг олдоогүй байна.

Алаг морьтын хүн чулуу. Асгат сумын нутаг Алагморьтод буй хүн чулууг анх 1984 онд археологич Д. Баяр үзэж, ямар цаг үед холбогдохыг тодорхойлох бэрхшээлтэй гээд гар зураг зурахдаа тамга дүрсийг нь анзаараагүй байна. Мөн тэрээр уг хүн чулуу БНУАУ-ын жуулчин Рона Ташийн номонд дурдагдсан хүн чулуу мөн бололтой хэмээн бичжээ. [Монголын археологи. 2016:148]. Уг хүн чулууны баруун хажуу талын тамга дүрсийг доктор Г.Энхбат, Б.Даваацэрэн нар 2011 онд “Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал” товхимолдоо гэрэл зураг, гар зургийн хамт хэвлэсэн байна. [Энхбат нар, 2011:32]. Буган хөшөөтөй төстэй зөвхөн нүүр дүрсэлсэн босоо гонзгой энэхүү хүн чулууны баруун хажуу талд сийлсэн тамга нь урт, богино хоёр ташуу зураасыг холбосон шулуун зураас нь үзүүртээ бөөрөнхий дүрстэй. 2019 онд тус сумын Соёлын төвийн мэргэжилтнүүд хадгалж хамгаалах зорилгоор энэхүү хүн чулууг зөөж, Асгат сумын төвд байрлуулжээ.

№	Сумын нэр	Дурсгалт газар	Онги, Чагт тамга	Бусад тамганууд
1	Түвшинширээ	Донгойн ширээ		
2	Баяндэлгэр	Их Мандал уул		
3	Баяндэлгэр	Таван толгой		
4	Эрдэнэцагаан	Хөндлөн хавцал	 +	
5	Эрдэнэцагаан	Рашаан тээг		
6	Эрдэнэцагаан	Жаргалантын адгийн ширээ		
7	Онгон	Бударын чулуу	 	
8	Наран	Ганзай хад	+	
9	Наран	Агуйт хад	 	
10	Асгат сум	Алаг морьтын Хүн чулуу		

Зураг-2. Сүхбаатар аймгийн нутаг дахь
тамга тэмдгийн ангилсан байдал (Д.Амараа. 2022)

Урласан арга барил

Дээрх тамга дүрслэлтэй дурсгалт газрууд нь тус аймгийн урд талын сумдын нутгаар ихэвчлэн тархсан бөгөөд нэрийн тухайд тамгатай холбоотой нэр байхгүй, тухайн дурсгал оршин байгаа уул, хад чулуу, хавцал зэрэг газрын нэрээр нэрлэгдэж байна.

Их мандал, Хөндлөн хавцал, Рашаантын тээгийн дурсгалууд нь

зөвхөн тамга тэмдэг дагнаж дүрсэлсэн бол бусад дурсгалууд руни бичээс, хүн, ан амьтан хамт сийлжээ. Чулууны сонголтын хувьд байгалийн хэлбэр төрхөөрөө байгаа ургаа хадан дээр дүрслэх тохиромжтой босоо тэгш хавтгай хэсгийг сонгон урладаг (Бударын чулуу, Агуйт, Ганзай, Их мандал, Жаргалантын адгийн ширээ) бол Хөндлөн хавцал, Рашаантын тээгийн тамга тэмдгийг сул хавтгай чулууг

сонгон сийлсэн сонирхолтой. Таван толгойн бичээс, тамгыг хадны дээш харсан гадаргууг сонгон дүрсэлснийг дэргэдээс нь үзэх боломжтой юм. Түрэг, Уйгарын язгууртны тахилын онгоны уламжлалыг тусгасан Донгойн ширээн дурсгалын “хөшөө чулуудыг магадгүй орон нутгийн гаралтай хэд хэдэн төрлийн боржин чулуу ашиглан хийсэн ба гол төлөв хажуу ирмэгийг нь мөлийлгөн зассан гонзгой, зууван эсвэл 3-4 талт хэлбэртэй ажээ.” [Цогтбаатар нар, 2017:229]. 14 гэрэлт хөшөө бүтээхэд (хамгийн өндөр нь 6,4м) бичээс, тамга сийлэх, чулуу бэлтгэх байрлуулах зэрэг олон хүний хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулах нь ойлгомжтой. “Донгойн ширээ цогцолборын гэрэлт хөшөөнд голлон язгууртны тамгыг дээд хэсэгт томоор дүрслэхийн хамт бичээсний хажуугаар бусад жижиг тамгуудыг дээрээс нь доош цувуулан сийлсэн. [Мөнхтулга нар, 2022:37]. Өнөөг хүртэл энэ дурсгалтай адил олон аварга том хөшөөтэй цогцолбор Монгол улсын нутгаас олдоогүй бөгөөд Эртний Түрэгийн үеийн гэрэлт хөшөөдөөс хамгийн зүүн талынх нь энхүү дурсгал болж байна [Болорбат нар, 2014:95-99] хэмээн судлаачид үзжээ.

Судалгаанд хамрагдсан дээрх тамганууд ихэнх нь энгийн (чагт, онги, саран, сэрээ) дүрслэл өгүүлэмжтэй бүтээгдсэн бол Таван толгой, Рашаан тээг, Донгойн ширээгийн дурсгалууд (могой тамганы олон хувилбар, янгир) олон төрлийн нарийн дүрслэл, утга агуулга шингээн урлажээ. Тамгуудыг сийлсэн арга барил нь дүрсийг хүрээлж цааш ховилдох, чулууны гадаргууг нийт талбайгаар нь өнгөц цохих аргуудаар бүтээсэн бөгөөд хамгийн гүн сийлсэн тамга нь Таван толгойн янгир тамга зарим хэсгээрээ 0,5мм гүн, 1см

өргөнтэй сийлсэн нь тод томруун ялгарч харагддаг. Хөндлөн хавцалын чагт, хүрээтэй чагт, саран, янгир тамганууд (30x30см) болон Бударын чулууны тамганууд мөн ойролцоо хэмжээтэй бол бусад дурсгалууд харилцан адилгүй янз бүрийн хэмжээтэй байна.

Он цаг ба харьцуулалт

Донгойн ширээд Түрэг, Уйгар, Татар, Кидан зэрэг олон овог аймгийн түүх соёлыг хадгалсан сийлмэл, бэхэн бичээс, тамга зэрэгцэн байгаа бөгөөд судлаачид “руни бичгийн үсэг зүй, хэлзүйн онцлог, тамгын хэлбэр, хавтангийн дүрслэл зэрэгт үндэслэн уг дурсгалыг 735-745 оны үед эртний Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ихэс язгууртанд зориулан байгуулсан хэмээн урьдчилсан байдлаар үздэг.” [Цогтбаатар нар, 2017:230]. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаач Г.Батболд “Донгойн ширээгийн дурсгал нь Татар аймгийн дурсгал мөн байна. Түрэгийн хаант улсын төгсгөл үед татарын холбоо хүчирхэгжиж байсны илрэл хэмээн үзэж байна. Тиймээс Татарууд нутгийн зүүн бүсэд өөрсдийн төр улсын уламжлалыг аймгийн холбооны хүрээнд хадгалж, өөрсдийн онцлогтой дурсгалууд үйлдэж байжээ” гэсэн дүгнэлт хийжээ. “Мөн нас барсан ихэс язгууртанд зориулсан уг тахилын онгоныг байгуулах ёслолд оролцохоор ирсэн овог аймгийн язгууртнууд хөшөөнд тамгаа сийлсэн бололтой.” [Болорбат нар, 2014:95-99]. Баяндэлгэр сумын Таван толгойн дурсгалд дүрслэгдсэн тамга нь Түрэг, Уйгар, Тунра аймагт хамаарах бөгөөд он цагийн хувьд “Донгойн ширээгийн дурсгалтай ойролцоо буюу VIII зууны сүүл үе 790 оны 5-р сард бичсэн байж

болох юм” [Мөнхтулга 2022:48] гэсэн бол Их мандал уулын дурсгалыг VII-VIII зууны овог аймгийн 30 орчим тамга бий гэж судлаач С.Далантай тодорхойлжээ. [Далантай.2019:34-40]. Бударын чулууны зосон болон сийлмэл зургуудын он цагийг судлаачид хожуу хүрэл-түрүү төмрийн үед хамааруулж үздэг бол “Жаргалантын адгийн хадны сийлмэл зургуудыг шинэ чулуун зэвсгийн үеэс зэс буюу энеолитын үед холбогдох магадлалтай юм.” [Төрбат 2017:62-69]. Дээрх хоёр газарт байгаа тамга тэмдгүүдийг сийлсэн арга барил, хэмжээ болон бусад бүс нутгийн ижил төстэй тамгануудтай харьцуулан үзэж он цагийг судлаж тогтоох боломжтой. Хөндлөн хавцалын гурван тийш харсан саран тамга Татар аймгийн тамга (Түрэг, Уйгарын үе) гэж судлаачид үздэг бөгөөд Түвшинширээ сумын Донгойн ширээ, Баянхонгор аймгийн Өлзийт сумын Хийдийн гэзэг болон өөр 10 гаран газар олон янз хувилбараар сийлэгдсэн байдаг ажээ. Онги, чагтан тамга нь Дорнод Монголын нутагт нэлээн түгээмэл тархсан бөгөөд хил залгаа ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Сөнөд зүүн хошууны нутагт ижил дурсгалууд байгаа билээ.

Хүн чулуун дурсгал дээр тамга дүрс үсэг байх нь тун ховор тохиолдол юм. Асгат сумын Алагтморьтын хүн чулууны тамганы он цагийг одоогоор харьцуулсан ямар нэгэн судлаачийн дүгнэлт гараагүй байна. Тамга дүрслэл бүхий хүн чулуун дурсгалууд бол Түрэгийн үед холбогдох Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг Талын хөшөөний хүн чулуу [Мөнхтулга 2019:31-34] хөндлөн зураастай онги, хажуу тийш харсан сэрээ тамга сийлжээ. Мөн Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутаг Хөтөл усны


хүн чулуу нүүрэн талдаа онги, хос угалз тамга тэмдэг дүрсэлсэн бөгөөд Хожуу Түрэг, Уйгарын хаант улсын үед холбогдох магадлалтай гэж судлаачид үзсэн байна. [Болдбаатар нар, 2022:92-97]. Монголын үеийн (XIII-XIV) хүн чулуунд дурсгал болох Төв аймгийн Хүүхэн хонгор уулын хүн чулууны ар хэсэгт исэр суудал дээр “бундан тамга” дүрслэлийг доктор Ч.Эрдэнэбаатар судалж илрүүлсэн юм. Тэрээр “энэхүү бундан тамга нь Монголын эзэнт гүрний нэг улс болох Цагаадайн эзэнт улсын тамга буюу Цагаадай хааны удмын тамга болох юм” [Эрдэнэбаатар 2011:228] гэжээ. Говьсүмбэр аймгийн Оцол сансар уулаас 1930 оны үед анх Улаанбаатар хотод зөөж авчирсан Чойрын хүн чулуу (XII-XVIII) нь эртний Түрэгийн руни бичээс, хоёр тамга дүрсэлсэн хосгүй ховор дурсгал юм.

Хөндлөн хавцалын дурсгалыг археологич Д.Баяр 1981 онд үзэхдээ авсан фото зурагт байхгүй дүрсүүдийг нэмж сийлсэн үү эсвэл маш бүдэг байсныг тодруулсан уу гэдэг нь тодорхойгүй гурван дүрслэл байна. Өмнө сийлсэн тамгануудаас зохиомж, өгүүлэмж, хэмжээ, гүйцэтгэл зэргээс харахад өөр байгаа нь сүүлд нэмсэн байх магадлалтай юм. (Зураг-3)

Тамга нь эртний овог аймгуудын гарал үүсэл, нүүдэл шилжилтийг судлахад чухал ач холбогдол бүхий хэрэглэгдэхүүн болно [Сэр-Оджав.1963:20] хэмээн дурдсан бол доктор Р.Мөнхтулга Таван толгойн (Баяндэлгэр) бичээсийг Хэрлэний хөндийгөөс Донгойн Ширээгээр дайран Ордос улмаар Тан улсын нийслэл Чанань орох зам дагуу үлдээсэн “замын бичиг” [Мөнхтулга нар, 2022:48] гэж

үзсэн нь доктор Л.Жамсран гуайн Дарьганга бол Ар, өвөр монголын зааг үүд гатлага нутаг гэсэнтэй нийцэж байна. Энэ бүс нутгаар эртнээс худалдаа наймаа, аян дайны гол зам дайран өнгөрдөг байсныг гэрчлэх түүх

хадгалсан дээрх бичээсүүд болон XV, XVII зуунд бичигдсэн Сөдөт, (Наран) Тосонгийн хятад бичээс (Баяндэлгэр) зэрэг тод мөр үлдээсэн дурсгал олон бий.



Зураг-3. Археологич Д.Баярын 1981 онд авсан гэрэл зурагтай 2022 онд авсан зургийг харьцуулсан байдал. (Д.Амараа)

Онцлох дүрслэл

Тус бүс нутагт байгаа онцлог дүрслэлтэй дурсгал бол Рашаан тээг дэх 17 орчим тамга, гурван хэсэг хэвтээ чулуун дээр сийлж үлдээсэн нь анхаарал татна. (Зураг-5) Доктор Д.Баяр 1981оны судалгааны тайланд “Дөрвөлжин тээг” нэрээр оруулсан нь Гашууны хөндийгөөс залгаад зүүн тийш Дөрвөлжин хөндий үргэлжилдэг учир тийнхүү нэрлэсэн бололтой. 2017 онд доктор Ц.Төрбат нар “Жаргалантын адгийн ширээ, Рашааны тээг ба Чулуут голд хийсэн хадны зургийн судалгаа” илтгэлдээ энэхүү дурсгалын тухай товч дурдсан байдаг. [Төрбат нар, 2017:238]. Монголын нэрт газарзүйч О.Намнандорж гуай 1958 оны 8 сарын 18-нд энэхүү Гашууны рашааныг судалж, анх удаа рашааны хими, физикийн найрлага, газар зүйн онцлогийг тодорхойлж, 1966 онд

хэвлүүлсэн БНМАУ-ын “Рашаан” номондоо бичжээ. Тэрээр уг тамгатай чулуунуудыг үзэж тэмдэглээгүй нь сонирхолтой юм. Рашаан тээгийн тамгат чулуудыг үзээд монголчуудын дээд өвөг болох Хүннү нарын язгууртан ургийн тамга гэж судлаачид үзжээ. (Зураг-7) “Үүнтэй ижилсэх тамга тэмдгүүд Говь-Алтай аймгийн Цагаан гол, Ховд аймгийн Ямаан ус ба Харгайтын бэлчир зэрэг газрын хаднаа сийлэгдсэн байхаас гадна Ноён уул, Гол Модны Хүннүгийн хад язгууртны бунханаас гардаг билээ. Түүгээр зогсохгүй Төв аймгийн Тэрэлжийн дөрвөлжингийн дээврийн нүүр ваар, Буриадын Дөрөөгийн суурин, Хятадын Шэньси мужийн Дабаодангийн булш зэргээс илэрсэн нь бүгд Хүннүгийн хад язгууртантай холбоотой юм. Судлаачид эдгээр бүх тамга тэмдгийг Хүннүгийн хаан ураг болох люаньди буюу Сюйляньти овгийн

тамга гэдэгт эргэлзээгүй итгэж байна.”
[Төрбат нар, 2017:237].

У Ү Жаргалантын адгийн ширээгийн буйлан тамгатай адил төстэй дурсгалууд Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын хаданд Ү ширээтэй буйлан тамга [Сүхбаатар 2016:78] сийлсэн бол Ноён уулын зарим булшнаас гарсан шавар ваар савын ёроолд тус тус тамга илэрсэн байна. Мөн Хакасын Абакан хотын орчим орших “Ли Линий ордон” гэгддэг Хүннүгийн үеийн барилгын малтлагаас зарим барилгын хэрэглэгдэхүүн дээрээс Ү зэрэг тамга илэрсэн байна. Дээрх тамга тэмдгүүд нь Хань улсын бичиг үсэгт байдаггүй тэмдгүүд тул Хүннүд хамаарагдах нь дамжиггүй юм хэмээн эрдэмтэн Ц.Доржсүрэн үзжээ.” [Төрбат нар, 2012:138] Энэхүү буйлан тамганаас эх авсан үүсмэл тамганы тухай “Өмнөд Сибирийн Кызыл Чира гэдэг газар байдаг хоёр хөшөөнд байгаа тамгануудыг эрдэмтэн Л.Р.Кизласов шинжлээд Учир-Кулюг-Тириг-ийн хүү нь Арслан-Кулыг Тириг, түүний хүү Кулюг-Тоган болох нь яах аргагүй зөв гээд Ү-Ү-Ү тамгаар хөөж үзвэл ийм байна гэжээ.” [Сэр-Оджав 1963:19] Уг гурван тамганы өөрчлөлтөөс (зураас, чихтэй онги) харахад ураг овгийн тамгаа өвлөн уламжлахдаа дүрс нэмж баяжуулан шинэ үүсмэл тамга болгон хэрэглэж байсан нь харагдана.

Утга бэлгэдэл ба зохиомж

Тамга нь ямар нэгэн зүйлээс санаа сэдэл авч бэлгэдэл, утга агуулгаар баяжуулан товч тодорхой, оновчтой шийдлээр илэрхийлсэн бүтээл юм. Эртний овог аймаг, удам угсааны бэлгэ тэмдэг болох тамганууд нь олон зууны

дамжин уламжлагдан оюун санаа, сүр хүчний бэлгэдэл болон шүтэгдэж, их хүчийг өөртөө оршоосон дүрс болж хувирсан байдаг.

Сүхбаатар аймгийн нутагт хад чулуунд дүрслэгдсэн эртний тамганы дүрслэлийн он цаг хоорондын уялдаа хамаарлыг тодруулахад археологийн малтлага судалгаанаас илэрч олдсон тамга тэмдэг бүхий эд хэрэглэгдэхүүн болон тухайн бүс нутагт хэрэглэдэг малын тамгатай харьцуулан үзэх нь хэдийгээр он цагийн хувьд зөрүүтэй боловч тамганы нэр, үүсэл гарвалыг судлахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгаанд хамрагдсан Бударын чулуу, Агуйт, Рашаан тээг зэрэг газарт онги, холбоо онги болон түүнээс салбарласан үүсмэл тамга дүрс голдуу сийлэгдсэн байгаа нь анхаарал татаж байна.

Дарьгангачуудын дунд одоо ч “Онгин тойргоо ойсон” гэдэг үг хэлэгддэг бөгөөд Сүхбаатар Ү аймгийн Асгат, Халзан, Дарьганга, Баяндэлгэр, Онгон сумдын малчдын хэрэглэдэг малын тамганд 14 төрлийн онгин тамга байгаа бөгөөд үүнээс Ө ширээтэй онги, холбоо онги, Ө хөндөлтэй хоёр онги гэсэн тамганууд судлагдаж буй тамгануудтай адил төстэй юм. [Сүхбаатар 1960:22]. Чингис хаан Хорезмыг эзэлсний дараа 1221 онд Самаркандад “Энэ бол Чингис хааны мөнгө” гэсэн бичээстэй мөнгөн зоос гаргаж, түүн дээрээ “ширээтэй Ү онги” сийлсэн байдаг. Чингис хааны овгийн тамга ширээтэй онгин тамга байсан бол Монголын эзэнт гүрний гурав дахь их хаан Гүег хааны мөнгөн зоосны (1206- Ө 1249) нүүрэн талд холбоо онгин тамга дүрслэгдсэн ажээ.

Ширээтэй онги, холбоо онги тамгыг ихэвчлэн босоо байдлаар сийлснийг Их мандалын хадны зургаас тодорхой харж болно. Манай орны нутгаас илэрч олоод байгаа Хүннүгийн язгууртны арав гаран тамганы дүрслэлээс харахад зохиомжийн төв буюу голох дүрс нь онгин тамга болж байна.  Эдгээр тамгануудын тэмдгийн үндсэн хэлбэр элементийг хадгалсан Рашаантын тээг дэх  тамганы үндсэн зохиомж нь дээрх Дарьгангын хөндөлтэй хоёр онги, ширээтэй гал тамганы нэгтгэсэн хувилбар байж болох юм. Энэ дүрсийг дахиад хураангуйлбал ташуу зураастай онги (загасан) тамганы дүрсэнд багтаж байна. (Зураг-6) Рашаан тээгийн жижгэвтэр чулуунд 4 тамга зэрэгцүүлэн дүрсэлснийг ажиглахад тамганы үүсэл, хувьсал харагдах ажээ. Хонх хэлбэрийн тамгыг түүний доод талд байгаа голдоо хөндлөн зураастай онгин тамгатай нийлүүлж үзвэл дээд хэсэгт зурагдсан тамганы үндсэн бүрдэл хэсэг болжээ.

Төгсгөл

Дорнод Монгол, зүүн өмнөд бүс нутгаас Донгойн ширээн томоохон гэрэлт хөшөө бүхий цогцолбор мөн Хүннүгийн хаад язгууртны ургийн тамга тэмдэг илэрсэн нь эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтойгоос гадна цаашид уг цогцолбор дурсгалуудын бичээсийг бүрэн тайлах, тамга тэмдгийг тухайн бүс нутгаас шинээр илэрсэн ижил төрлийн дурсгалуудыг харьцуулан судлах, гэрэлт хөшөөдийг хадгалж хамгаалах, эх байдлаар нь сэргээн засварлаж босгох, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой. Эдгээр дурсгалууд анхны хэв төрхөөрөө уг газраа хадгалагдаж байгаа нь нутаг орны иргэд түүх


соёлын үнэт өв дурсгалаараа бахархах, эрдэмтэд судлаачид тухайн газар орчинд нь судалгаа шинжилгээ хийхэд ач холбогдол оршино. Байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал чулууны насжилт, цууралт, хаганд идэгдсэн байдал зэрэг муугаар нөлөөлөх, сул байдалтай байгаа чулуун дурсгал нь хүн малын хөлөөр хөдөлж зөөгдөх, хагарах, эрсдэл үүсгэжээ. Иймээс дээрх дурсгалуудын хадгалалтын эмзэг байдал зэргийг харгалзан үзэж анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Ашигласан материал


- Ч.Амартүвшин (ред) Монголын археологи: хээрийн судалгааны тайлан. III (1979-1983) Улаанбаатар. 2016.
- Н.Батболд, Г.Галдан “Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) суурь судалгааны төслийн 2021 оны хээрийн судалгааны товч үр дүн” Монголын археологи-2021. Улаанбаатар. 2021.
- Ю.Болдбаатар, Г.Анхсанаа “Хөтөл уснаас олдсон тамгатай хүн чулуун хөшөө” Түрэг, Уйгар судлал III. Улаанбаатар. 2022
- Ц.Болорбат, Р.Мөнхтулга “Донгойн ширээний гэрэлт хөшөө бүхий дурсгалыг илрүүлэн судалсан нь”. Монголын археологи-2013. Улаанбаатар. 2014
- С.Далантай “Их мандал хайрханы археологийн дурсгалын тухай” Сүхбаатарчуудын өв соёл. Улаанбаатар. 2019.
- Л.Жамсран “Дарьгангын сүрэг хошуу” Улаанбаатар. 1994.

- Казакевич.В.А. Записки института Востоковедения. Ленинград. 1933.
- Казакевич.В.А. I.Намогильные статуи в Дариганге. II.Поездкав Даригангу. Ленинград. 1930.
- Р.Мөнхтулга, Д.Амараа, Г.Бүрэнтөгс “Таван толгойн руни бичээс” Нүүдэлчдийн өв судлал. Улаанбаатар. 2022.
- Р.Мөнхтулга, Г.Бүрэнтөгс, Г.Арьяажав “Талын хөшөөний тахилын онгон” УБ., 2019.
- Д.Наваан “Эртний мөр” Улаанбаатар. 1960.
- Г.Сүхбаатар “Об имах и тамгах табунов Даригангы” Улаанбаатар. 1960.
- Н.Сэр-Оджав “1961оны хээрийн шинжилгээний хэрэглэгдэхүүн” Улаанбаатар. 1963.
- Н.Сэр-Оджав “Эртний судлал” Улаанбаатар. 1963.
- Д.Сүхбаатар “Дэл уулын хадны зураг” Улаанбаатар. 2016.
- Ц.Төрбат “Дорнод Монголд нээгдсэн Жаргалантын адгийн хадны зураг” Төв Ази ба умард Хятадын хадны зураг” Улаанбаатар. 2017.
- Ц.Төрбат, Д.Батсүх, Н. Баярхүү “Хүннүгийн археологийн тамгууд Люаньди овгийн тамга болох нь” Археологи судлал. Tomus XXXII. Улаанбаатар. 2012.
- Ц.Төрбат, Н.Батболд, Д.Батсүх “Жаргалантын адгийн ширээ, Рашааны тээг ба Чулуут голд хийсэн хадны зургийн судалгаа. Монголын археологи-2016” Улаанбаатар. 2016.
- Б.Цогтбаатар нар, “Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн 2016 оны малтлага судалгааны шинэ үр дүнгээс” Монголын археологи-2016. Улаанбаатар. 2016.
- Д.Эрдэнэбаатар, С.Чулуун “Төв халхын нутгаар хийсэн археологийн судалгаа” Нүүдэлчдийн өв судлал. Tomus XI. Улаанбаатар. 2011.
- Г.Энхбат, Б.Даваацэрэн “Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал” II дэвтэр Сүхбаатар аймаг. Улаанбаатар. 2011.


Хавсралт зураг-1



Зураг-5. Рашаан тээгийн тамга дүрслэл.
(Д.Амараа. 2022)




Зураг-6. Рашаан тээгийн тамганы хувьсал үүсэл. (Д.Амараа. 2022)




1. Рашаан тээгийн тамга (Д.Амараа 2022)
2. Говь-Алтай аймгийн Цээл сумын Цагаан голын тамга (Н.Сэр-Оджав 1963)
- 3.5.7. Ховд аймгийн Алтай сумын Ямаан усны хавцлын тамга (Төрбат нар, 2012)
4. Ноён уулын 31-р булшнаас гарсан аяганд сийлсэн тамга (Төрбат нар, 2012)
6. Ховд аймгийн Үенч сумын Дүнд Жаргалантын хадны тамга (Төрбат нар, 2012)

Зураг-7. Монгол нутгаас олдсон Хүннүгийн язгууртны тамга дүрслэлийг харьцуулсан байдал


Хавралт зураг-2



Зураг-8. 1. Алаг морьтын хүн чулуу. Сүхбаатар аймаг. Асгат сум
 2. Чойрын хүн чулуу. Чингис хааны музей.
 3. Хүүхэн хонгор уулын хүн чулуу. Төв аймаг. Баянцагаан сум
 4. Талын хөшөө. Хэнтий аймаг. Бор-Өндөр
 5. Хөтөл усны хүн чулуу. Баянхонгор аймаг. Бууцагаан сум



Зураг-9. Дарьгангын малын тамга. (Г.Сүхбаатар. 1960)



Зураг-10. Говь-Алтай аймгийн Цээл, Наран сумын хооронд орших Цагаан голын хадны тамганы зураг (Н.Сэр-Оджав. 1963)